ЭНЕРЖИ РЕСУРС ХХК
Сэнтрал Тауэр 16 давхар, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200 УБД: 9011007001
Утас: (976) 70122279, 70132279
contact@mmc.mn, www.energyresources.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Х.ОТГОНМӨНХ ТАНАА

2025.10.31 № 765

танай ______ -ны № ______ -т

Тайлан хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худаг төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлж байна.

Уг тайланг БОАЖС-н 2019 оны А/618-р тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.1-р заалтын дагуу БОУАӨЯ-ны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлангийн мэдээллийн санд 10-р сарын 31 -ний өдөр илгээж, байршуулсан болно.

БОМТ-ний биелэлтийн тайланг илгээж, хүргүүлсэнтэй холбогдуулан ажлын хэсгийг томилон ажиллуулж, холбогдох дүгнэлтийг гарган өгч бидний ажилд дэмжлэг үзүүлж өгнө үү.

Хавсралт 128 хуудастай.

Хүндэтгэсэн

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ С.ЛХАГВА-ОЧИР

# УХАА ХУДАГ ТӨСӨЛ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН “УХАА ХУДАГ” ОРДОД MV-011952 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР : **MV-011952**
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : **2887746**

**Хянасан:**

БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ын
ахлах шинжээч ______________________________ Ц. Жаргалнэмэх

**Хэрэгжилтийг гаргасан:**

“Энержи ресурс” ХХК-ийн
БОХАБЭА Нийцэл хариуцсан захирлын
үүрэг гүйцэтгэгч______________________________ Д. Батбаяр

“Энержи ресурс” ХХК-ийн
Байгаль орчны ахлах менежер ______________________________ П. Батболд

2025 ОН

# Агуулга

**1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 3**
**1.1 Ухаа худаг нүүрсний уурхай ... 4**
**1.2 Нүүрс баяжуулах үйлдвэр ... 4**
**1.3. Дулааны цахилгаан станц ... 6**
**1.4. Ус хангамж ... 7**
**1.5. Уурхайн ажиллагсдын хотхон ... 8**
**1.6. Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн авто зам ... 8**
**1.7. Цагаан Хад Нүүрс ачиж буулгах талбай ... 8**
**1.8 Шатахуун түгээх станц ... 9**

**2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ... 10**

**3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН ... 12**

**4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 13**
**4.1. Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 13**
**4.2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 24**
**4.3. Цахилгаан станцын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 29**
**4.4. Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 36**
**4.5. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үеийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ ... 45**

**5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 49**
**5.1. Хаягдлын овоолгын талбайг налуулж хэлбэршүүлэлт хийх ... 50**
**5.2. Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих ... 50**
**5.3. Шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах, усалгаа арчилгаа хийх ... 51**
**5.4. Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нэмэгдүүлэх чиглэлд ногоон байгууламж үүсгэж ургамлан хашлага хийх ... 52**
**5.5. Цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах ... 52**
**5.6. Цогтцэций сумын хашаатай айл өрхөд тарьц суулгац олгож амьдарч буй орчноо ногооруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ... 54**

**6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 54**
**6.1 Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх ... 55**
**6.2 Говийн ховор нэн ховор амьтан ургамлын зүйлийг хамгаалах ... 55**
**6.3 Байгалийн тооройн бүлгэмдлийг хашиж хамгаалах ... 56**
**6.4. Хууль бус ан, тэдгээрийн гаралтай эд, эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх" төсөлд дэмжлэг үзүүлэх ... 57**

**7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 58**

**8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 58**

**9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 59**
**9.1 Химийн бодисын хадгалалтын хяналт ... 62**
**9.2 Хийн алдагдал илрүүлэгч автомат төхөөрөмжийг суурилуулах ... 62**

**9.3 Химийн хорт болон аюултай бодисын ослын үед ажиллах төлөвлөгөөний дагуух практик сургалт хийх** ........ 62
**9.4 Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах** ........ 63
**9.5 Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг сургалтанд хамруулах** ........ 63
**9.6 Гамшгийн эмзэг байдал эрсдэлийн үнэлгээ хийлгэх** ........ 64
**9.7 Уурхайн галын насос станцыг шинэчлэх** ........ 65
**9.8 Гамшиг, галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох66**
**9.9 Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийх** ........ 66
**9.10. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээлэх** ........ 67

**10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ 68
**10.1. Хуванцар хог хаягдлыг ангилан ялгалт** ........ 71
**10.2. Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох** ........ 71
**10.3 Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх** ........ 72
**10.4 Хаягдал дугуйг эрх бүхий байгууллагад шилжүүлэх** ........ 73
**10.5 Хог хаягдлын устгалын ландфилл байгуулах** ........ 73
**10.6 Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх** ........ 74
**10.7 Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх** ........ 75
**10.8 Аюултай хог хаягдал болох аккумляторыг нийлүүлэгч болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх** ........ 76
**10.9 Аюулын зэрэглэл нь “X” тэмдэглэгээтэй буюу хяналттай хог хаяглууд дээр шинжилгээ хийлгэж, аюулын зэрэглэлийг тодорхойлох** ........ 77
**10.10 E- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийх** ........ 77

**11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ 79
**11.1. Байгаль орчны дотоод хяналт** ........ 81
**11.2. Ус ашигласны төлбөр** ........ 81
**11.3. Байгаль орчны аудит** ........ 83
**11.4. Байгаль орчны тэмдэглэлт өдөр** ........ 83
**11.5. Нийт ажилтнуудын байгаль хамгаалах чиглэлээрх сургалт** ........ 86
**11.6. Байгаль орчны ажилтнуудыг чадавхжуулах сургалт** ........ 86
**11.7. Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагын хяналт** ........ 90
**11.8. Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ISO:14064 стандартыг нэвтрүүлэх** ........ 90
**11.9. Булгийн эх хаших хамгаалах** ........ 91
**11.10. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ТЭЗҮ** ........ 92

**12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ** ........ 93
**12.1. Гадаргын ба газрын доорх усны хяналт шинжилгээ** ........ 93
**12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ** ........ 101
**12.3 Хөрсний судалгаа** ........ 110
**12.4 Ургамал, амьтны аймгийн судалгаа** ........ 114

**13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ 122

**14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ** . 128

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, бизнест тодорхой хувь нэмэр оруулах, нэн ялангуяа нүүрс, нүүрсэн химийн бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр дэлхийн зах зээлд баттай байр сууръ эзлэх эрхэм зорилготойгоор “Энержи Ресурс” ХХК нь 2005 оны 4-р сарын 22-нд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь “Ухаа худаг” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худаг коксжих нүүрсний ордыг 2009 оноос олборлож эхэлсэн нь коксжсон нүүрсний зорилтот зах зээлд хүргэхэд томоохон алхам болсон. “Энержи Ресурс” ХХК нь өндөр хөгжилтэй орнуудад мөрддөг олон улсын стандартыг эх орондоо нэвтрүүлж, бодит ажил хэрэг болгон хариуцлагатай уул уурхайн жишиг тогтоохыг зорьж, Монгол улсад өрнөж буй их бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Тус компани нь Ухаа худаг төслийн хүрээнд явагдаж байгаа бүхий л үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартыг даган мөрдөж, төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилготойгоор ажилладаг. “Энержи Ресурс” компани нь 2007 онд Ухаа Худагийн ордын ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмших болсноор ордыг ашиглах ТЭЗҮ, Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ зэргийг боловсруулан батлуулж, 2008 оны 10 сараас ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнийн дагуу уулын бэлтгэл ажлыг эхлүүлсэн ба 2009 оны 4 сард улсын комисс Ухаа Худагийн уурхайг байнгын ашиглалтанд хүлээж авснаар хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн.
2025 оны 10-р сарын 30-ны гүйцэтгэлээр **9,213,443** тонн нүүрс олборлосон байна.

11952А тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицолууд

| Дугаар | X | У |
|---|---|---|
| 11952A - 4 | 4835630.651 | 536106.290 |
| 11952A - 1 | 4839519.390 | 536085.354 |
| 11952A - 2 | 4839364.841 | 543699.684 |
| 11952A - 3 | 4835676.639 | 543725.328 |

“Энержи Ресурс” компани нь Монгол улсын хөгжил дэвшил, үйлвэржилт, шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулах, “Ухаа Худаг” нүүрсний ордыг цогц байдлаар ашиглах зорилтын хүрээнд уурхайн нүүрс олборлолтын үйл ажиллагаатай зэрэгцүүлэн жилд 15 сая нүүрс хүлээн авч баяжуулах үйлдвэр, 18 МВт конденсатын цахилгаан станц, хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр, уурхайн ажиллагсдын “Галлерей кемп”, гүний ус олборлох худаг, ус цэнгэгжүүлэх байгууламж, Ухаа худаг-Гашуун сухайтын чиглэлийн 245 км хатуу хучилттай зам, 5000 хүн ам оршин суух “Цэций” хороолол орон сууц, хоногт 1200м$^3$ ус цэвэршүүлэх цэвэрлэх байгууламж болон бусад ахуйн барилгыг барьж ашиглалтанд оруулсан.

## 1.1 Ухаа худаг нүүрсний уурхай

"Энержи Ресурс" ХХК нь уурхайн олборлолтын чиглэлээр ашигт малтмалын эрэл хайгуул, нөөцийн үнэлгээ, уурхайн урт, дунд болон богино хугацааны төлөвлөлт, ISO, GB, MNS стандарт шаардлагуудыг хангасан нүүрсний чанарын бүрэн хэмжээний судалгаа, уул уурхайн хүнд машин механизмын засвар үйлчилгээ, ашигт малтмалын олборлолт зэрэг 10 гаруй чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Ордын нүүрсний тогтоцоос хамааран нүүрсний хаягдал бохирдлын хэмжээг багасгах зорилгоор нүүрс олборлолтын доголууд дээр Hitachi1200 болон Liebherr 9250 урвуу хутгуурт гидравлик экскаваторуудболон уурхайн дотоод тээвэрлэлтэнд Caterpillar фирмийн автосамосвалуудыг ашигладаг. Уурхай 12 цагийн 2 ээлжээр, 24 цагийн турш ажилладаг бөгөөд үйл ажиллагаа хэвийн үед 700 орчим хүн ажилладаг.



Зураг 10.1. *Нүүрсний уурхай*

## 1.2 Нүүрс баяжуулах үйлдвэр

Ухаа Худаг төслийн хүрээнд жилд тус бүр 5 сая тонн нүүрс угааж, боловсруулах хүчин чадалтай 3 модуль бүхий Нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ) Австралийн Седжмен компанийн зураг төслөөр баригдсанаас эхний модулийг 2011 оны 6-р сард, 2-р модулийг 2012 оны эхний хагаст ашиглалтанд оруулж жилдээ 10 сая тонн нүүрс хүлээн авч баяжуулсан ба 3-р модулийг 2013 оны 7 сард оруулснаар жилийн хүчин чадал 15 сая тонн болж өргөжсөн. 2025 оны 10-р сарын 30-ны байдлаар 7,061,263 тонн коксжсон нүүрс боловсруулсан байна.



Зураг 1.2. *Нүүрс баяжуулах үйлдвэр*




Зураг 1.3. *Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем*

### 1.2.1. НБҮ-ийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгүйжүүлэх ажиллагаанд шинэ техник технологийг ашиглан байгаль орчинд ээлтэй нөхцлөөр шийдвэрлэхээр Нүүрс баяжуулах үйлдвэрийн Хаягдлыг усгүйжүүлэх байгууламжийг барьж байгуулан 2013 оны 12-р сард ашиглалтанд оруулсан.

Уг байгууламж нь баяжуулах үйлдвэрийн хаягдлыг усгүйжүүлж, гарсан усны 67%-85%-ийг эргүүлэн ашиглахад зориулагдсан үйлдвэр юм. Үйлдвэрт 8 ширхэг усгүйжүүлэх төхөөрөмжийг суурилуулсан ба нэг төхөөрөмж нь цагт 75.3 м3 хаягдлыг базаж 65 м3 шүүгдсэн ус, 21 тн хуурай хаягдал болгон ялгана. Шүүгдсэн усыг технологийн шугаманд эргүүлэн ашигладаг.




Зураг 1.4. *Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн технологийн схем*

## 1.3. Дулааны цахилгаан станц

"Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа худаг коксжих нүүрсний ордыг түшиглэн 18 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, 2011 оны 9 сарын 24-нд ашиглалтанд оруулсан. Тус станц нь уурхайн болон дэд бүтцийн төслүүдийн эрчим хүчний бүхий л хэрэгцээг хангахаас гадна төвийн эрчим хүчний системээс алслагдсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг цахилгаанаар найдвартай хангаж байна. Монголдоо анх удаа дотоодын чадварлаг инженерүүдийн ур ухаанаар боссон энэхүү цахилгаан станц говь нутгийн байгалийн онцлогт нэн тохиромжтой хуурай хөргөлтийн систем, шаталтын үр дүнд үүссэн байгаль орчинд хортой үнсийг цахилгаан ионжих аргаар ялгах цахилгаан фильтер, усны бага хэрэглээ гээд технологийн олон давуу талыг агуулсан тул одоогоор Монголд ажиллаж буй бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэх боломжтой. Дулаан цахилгаан станц нь 2025 оны 10 сарын 30-ны байдлаар 90,706,860 кВт. цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн байна.



Зураг 1.5. *Цахилгаан станц*




Зураг 1.6. *Дулааны цахилгаан станцын технологийн схем*

## 1.4. Ус хангамж

Ухаа Худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг бий болгох ажил 2008 оны 1-р сараас эхэлж улмаар 2011 оны 6-р сард ашиглалтанд орсон. Ингэхдээ цэвэр усны нөөцөөр хомс говь нутгийн онцлогийг дээд зэргээр харгалзсан, усыг 100 хүртэлх хувь дахин ашиглах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологид суурилсан болно.

Уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангаж буй ус хангамжийн систем нь 56,000 куб метрийн багтаамжтай усан сан, насос станц болон иж бүрэн автомат хяналтын систем гээд технологийн онцлог шийдэл бүхий хэсгүүдээс бүрдэл болдог.

2025 оны 10 сарын 30-ны байдлаар 1,514,608 $м^3$ ус үйлдвэрлэлд ашигласан байна.

### 1.4.1. Ус хангамжийн систем

Одоогийн байдлаар Наймантын хотгорын болон Наймдайн хөндийн гэсэн хоёр үндсэн ус хангамжийн системийг байгуулснаас Наймантын хотгорын ус хангамжийн системийг ашиглаж байна.




Зураг 1.7. *Ус хангамжийн ерөнхий схем зураг*

### 1.4.2. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууламжууд

Тус компани нь нийгмийн хариуцлагатай уул уурхайн төслийн хүрээнд өөрийн ажиллагсад төдийгүй Цогтцэций сумын иргэдийг стандартын шаардлагад нийцсэн ундны цэвэр усаар хангадаг бөгөөд хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг шийдвэрлэсэн болно. Энэ зорилгоор дараах байгууламжуудыг барьж байгуулан, ашиглаж байна. Үүнд:

**Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж**

- Хүчин чадал: 750 м3/хоног
- Ус цэнгэгжүүлэх байгууламж нь Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажилчдын хотхоныг цэвэршүүлсэн усаар хангах зорилгоор байгуулагдсан.
- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг Герман улсын Prominent компанид үйлдвэрлэсэн бөгөөд мембран шүүлтүүр бүхий урвуу осмосын зарчмаар ажилладаг.
- Байгалийн усыг чөлөөт ионуудаас 97-98%-иар, бусад хольцноос 99% хүртэл цэвэрлэх боломжтой.

**Цогтцэций сум, Цэций хорооллын хэрэглээнээс гарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж**

- Хүчин чадал: 1200 м3/хоног
- Бүрэн автомат цэвэрлэх байгууламж ба 96 % хүртэл цэвэрлэх боломжтой.
- 35x20 м-ийн талбайтай аваарийн сан- 1ш, 35x20 м-ийн талбайтай лагийн сан 1ш, 1400 м3-ийн 4 ш шүүрүүлэх талбайтай.
- Чехийн SPR технологитой

### 1.5. Уурхайн ажиллагсдын хотхон

2013 оны 1 сард Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн, боловсролын орчин үеийн Мөрөөдөл нэртэй томоохон цогцолбор болох 640 хүүхдийн дунд сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр бүхий иж бүрэн байгууламж Өмнөговь аймгийн болон тус компанийн хөрөнгө оруулалтаар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд орон сууцны хороолол болон хашаатай бүрэн тохижуулсан ажилчдын гэр хорооллыг барьж байгуулсан. 2011 онд 377 айлын хашаа 2022 онд уурхайчин хорооллын өргөтгөл 165 айлын хашаа 2014 онд "Цэций" хороололд 480 айлын орон сууц ашиглалтанд орж, нийт 1022 айл өрх тус хороололд амьдарч байна.

### 1.6. Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн авто зам

"Энержи Ресурс" компани Ухаа Худаг – Гашуун сухайт чиглэлийн 245 км хатуу хучилттай замыг барьж байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2011 оны 10-р сард ашиглалтанд оруулсан. Хатуу хучилттай авто зам ашиглаж байгаа нь уурхайн тээвэрлэлтийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлснээс гадна хайрган хучилттай зам ашигласнаас үүдэлтэй тоосжилтыг эрс бууруулж, говь нутгийн байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад бодитой хувь нэмэр оруулж байна. Замыг Засгийн газрын 2013 оны 299-р тогтоолоор 2014 оны 02 сарын 14-өөс хойш төрийн өмчид шилжүүлсэн бөгөөд одоогоор энэхүү замын хувьцааны 40%-ийг төрийн өмчит "Эрдэнэс таван толгой" ХХК, 40%-ийг "Энержи Ресурс" ХХК, 20%-ийг Орон нутгийн өмчит "Таван толгой" ХХК тус тус эзэмшиж байгаа. Авто зам төрийн өмчид шилжсэнтэй холбоотойгоор замын менежмент, засвар үйлчилгээ, аюулгүй байдлын хяналт зэрэг асуудлыг "Гашуунсухайт автозам" ХХК хариуцан замын үйл ажиллагааны тогвортой байдлыг хангаж ажиллаж байна.



Зураг 1.8. *Хатуу хучилттай нүүрс тээврийн зам*

### 1.7. Цагаан Хад Нүүрс ачиж буулгах талбай

Нүүрс буулгах агуулах болон Гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт, Цагаан хад нэртэй газарт орших бөгөөд сумын төвөөс урагш 75км, Гашуун сухайтын хилийн боомтоос 20 гаруй км зайд байрлана. Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайд БНХАУлсад экспортлох нүүрсийг талбайгаас дахин ачиж хилийн шалган нэвтрүүлэх болон гаалийн хяналт-бүрдүүлэлт хийдэг. Энэ талбай нь нийт 37.4 га талбайг эзэлдэг. Нүүрс ачиж буулгах талбайн ажиллагсад, засварын газрын ажилчдын хотхонд 35 гэр, 3 контейнэр хаус бүхий кэмп, цахилгаан дулааны эх үүсвэрийн барилга, хоолны газар, ундны ус цэвэрлэх байгууламж, угаалга болон нийтийн халуун усны газар, авто гараж, шалган нэвтрүүлэх байр, спортын талбай зэргээс бүрддэг. Нүүрс ачиж буулгах талбайд нийт 4 дугуйт ачигч, усны 1 машин, 60 орчим хүн ажилласан.




Зураг 1.9. *Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбай*

**1.8 Шатахуун түгээх станц**

Шатахуун түгээх станцыг Ухаа худаг уурхайд ажиллаж буй техник хэрэгслийг түлшээр найдвартай хангах зорилгоор 2019 онд үйл ажиллагаандаа шилжүүлэн авсан. Шатахуун түгээх станц нь шатахуун далд нөөцлөх 50м3-н багтаамжтай 3, ил 24ш нөөцлөх сав болон тээврийн машин орж гарах, зам шатахуун буулгах хэрэгсэл, технологийн худгууд, хаягдлын сан, шатахуун буулгах талбай, шатахуун түгээгүүрүүд , шатахуун түгээх станцын ажилчдын амрах байр зэргээс бүрддэг.

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2019 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт “Энержи Ресурс” ХХК-аас гадна “Эрдэнэс Таван толгой” ХК, “Таван толгой” ХК зэрэг бусад аж ахуйн нэгжүүд нүүрсний уурхайн ба тэдгээрт туслах дэд бүтцийн төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Ухаа Худаг ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

**Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Гол сөрөг нөлөөллүүд:**

- Ил уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлох, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт PM10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх.
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины болон хөдөлгөөнт техникийн нөлөөгөөр тоосжилт үүсэх.
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан.
- Цахилгаан станц ба бага оврын халаалтын зуух, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий агаарт ялгарах.

**Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Нүүрс ачиж буулгах талбай дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалснаас нүүрс өөрөө халж шатан хүлэмжийн хий ялгаруулж агаарын чанарт нөлөөлөх.
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх.
- Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн хортой болон аюултай бодисуудын агуулах сав, шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх эсвэл байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт химийн бодис ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

**Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Төслийн үйл ажиллагаанд зориулан Наймантын хөндийн гүний ус олборлолтоос шалтгаалан гүний усны түвшин буурах.
- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Уурхайн хотхон болон ажилчдын кэмпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн хортой болон аюултай бодисуудын агуулах сав, шатахуун түгээх станцуудын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.
- Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан сангаас гүний усанд нэвчилт үүсч усны чанарт нөлөөлөх.
- Наймантын хөндийн гүний ус олборлолтоос шалтгаалан малчдын гар худгуудын усны түвшин буурах.

**Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.

- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.
- Наймантын хөндийн гүний ус олборлосноос шалтгаалан хөрсний чийгийн хэмжээ багасч хөрсний үржил шимт чанар муудах.

**Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс элэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх
- Наймантын хөндийн гүний ус олборлолтын улмаас хөрсний чийг багасч ургамлан бүрхэвч сийрэгжих.

**Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Нүүрс тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.
- Өндөр хүчдэл болон цахилгааны шугамын шувуу үргээгч эвдэрсэнээс шувуу цахилгаанд цохиулах.

# 3. УХАА ХУДАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Ухаа худагийн ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 19-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг баримталсан болно.
Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 3.1 *Байгаль орчны менежмент төлөвлөгөөд тусгагдсан ажлуудын хэрэгжилт*

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл | Төлөвлөсөн ажлын тоо | Гүйцэтгэсэн ажлын тоо | Гүйцэтгэл хүлээгдэж буй ажлын тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 45 | 45 | - |
| 2 | Нөхөн сэргээлт | 6 | 6 | - |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 4 | 3 | - |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох | 1 | 1 | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах | 1 | 0 | - |
| 6 | Осол эрсдэлийн менежмент | 10 | 10 | - |
| 7 | Хог хаягдлын менежмент | 10 | 9 | 1 |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 10 | 10 | - |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 17 | 18 | - |
| 10 | Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа | 6 | 6 | - |
| **Нийт** | | **110** | **109** | **1** |

2025 оны Ухаа худаг төслийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- Уурхайн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хаягдлын овоолгын 10га талбайг стандартын дагуу налуулж, хэлбэршүүлэн, 10 га талбайг шимт хөрсөөр бүрэн хучиж, 7 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.
- Тоорой бүлгэмдлийг хамгаалж, устаж болзошгүй модлог ургамлын тархалтыг хадгалах, ургалтын нөхцлийг сайжруулах,унаган төрхийг хамгаалахын тулд өмнөговь аймгийн номгон сумын нутаг "гуагийн тоорой" хэмээх тоорой бүхий ойн сангийн 477 м² талбайг төмөр торон хашаагаар хашиж хамгаалах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.
- 2025 оны 4-р сард нбү-ийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн өргөтгөлийг ашиглалтад оруулсан бөгөөд хүчин чадлыг 50 хувиар нэмэгдүүлсэн.
- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд шинэ хархорум хот ерөнхий төлөвлөлт, хамгаалалтын ойн зурвас байгуулах төлөвлөгөөний дагуу "энержи ресурс" ххк нь 12.000 шилмүүст мод 28.000 навчит модыг а5,а9 хувиарлагдсан 52 га талбай дээр нийт 40.000 ширхэг модыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн.
- Мөн хэнтий аймаг хэрлэн сумын нутаг өлзийт баг чандганы талд байрлах цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг 05-р сарын 10-наас 06-р сарын 18 хооронд 50.000 мянган ширхэг мод тарьж ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- "энержи ресурс ххк" нь хог хаягдлыг булшлах байгууламж ландфилл байгуулах ажлын хүрээнд er24/06 дугаар бүхий ажлын даалгаврын дагуу мэргэжлийн байгууллага болох "эн си си эс" ххк -аар эскиз зураг болон ажлын зургийг хийлгээд байна. Ерөнхий төлөвлөлтөөр 2025

онд талбай тэгшилгээний газар шорооны ажил, эхний ландфиллын үүр, ууршуулах цөөрөм, хашаа барих, гэрэлтүүлэг хийх, пүүний суурийг байрлуулах ажлуудыг хийхээр төлөвлөсөн ба барилга угсралтын ажлыг дуусгаж хог хүлээн авахад бэлэн байдлаар ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан. Энэхүү ажлыг 2026 оны төсөвт суулган хийхээр төлөвлөж байна.

- Говь шанхын уртын гурван дууг сэргээн таниулах зорилгоор “холч морь”, “өндрийн өвс”, “хурдан сайхан” дуунуудыг түүхийн хамт, клипжүүлэн централ тв-ийн монгол өв соёл нэвтрүүлэг болон олон нийтийн сүлжээнд байршуулсан.

## 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 4.1. Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 1 | Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтоос сэргийлэх зорилгоор | Ил уурхай | Ухаа худаг уурхайд зам талбайн тоосжилт дарах зориулалтаар 2025 оны 1-р сарын 1-нээс 10-р сарын 28-ыг хүртэл 591,937м3 тн усаар усалгаа хийсэн байна. | Үйлдвэр лэлийн зардалд багтсан | 30,000.0 $м^3$/сар |
| 2 | Уурхайн технологийн зам шинээр тавих болон түүний засвар үйлчилгээнд тоосжилт бага үүсгэдэг материалыг сонгож ашиглах | Ил уурхай | Тоосжилт бууруулах ажлын хүрээнд 291,271$м^3$ материалаар уурхайн технологийн тээврийн замд засвар, үйлчилгээ хийж, олборлолтын явцад гарсан замын материалыг дахин ашиглах зорилгоор 7,202 $м^3$ нөөц бүрдүүлэн хадгалсан. | Үйлдвэр лэлийн зардалд багтсан | 25,000.0 $м^3$/жил |
| 3 | Хүйтний улиралд тоосжилт бууруулах арга хэмжээ зохион байгуулах | Ил уурхай | Өвлийн улиралд тоосжилт бууруулах ажлын хүрээнд 2025 оны 2 дугаар сарын 8 болон 22-нд давстай усаар цацах туршилтын ажлыг хоёр удаа гүйцэтгэлээ. Туршилтын үр дүнд үндэслэж өвлийн улиралд хуваарийн дагуу давстай усалгаа тогтмол хийхээр төлөвлөн ажиллаж байна. | 27,000.0 | 1 удаа 1-3сард |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Авто зам ашиглалтын үед үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор материал дэвсэж замын нөхцлийг сайжруулах | Баруун наран-Ухаа худаг чиглэлийн нүүрс тээврийн технологийн зам | Баруун наран уурхайн нүүрс тээвэрлэх технологийн замыг 2-8 дугаар сарын хооронд 1.9 км урттай хэсэгт шинэ чиглэлд шилжүүлэн байгуулсан. Өмнөх замын хэсэгт геотехникийн хувьд тогтворжилтын эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тул хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, уурхайн хэвийн ажиллагааг найдвартай үргэлжлүүлэх зорилгоор замыг шороон сайжруулсан хэлбэрээр шинэ чиглэлд шилжүүлэн | Үйл ажиллагааны зардлаас | 1.96 км |
| Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 5 | Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах | Цэвэрлэх байгууламж | Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллаж 2025 оны 10 сарын байдлаар 25-ны байдлаар **129,623**м$^3$ бохир усыг цэвэршүүлсэн. | Үйлдвэрлэлийн зардлаас | 300.0 м$^3$/хоног |
| 6 | Цэвэрлэх байгууламжаар усыг цэнгэгжүүлж унд ахуйн хэрэгцээний усаар хангах | Унды ус цэнгэгжүүлэх байгууламж | Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж нь Галлерей кемп, Цэций хороолол, Уурхайчин хороолол болон Сумын цэвэр усны хэрэглээг хангаж ажиллаж байна. 2025 оны 10 сарын 10-ны байдлаар **153,014**м$^3$ ус цэнгэгжүүлэн ахуйн цэвэр усны хэрэглээнд нийлүүлсэн | Үйлдвэрлэлийн зардлаас | 400.0 м$^3$/хоног |
| 7 | Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах | Ухаа худаг ус хангамж | Усны газараас 2025 оны 01 дүгээр сарын 30-нд Е-2501-000069 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж авсан. Мөн Галба Өөш Долоодын Говийн сав газрын захиргааны даргын 2023 оны А/06 тушаалаар ус ашиглах зөвшөөрлийг гаргуулсан бөгөөд сав газрын захиргаатай 2025 оны 04-р сарын 08-ны өдөр 2025/02 тоот ус ашиглах | Үйл ажиллагааны зардлаас | Ус ашиглах дүгнэлт гаргуулсан, гэрээ байгуулсан байх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Хаягдал усны гэрээ байгуулж биелэлтийг хангаан, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах. | Ухаа худаг ус хангамж | Төслийн хүрээнд “УБТТ” хуулийн дагуу УХУХ ХХК дээр **163,614.5** $м^3$/жил , ЭР ХХК дээр **1,072,989,33** $м^3$/жил бохир усыг хүрээлэн буй орчинд стандартын дагуу нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээний дагуу төлбөрийг тухай бүрт төлж байна. | Үйл ажиллага аны зардлаас | Хаягдал усны гэрээ байгуулж сар бүр төлбөрийг цаг тухай бүрт төлсөн байх |
| Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 9 | Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих. | Хаягдлын овоолго | Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлттэй холбогдуулан “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу 695,835 $м^3$ хөрсийг хуулж овоолго үүсгэсэн байна. | Үйлдвэрл элийн зардлаас | Шимт хөрсний хуулалт ба хадгалалт стандарт хангасан байх |
| 10 | Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд олборлолт хийх | Ил уурхай | Ухаа худаг уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөлтөөр нийт 10.0 сая тонн нүүрс олборлохоор батлуулсан ба 2025 оны 10-р сарын 27-ны байдлаар **9,124,725** тонн нүүрс | Үйл ажиллага аны зардлаас | Сар бүр |
| 11 | MV-011952 тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайгаас тусгай зөвшөөрөлгүйгээ р түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, | Ил уурхай | Төслийн үйл ажиллагаанд зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан тохиолдол гараагүй бөгөөд үйлдвэрлэлийн бүсэд томоохон барилга байгууламж шинээр баригдаагүй. | Үйл ажиллага аны зардлаас | Сар бүр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж мод, сөөг үржүүлж бойжуулах | Мод үржүүлэг туршилт судалгааны талбай | Ухаа худаг уурхайн мод үржүүлгийн талбай дээр говийн бүс нутагт тархан ургадаг Жигд, Сухай, Хайлаас, Тоорой, Заг, Харгана, Бүйлс, Хармаг, Хотир зэрэг мод болон орон нутгийн бутлаг ургамлыг үр болон мөчирөөр нийт 35,000 ш тарьж ургуулан мөн мод үржүүлгийн талбайгаас орчны тохижилт ногоон байгууламж,нөхөн сэргээлтэнд 14,965 ш тарьц суулгацыг бэлтгэн нийлүүлсэн байна. | 27.000.0 | 30.000 |
| Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 13 | Хөрс ургамал бохирдуулахаас сэргийлж ажилчад зориулж ариун цэврийн блок хийж | Тээвэр логистик | Шинээр 3ш 40 тн контайнерийг ариун цэврийн блокоор тоноглож холбогдох инженерийн шугам сүлжээнд холболт хийж гүйцэтгэсэн | Үйл ажиллага аны зардлаас | 1ш ариун цэврийн блок байршуулсан байх |
| 14 | Уурхайн орчмын ногоон байгууламжийн нөхөн тарилтыг зохион байгуулах | Ил уурхай | Нөхөн тарилтаар Улиас, Сухай, Жигд, Хайлаас зэрэг 2825 ш мод тарьж ургуулан намрын модны амьдралтын хувь 85%-аас дээш үзүүлэлттэй байна. | 13,000.0 | 4333 мод тарьсан байх |
| 15 | Уулын туруутан амьтдад зориулс ан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх | Хангинах уул | Билгэх багийн Тугийн цохио, Хөх овоонд ашигт долооц тавих ажлыг 2025 оны 03-р сарын 4-ний өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэй хоёр байршилд нийт 8 хайрцаг буюу 24 ширхэг ашигт долооцыг туруутан амьтдын хэвтэр газарт тараан байршуулсан. зохион зохион байгуулсан. Тугийн цохио орчимд уулын туруутан амьтад ажиглагдаагүй бөгөөд ойр орчмын айлаас тодруулахад тус байршилд туруутан амьтад энэ өвөл аргал янгир өвөлжөөгүй гэсэн учир Хөх овоо, Хангинах орчмын уулын туруутан амьтдад зориулж биотехникийн арга | 1,000.0 | 40ш өвс байршуулсан байх |

*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн*

### 4.1.1. Уурхайн замын усалгаа

Ухаа худаг уурхайд зам, талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор нийт 11 автомашинаар тогтмол усалгааны ажил гүйцэтгэж байна. 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 25-ны хугацаанд нийт **591,937 м³ ус** ашиглан тоосжилт дарах усалгааг хийсэн.

Уурхайн технологийн замын усалгаанд шүүрлийн усыг, нүүрс ачиж буулгах талбайн усалгаанд саарал усыг ашиглаж, усны хоёрдогч ашиглалтыг дэмжих, байгаль орчны нөлөөллийг бууруулах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.




Зураг 4.1.1.1 *Уурхайн технологийн замын усалгаа хийж буй байдал*

### 4.1.2. Уурхайн замын материал

Уурхайн үйл ажиллагаанаас үүсдэг тоосжилтын нэг томоохон эх үүсвэр нь уурхайн технологийн зам бөгөөд үүнд замын материал гол нөлөө үзүүлдэг. Тайлант хугацаанд тоосжилтыг багасгахад үр дүнтэй нь батлагдсан 291,271 м³ материалаар уурхайн технологийн тээврийн замд засвар, үйлчилгээ хийв. Түүнчлэн олборлолтын явцад гарсан замын материалыг дахин ашиглах зорилгоор 7,202 м³ нөөц бүрдүүлэн хадгалсан.




Зураг 4.1.2.1 *Уурхайн замын материал ба дэвссэн байдал*

### 4.1.3. Хүйтний улиралд тоосжилт бууруулах арга хэмжээ зохион байгуулах

Өвлийн улиралд тоосжилтыг бууруулах ажлын хүрээнд 2025 оны 2 дугаар сарын 8–21-ний хооронд болон 2 дугаар сарын 22–27-ны хооронд тус бүр 5 хоногийн хугацаатайгаар давстай усаар

цацах туршилтын ажлыг хоёр удаа зохион байгуулж, гүйцэтгэлээ. Туршилтыг нийт 10 хоногийн хугацаанд өөр өөр температурын нөхцөлд хэрэгжүүлж, үр нөлөөг ажиглан дүгнэв (туршилтын үеийн температурын ялгааг доорх хүснэгтэд үзүүлэв).

| Огноо | Өдрийн температур (°C) | Шөнийн температур (°C) |
|---|---|---|
| 2025.02.08 | -7$^{0}$C | -21$^{0}$C |
| 2025.02.09 | -6$^{0}$C | -18$^{0}$C |
| 2025.02.10 | -5$^{0}$C | -16$^{0}$C |
| 2025.02.18 | -4$^{0}$C | -15$^{0}$C |
| 2025.02.21 | -11$^{0}$C | -23$^{0}$C |

Туршилтын үр дүнгээр салхины хурд 6–9 м/с, агаарын температур -15°C байх үед замын гадаргуу дээр хөнгөн тээврийн хэрэгсэл 30–40 км/цагийн хурдтай зорчиход тоосжилт үүсээгүй байна. Мөн туршилтын дараах өглөө замын гадаргуу хөлдөлтгүй, чийгтэй хэвээр байв.





Зураг 4.1.3. Давс цацсан туршилтын ажлын үр дүн

Туршилтын үр дүнд үндэслэж өвлийн улиралд хуваарийн дагуу давстай усалгаа тогтмол хийхээр төлөвлөн ажиллаж байна.

### 4.1.4 Авто зам ашиглалтын үед үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын нөхцлийг сайжруулах

Баруун наран уурхайн нүүрс тээвэрлэх технологийн замыг 2-8 дугаар сарын хооронд 1.9 км урттай хэсэгт шинэ чиглэлд шилжүүлэн байгуулсан. Өмнөх замын хэсэгт геотехникийн хувьд тогтворжилтын эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тул хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, уурхайн хэвийн ажиллагааг найдвартай үргэлжлүүлэх зорилгоор замыг шороон сайжруулсан хэлбэрээр шинэ чиглэлд шилжүүлэн байгуулсан болно. Зам барилгын болон ашиглалтын явцад байгаль орчныг сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Тоосжилтыг бууруулах зорилгоор тогтмол усалгаа хийсэн.
- Хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлж, замын хажуугийн хэлбэрийг инженерийн шийдлээр тогтворжуулсан.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд геотехникийн тогтворжилт сайжирч тээврийн аюулгүй байдал нэмэгдэн, мөн замаар зорчих орон нутгийн иргэдийн хөдөлгөөн илүү аюулгүй найдвартай болсон нь нийгэм орон нутгийн хувьд эерэг нөлөөтэй байна.





Зураг 4.1.4.1 Баруун наран-Ухаа худаг нүүрс тээврийн зам болон дараах усалгаа

### 4.1.5 Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах

Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулж 2025 оны 10 сарын 25-ны байдлаар 129,623 м3 бохир усыг цэвэршүүлсэн. Хаягдал усыг стандарт шаардлагад нийцүүлэх сайжруулалт засвар үйлчилгээг хийж байна.



ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ
Өмнөговь аймаг, Цогтцэций сум, "Ухаа Худаг" уурхай
И-мэйл хаяг: [illegible]

MNAS

СОРИЛТЫН ТАЙЛАН

№: 2025_18

Хэвлэсэн огноо: 2025.10.11
Хуудасны дугаар: 1/1

| Лабораторийн дугаар | Техникийн шаардлага | Сорьцын тодорхойлолт |
|---|---|---|
| 18/35,36 | MNS 6561:2015 /оролт/ | "Бохир ус" |
| | MNS 4943:2015 /гаралт/ | "Цэвэрлэгдсэн бохир ус" |

Сорьцын нэр:
1. Б-35 СБУЦБ-ийн оролтын ус
2. Б-36 СБУЦБ-ийн гаралтын ус

Сорьц авсан: Ус хангамжийн техникч

| Сорьцын хэмжээ | Хүлээн авсан огноо | Шинжилсэн огноо |
|---|---|---|
| Тус бүр 0.5 л | 2025.10.05 | Эхэлсэн: 2025.10.05<br>Дууссан: 2025.10.10 |

*Шинжилгээний үр дүн:*

| Д/д | Шинжилгээний үзүүлэлт, нэгж | Шинжилгээний аргын стандарт | Зөвшөөрөгдөх хэмжээ | | Үр дүн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | оролт | гаралт | 35 | 36 |
| 1. | Үнэр, балл | MNS 1097:2023 | 0-5 | | 5 | 2 |
| 2. | Цахилгаан дамжуулах чанар, мкСм/см | MNS ISO 7888: 99 | - | | 3.69 | 1.43 |
| 3. | Усны орчин, pH | MNS ISO 10523:2001 | 6-9 | | 8.19 | 7.83 |
| 4. | Умбуур бодис, мг/л | MNS ISO 11923:2001 | 400 | 30 | 217.5 | **66.0** |
| 5. | Хлорид Cl-, мг/л | MNS 4424:2005 | 1000 | - | **1206.5** | 430.4 |
| 6. | Үлдэгдэл чөлөөт хлор, мг/л | Фотометр DT2B | - | 1 | - | 0.58 |
| 7. | Аммонийн азот ($NH_4^+$), мг/л | MNS ISO 7150-1:2006 | 15 | - | 1.95 | 3.06 |
| 8. | Нитритийн ион ($NO_2^-$), мг/л | MNS ISO 6777:2001 | - | | 1.20 | 0.74 |
| 9. | Фосфатын ион ($PO_4^{3-}$), мг/л | MNS ISO 6878:2001 | 5 | 1.5 | **21.66** | **12.36** |
| 10. | Нийт төмөр (Fe), мг/л | MNS ISO 4430:2005 | 3 | 1 | **17.15** | **6.64** |
| 11. | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч мг/л | MNS ISO 5815-1:2015 | 400 | 20 | 178 | **45** |
| 12. | Цэвэршилтийн зэрэг, % | | - | 100% | - | 74.6% |

*Энэхүү сорилтын дүн нь тухайн сорьцын хувьд хүчинтэй.*

Шинжилгээ гүйцэтгэсэн: Химич [illegible]

Хянаж баталгаажуулсан: Чанарын менежер [illegible] /Б. А[illegible]/

Сорилтын лаборатори[illegible] зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

Зураг 4.1.5.1 *Бохир усны шинжилгээний үр дүн*

### 4.1.6 Цэвэрлэх байгууламжаар усыг цэнгэгжүүлж унд ахуйн хэрэгцээнийн усаар хангах

Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж нь Галлерей кемп, Цэций хороолол, Уурхайчин хороолол болон Сумын цэвэр усны хэрэглээг хангаж ажиллаж байна. 2025 оны 10 сарын 10-ны байдлаар **153,014** м$^3$ ус цэнгэгжүүлэн ахуйн цэвэр усны хэрэглээнд нийлүүлсэн. Үүнд:

- Цэнгэгжүүлсэн усны 60м$^3$ нөөцийн савыг GRP материалаар хийгдсэн нөөцийн саваар шинээр сольсон.
- Концентрацтай усны шугамын цахилгаан хаалтыг шинээр сольсон.
- 6м$^3$-н төхөөрөмжийн урвуу осмосын мембранд угаалга хийсэн.
- Боловсруулагдах усны насос шинээр сольсон
- Концентрацтай усны насос шинээр сольсон
- Боловсруулагдах ус болон 6м3, 26м3-г шугамд механик тоолуурууд суурилуулсан.
- Автоматжуулалтыг системд гэмтэл гарч PLC сольж засварласан.
- УУЦБ-н дотор заалыг камержуулсан.



Зураг 4.1.6.1 *Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж*

### 4.1.7 Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах

Усны тухай хуулийн дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж “Усны газар”-аас 2025 оны 01 дүгээр сарын 30-нд Е-2501-000069 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж авсан. Мөн Галба Өөш Долоодын Говийн сав газрын захиргааны даргын 2023 оны А/06 тушаалаар ус ашиглах зөвшөөрлийг гаргуулсан бөгөөд сав газрын захиргаатай 2025 оны 04-р сарын 08-ны өдөр 2025/02 тоот ус ашиглах гэрээг байгуулан ажиллаж байна.



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

2025 оны 1 дүгээр сарын 30 -ний өдөр

Дугаар Е-2501-000069

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Ухаа худаг ус хангамж |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 3614085 |
| Захирал: | Лхагваочир |
| Холбоо барих дугаар: | 77202279 |
| Факс: | |
| И-мэйл хаяг: | |

2. Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Ухаа худаг ус хангамж ХХК |
| Байршил: | Өмнөговь, Цогтцэций, 1-р баг, Сийрст |
| Харьяалагдах сав газар: | Галба-Өөш Долоодын говийн сав газар |
| Хамаарах салбар: | Нийтийн болон аж ахуйн үйлчилгээний газрууд |
| Төслийн дэлгэрэнгүй: | [illegible] |



БАТЛАВ:
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.ЯЛАЛТБАЯР

БАТЛАВ:
“УХАА ХУДАГ УС ХАНГАМЖ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ЛХАГВА-ОЧИР

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 4-р сарын 8 өдөр Дугаар 2025/02 Сайншанд хот

UHGUS-25-030

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Усны газрын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Е-2501-000069 дүгээр ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/07 дугаар тушаалыг тус тус үндэслэн:

Нэг талаас Ус ашиглуулагч /цаашид "**Захиргаа**" гэх/-ийг төлөөлж Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Жанчивдорж, нөгөө талаас ус ашиглагч /цаашид "**Ус ашиглагч**" гэх/-ийг төлөөлж Өмнөговь аймаг Цогтцэций суманд байрлах "Ухаа худаг ус хангамж" ХХК /улсын бүртгэлийн дугаар 1111003043, регистрийн дугаар 3614085/-ийн Дэд бүтцийн албаны дарга Д.Сүхбаатар нар ус ашиглах талаар харилцан тохиролцон энэхүү Ус ашиглах гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:
   2.1.1. Эрчим хүчний үйлдвэрлэл
   2.1.2. Нөхөн сэргээлт, мод усалгаанд
   2.1.3. Хүн амын унд
   2.1.4. Газар тариалан
   2.1.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд
   2.1.6. Зам талбайн усалгаа
2.2. Ашиглах усны хэмжээ:
   2.2.1. Эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглах ус – 78,000.0 $м^3$/жил
   2.2.2. Нөхөн сэргээлт, мод усалгаанд ашиглах ус – 170,000.0 $м^3$/жил
   2.2.3. Хүн амын унд ахуйн хэрэгцээнд ашиглах ус – 120,000.0 $м^3$/жил
   2.2.4. Газар тариаланд ашиглах ус – 25,000.0 $м^3$/жил
   2.2.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах ус – 110,000.0 $м^3$/жил

1

Зураг 4.1.7.1 *Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ*

### 4.1.8. Хаягдал усны гэрээ байгуулж биелэлтийг ханган, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах

Манай компани “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Ухаа худаг ус хангамж ХХК дээр 163,614.5 $м^{3}$/жил, Энержи Ресурс ХХК дээр 1,072,989.33 $м^3$/жил бохир усыг хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугаманд “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал,

ерөнхий шаардлага MNS4943:2015", "Хүрээлэн байгаа орчин чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS6561:2015" стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар авч гэрээг байгуулан төлбөрийг гэрээний заалтын дагуу тухай бүрт төлж байна.









Зураг 4.1.8.1. *Хаягдал усны зөвшөөрөл, сунгалт, гэрээ*

**4.1.9 Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих.**

Уурхайн ухмал болон хаягдал чулуулгийн овоолгын тэлэх талбайн тэлэлтийн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орох газрын шимт хөрсийг "Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5916:2008" стандартын дагуу хуулж хадгалдаг. Шимт хөрсний овоолго тус бүрийг дугаарлаж овоолго хийсэн огноо, хөрсний эзлэхүүн зэрэг мэдээллүүдийг оруулан бүртгэлжүүлж байна. Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлттэй холбогдуулан **2025 онд нийт 695,835 м$^3$** хөрсийг хуулж овоолго үүсгэсэн байна.



Зураг 4.1.9.1. *2025 оны шимт хөрсний овоолгийн байршлын зураг*

### 4.1.10 Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд олборлолт хийх

Ухаа худаг уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөлтөөр нийт 10.0 сая тонн нүүрс олборлохоор батлуулсан ба 2025 оны 10-р сарын 27-ний байдлаар **9,124,725** тонн нүүрс олборлосон байна.

### 4.1.11 MV-011952 тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайгаас тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх

Төслийн үйл ажиллагаанд зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмалт ашигласан тохиолдол гараагүй бөгөөд үйлдвэрлэлийн бүсэд томоохон барилга байгууламж шинээр баригдаагүй. Компанийн ажилтнуудыг орон нутагт суурьшуулах бодлогын хүрээнд хийгдсэн Цэций хорооллын 2-р ээлжийн орон сууцны барилгыг 2024-2025 онд Си Эй Ти Ди ХХК-р гэрээгээр бариулж байгаа болно.

Уг компани Цогтцэций болон ойролцоох сумдад үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдээс ТТАМ болон бетон зуурмагийн узелиудаас бэлэн бетон худалдан авч орон сууцны барилгын ажилд ашигласан ба үүнд захиалагч талын зүгээс хяналт тавьж ажилласан.

### 4.1.12 Нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж мод, сөөг үржүүлж бойжуулах

“Ухаа худаг” уурхайн олборлолтын үйл ажиллагаатайгаа зэрэгцэн, ирээдүйд уурхайн биологийн нөхөн сэргээлтэд ашиглах нутгийн болон олон наст ургамал, мод, сөөгийг туршилтын байдлаар ургуулах, бүс нутагт зохицсон ургамлыг сонгож, тэдгээрийг үржүүлж бойжуулан биологийн нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулах, орчны тохижилтод ашиглах зорилгоор 2009 онд 2.5 га талбай бүхий мод үржүүлгийн талбайг байгуулсан. 2025 оны тайлант онд тус мод үржүүлгийн талбай дээр говийн бүс нутагт тархан ургадаг Жигд, Сухай, Хайлаас, Тоорой, Заг, Харгана, Бүйлс, Хармаг, Хотир зэрэг мод болон орон нутгийн бутлаг ургамлыг үр болон мөчирөөр нийт 35,000 ш тарьж ургуулан мөн мод үржүүлгийн талбайгаас орчны тохижилт ногоон байгууламж, нөхөн сэргээлтэнд 14,965 ш тарьц суулгацыг бэлтгэн нийлүүлсэн байна.




Зураг 4.1.12.1 *Мод үржүүлгийн талбай*

### 4.1.13 Хөрс ургамал бохирдуулахаас сэргийлж ажилчидад зориулж ариун цэврийн блок хийж байршуулах

Тээвэр логистикийн албаны Ухаа худаг уурхайн бүсэд ариун цэврийн зориулалттай байр нь засварын цех болон нүхэн жорлон гэсэн байдлаар байдаг бөгөөд дараах хэсгүүдэд ачаалал ихэссэн, үүнтэй холбоотойгоор ажилчдын үр бүтээмж сэтгэл ханамж буурсан болон байгаль орчинд сөрөг нөлөөтэй байгаа тул шинээр 3 ш 40 тн контайнерийг ариун цэврийн блокоор тоноглож холбогдох инженерийн шугам сүлжээнд холбоот хийж гүйцэтгэсэн.




Зураг 4.1.13.1. *Шинээр хийсэн ариун цэврийн байгууламж*

### 4.1.14 Уурхайн орчмын ногоон байгууламжийн нөхөн тарилтыг зохион байгуулах

Манай компани нь жил бүр "Тэрбум мод" тарих үндэсний өдрөөр уурхайн орчмын ногоон байгууламж, зам дагуу, ажилчдын хотхон орчим таригдсан модны нөхөн тарилт арчилгаа хамгаалалалтыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү үйл ажиллагаанд ххк-ын ажилтан бүр идэвхи санаачлагатай, хариуцлагатайгаар оролцох уламжлал тогтсон бөгөөд ххк-ын нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд жил бүр хэрэгждэг чухал ажлын нэг болсон байна. Нөхөн тарилтаар Улиас, Сухай, Жигд, Хайлаас зэрэг 2825 ш мод тарьж ургуулан намрын модны амьдралтын хувь 85%-аас дээш үзүүлэлттэй байгаа нь говийн бүс нутагт харьцангүй өндөр үзүүлэлт юм. Намрын цэнэг усалгаа, арчилгааны ажлыг бүрэн хийж,өвөлжилтийн бэлтгэлийг ханган ажилласнаар уурхай орчмын ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийн чанар, үр өгөөжийг сайжруулах, байгаль орчны тогтвортой байдлын дэмжих зорилт амжилттай хэрэгжсэн болно.




Зураг 4.1.14.1 *Мод тарьж буй байдал*

### 4.1.15 Уулын туруутан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

Цогтцэций сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу Билгэх багийн Тугийн цохио, Хөх овоонд ашигт долооц тавих ажлыг 2025 оны 03-р сарын 4-ний өдөр зохион зохион байгуулсан. Тугийн цохио орчимд уулын туруутан амьтад ажиглагдаагүй бөгөөд ойр орчмын айлаас тодруулахад тус байршилд туруутан амьтад энэ өвөл аргал янгир өвөлжөөгүй гэсэн учир Хөх овоо, Хангинах орчмын уулын туруутан амьтдад зориулж биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Тус арга хэмжээг 5 хүний бүрэлдэхүүнтэй хоёр байршилд нийт 8 хайрцаг буюу 24 ширхэг ашигт долооцыг туруутан амьтдын хэвтэр газарт тараан байршуулсан. Мөн амьтны ажиглалтын камер суурьлуулах

ажил хийгдлээ. Биотехникийн арга хэмжээ авахаар төлөвлөсөн байршлуудад цастай, өвстэй байсан тул энэ удаад өвс болон мөс тавих хэрэгцээ байгаагүй болно. Мөн 2025.04.19-нд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах "Хангинах хад" ууланд байрлуулсан зэрлэг ан амьтдыг хянах ажиглалтын камерын тэжээл солих, цуглуулсан мэдээллийг хянах болон долооц байрлуулах ажлын зохион байгуулсан.



Зураг 4.1.15.1 *Биотехникийн арга хэмжээ зохион байгуулсан байдал*

**4.2. Нүүрс баяжуулах үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 1 | Нүүрсний шаталт уугилтыг тухай бүр бууруулж агаарын бохирдлоос сэргийлэх | Нүүрсний овоолго | 2025 оны 10-р сарын байдлаар нүүрсний овоолгын халалттай хэсгийг усаар хөргөж, тусгаарлаж авснаар нүүрс шатаж агаар бохирдохоос урьдчилан сэргийлсэн байна. | Үйлдвэрийн зардлаас | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Хаягдлын далангийн хуурай хаягдлыг хөрсөөр хучиж тоос дэгдэлтийг багасгах | Нүүрс баяжуулах үйлдвэр | НБҮ-ийн хаягдлын далангийн хуурай хаягдлыг МСС ХХК болон Говь Ресурс Девелопмент ХХК хариуцаж 3 га талбайг хучиж тоосжилт үүсэх сөрөг нөлөөллийг багасгасан. | Үйлдвэрийн зардлаас | 3.0 га |
| Газар доорх усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, хамгаалах | | | | | |
| 3 | Хаягдлыг усгүйжүүлэх хэсэгт өргөтгөл хийж хүчин чадлыг нэмэгдүүлж, НБҮ-ийн технологийн усыг эргэлттэйгээр ашиглаж усны нөөцийг хэмнэх | Нүүрс баяжуулах үйлдвэр | 2025 оны 10-р сарын 29-ны өдрийн байдлаар хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр нь 1,076,853 $м^3$ усыг үйлдвэрт эргүүлэн татаж ашигласан байна. | Үйлдвэрийн зардлаас | - |
| 4 | Усыг зөвхөн дүгнэлтэнд заасан хэмжээнд ашиглах | Ухаа худаг ус хангамж | 2025.05.15 өдөр Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглах гэрээгээр 2,271,896.47 м3/жил усыг ус баяжуулах үйлдвэрт ашиглахаар тусгаснаас 10-р сарын 29-ны байдлаар 1,590,565 $м^3$ ус ашигласан байна. | Үйл ажиллагааны зардлаас | - |
| Хөрс, ургамал үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 5 | Хөрс ургамал бохирдуулахаас сэргийлж ажилчдад зориулж шинээр ариун цэврийн блок суурьлуулах | УХГ НАБТ | 2025 оны 2-р сард ашиглалтад оруулсан. Тус ариун цэврийн блок нь нэгэн зэрэг 4 хүн үйлчлүүлэх боломжтой, 6 ширхэг шүүлтүүрийн системтэй бөгөөд бохир усны шугам нь төвийн бохирын системд холбогдсон. | Үйл ажиллагааны зардлаас | 1 ш |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх | Сумаас уурхай явах хатуу хучилттай зам дагуух ногоон байгууламж | Зам дагуух мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг тогтмол хуваарийн дагуу хийж 2025 оны 10-р сарын 05-ны өдрөөс 20-ны өдрүүдэд цэнэг усалгааг хийж гүйцэтгэсэн. | 12,000.00 | 3000 ширхэг |
| НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | | 12,000.00 | |

**Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн*

### 4.2.1 Нүүрсний шаталт уугилтыг тухай бүр бууруулж агаарын бохирдлоос сэргийлэх

Ухаа худаг уурхайн нүүрсний өөрөө шатах үзэгдлийг хянах, шаталтаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Нүүрсний өөрөө шатах үзэгдлийг хянах, сэргийлэх” дотоод журмыг боловсруулан мөрдөж байна. Нүүрсний шаталтаас үүсэх агаарын бохирдлоос урьдчилсан сэргийлж нүүрсний овоолгын халалтын температурыг өдөр бүр хэмжиж, хэмжилтийн тайланг гаргаж холбогдох хүмүүст тайлагнаж байна. 2025 оны 10-р сарын байдлаар нүүрсний овоолгын халалттай хэсгийг усаар хөргөж, тусгаарлаж нүүрс шатаж агаар бохирдохоос урьдчилан сэргийлсэн байна.




Зураг 4.2.1.1 Өдөр тутмын тайлан



Зураг 4.2.1.2 Нүүрсний шаталт

### 4.2.2 Хаягдлын далангийн хуурай хаягдлыг хөрсөөр хучиж тоос дэгдэлтийг багасгах

НБҮ-ийн хаягдал ус хадгалах, эргэн ашиглах зориулалтаар ашиглаж байсан эргэлтийн усан санг шимт хөрсөөр хучих хучилтын ажлыг хаягдал дахин боловсруулах зориулалтаар ашиглаж буй МСС ХХК болон Говь Ресурс Девелопмент ХХК-иуд хариуцан хийсэн. Тус ажлын хүрээнд 2025 оны 4-р сараас 10-р сарын хооронд 3 га талбайг шимт хөрсөөр хучсан ба нийт 64 га талбайгаас 43 га-г хучсан байна.




Зураг 4.2.2.1. Хаягдлын далангийн хучилтын ажлын гүйцэтгэл

**4.2.3 Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн үйл ажиллагааг горимын дагуу явуулж НБҮ-ийн технологийн усыг эргэлттэйгээр ашиглаж усны нөөцийг хэмнэх**

Хаягдлын усгүйжүүлэх үйлдвэрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна. 2025 оны 4-р сард НБҮ-ийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн өргөтгөлийг ашиглалтад оруулсан бөгөөд хүчин чадлыг 50 хувиар нэмсэн. 2025 оны 10-р сарын 29-ны өдрийн байдлаар хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр нь 1,076,853 м$^3$ усыг үйлдвэрт эргүүлэн татаж ашигласан байна.

/




Зураг 4.2.3.1. Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

**4.2.4 Усыг зөвхөн дүгнэлтэнд заасан хэмжээнд ашиглах**

Ухаа худаг уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэглээнд ашиглах усны  ус ашиглах дүгнэлтийг Усны газраас авч, 2025 оны 5-р сарын 15-ны өдөр Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг байгуулсан бөгөөд гэрээнийд заасанаар 2,271,89296.47 м$^3$/жил усыг усыг баяжуулах үйлдвэрт ашиглахаар тусгаснаас 10-р сарын 29-ны өдрийн байдлаар 1,590,565 м$^3$ ус ашигласан байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

оны -р сарын -ны өдөр | Дугаар E-2501-000005 | Улаанбаатар хот Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Энержиресурс ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 2887746 |
| Захирал: | Энхбат |
| Холбоо барих дугаар: | 70122279 |
| Факс: | |
| И-мэйл хаяг: | |

2.Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Ухаа худаг уурхайн нүүрс баяжуулах үйлдвэр |
| Байршил: | Өмнөговь, Цогтцэций, 3-р баг ,Цагаан-Овоо |
| Харьяалагдах сав газар: | Галба-Өөш Долоодын говийн сав газар |
| Хамаарах салбар: | Уул уурхай |
| Төслийн дэлгэрэнгүй: | Энержи ресурс ХХК-ийн Ухаа худгийн коксжих нүүрсний орд болон нүүрс баяжуулах үйлдвэр нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт оршдог бөгөөд Цогтцэций сумын төвөөс баруун урагш 7км, Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 95км, Улаанбаатар хотоос зүүн урагш 550км, хилийн Гашуун сухайт боомтоос баруун хойш 240км зайд байрладаг. Галба-Өөш Долоодын говийн сав газарт хамааргдана. Нүүрс баяжуулах үйлдвэрт Ухаа худгийн ордоос олборлосон ангидарч нүүрсийг -50мм хүртэл 3 шатны бутлуураар бутлан, шламгүйжүүлэх шигшүүрээр 3 фракцид хуваан, том бүхэллэгтэй нүүрсийг хүнд орчны циклоноор ялгах ба дундаж бүхэллэгтэй нүүрсийг шурган сепаратор ангилах, нарийн бүхэллэгтэй нүүрсийг флотацийн аргаар баяжуулах гэсэн технологийн дамжуулгыг ашиглаж байна. Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр нь CPF-3000 маркийн 4ш усгүйжүүлэх машинтай, эдгээр нь 24 цагаар ажилладаг. Энержи ресурс ХХК-ийн Цагаан хадны кемп болон нүүрс ачиж, буулгах талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт оршдог бөгөөд Ханбогд сумын төвөөс баруун урагш 75км, Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 277км, Улаанбаатар хотоос зүүн урагш 820км, хилийн Гашуун сухайт |



БАТЛАВ:
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.ЯЛАЛТБАЯР
2025 оны 6 сарын 15 өдөр

БАТЛАВ:
"ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ
С.ЛХАГВА-ОЧИР
2025 оны 05 сарын 19 өдөр

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 5 сарын 5 өдөр | Дугаар 2025/05 | Сайншанд

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дугаар зүйлийн 29.1-д заасны дагуу Усны газрын 2025 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн E-2501-000005 дугаар ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалыг тус тус үндэслэн:

Нэг талаас Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа (цаашид "**Захиргаа**" гэх)-ийг төлөөлж Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны Усны чанар, экологи төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн О.Амгалан, нөгөө талаас Өмнөговь аймаг Цогтцэций суманд байрлах Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэр, Ханбогд сумын нутагт байрлах Цагаан хадны кемп болон нүүрс ачиж буулгах талбайд үйл ажиллагаа явуулдаг "Энержи Ресурс" ХХК (улсын бүртгэлийн дугаар 9011007001, регистрийн дугаар 2887746) (цаашид "**Ус ашиглагч**" гэх)-ийг төлөөлж Дэд бүтцийн албаны дарга Д.Сүхбаатар нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) нь ус ашиглах талаар тохиролцон энэхүү Ус ашиглах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:
- 2.1.1. Нүүрсийг гравитацийн аргаар угаан баяжуулахад ашиглах;
- 2.1.2. Нүүрсийг флотацийн аргаар угаан баяжуулахад ашиглах;
- 2.1.3. Барилга, барилгын материал үйлдвэрлэхэд ашиглах;
- 2.1.4. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах;
- 2.1.5. Уурхайн ухлагаас шавхан зайлуулж болзошгүй уерийн ус;
- 2.1.6. Уурхайн ухлагад хуримтлагдсан ус.

2.2. Ашиглах усны хэмжээ:
- 2.2.1. Нүүрсийг гравитацийн аргаар угаан баяжуулахад ашиглах ус-2,038,710.55 м³
- 2.2.2. Нүүрсийг флотацийн аргаар баяжуулахад ашиглах ус- 233,185.92 м³
- 2.2.3. Ухаа худаг уурхайн ухлагад шүүрэн орж ирэх ус-93,345.10 м³
- 2.2.4. Ухаа худаг уурхайн өрөмдлөгт ашиглах ус-98,110.20 м³
- 2.2.5. Тэрбум мод болон биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ус-105,721.2 м³
- 2.2.6. Ухаа худаг уурхайн засварын газрын угаалга, цэвэрлэгээнд ашиглах ус-8,974.46 м³

1

Зураг 4.2.4.1 Ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээ

## 4.2.5 Хөрс ургамал бохирдуулахаас сэргийлж ажилчдад зориулж шинээр ариун цэврийн блок суурьлуулах

"Ухаа худаг" НАБТ-ын зааварчилгааны байрны хажууд ариун цэврийн блокийг "Саади Констракшн" ХХК-аар бариулж, 2025 оны 2 дугаар сард ашиглалтад оруулсан байна. Тус ариун цэврийн блок нь нэгэн зэрэг 4 хүн үйлчлүүлэх боломжтой, 6 ширхэг шүүлтүүрийн системтэй бөгөөд бохир усны шугам нь төвийн бохирын системд холбогдсон тул хөрс, ургамал бохирдуулах эрсдэлгүй, байгальд ээлтэй шийдэлтэйгээр ашиглагдаж байна.





Зураг 4.2.5.1 НАБТ-д суурьлуулсан ариун цэврийн блок

## 4.2.7 Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх

Нүүрс баяжуулах үйлдвэрийн орчим, ногоон байгууламж болон засмал замын дагуу байрлах 3,000 мод бүхий ногоон байгууламжийн усалгааны системийг засварлаж, тогтсон хуваарийн дагуу усалгаа, арчилгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн намрын цэнэг усалгааг 2025 оны 10 дугаар сарын 05-наас 20-ны өдрүүдийн хооронд зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан байна.




*Зураг 4.2.7.1 НБҮ орчим болон зам дагуух модтой талбай*

**4.3. Цахилгаан станцын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 1 | Цахилгаан станцын уурын зуухны нарийн үнс тээвэрлэхэд үүсэх тоосжилтыг бууруулах үзлэг хийх. Үнс тээвэрлэх машины тэвшний нягтруулгыг сэргээх | Цахилгаан станц | Үнс тээвэрлэх автомашины тэвшний нягтруулгын засварын ажлыг 2025 оны 9-р сарын байдлаар тэвшний нягтруулгыг сар бүр шинэчилж, шаардлагатай тохиолдолд нэмэлт сайжруулалт хийж ажиллаж байна. | 4,500.0 | Сар бүр |
| Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 2 | Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах | Хээрийн булаг | Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээг 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, Цогтцэций сумаас 35 км зайд байрлах “Булгийн эх уст” орчимд 6 хүний бүрэлдэхүүнтэй баг талбайн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан ажиллав. | 450.0 | 9-р сард жилд 1 удаа |
| 3 | Цахилгаан станцын хөргөлтийн задгай системийг битүү системээр шинэчилж усны нөөцийг хэмнэх | Цахилгаан станц | Үйлдвэрийн хөргөлтийн задгай системийг битүү системтэй хөргөх цамхгаар солих ажлын мэргэжилтэн ирж угсралт хийж, удирдлагыг гар дээр явуулж станцын хөргөлтийн системийг 2 турбин, зуухтай явж байх үед битүү систем рүү 6 цаг явуулж шалгасан. Хэвийн | 540.0 | 12-р сард |
| Хөрс, ургамал үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 4 | Цахилгаан станцын дотор зүүн талын талбайд шинээр 200 ширхэг мод тарих | Цахилгаан станц | 2025 оны 5 дугаар сард нийт 200 ширхэг мод шинээр тарьж, өмнө тарьсан моддын хорогдлыг нөхөх зорилгоор 33 ширхэг модыг нөхөн тарьсан. | 700.0 | 5-р сард , Жилд 1 удаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 3А болон 2А-тай Алкалин нэг удаагийн батарейны оронд дахин цэнэглэж ашиглах боломжтой 50 ширхэг лити-ион батарейгаар сольж хог хаягдлын тоо хэмжээг бууруулах | Цахилгаан станцын оффис | Энэ ажлын хүрээнд нийт 50 ширхэг лити-ион батарей болон 10 ширхэг цэнэглэгч төхөөрөмжийг худалдан авч, 2025 оны 9 дүгээр сараас эхлэн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд туршин нэвтрүүлж эхэлсэн болно. | 1000.0 | 9 сард |
| 6 | Цахилгаан станцын үндсэн тоноглол болох уурын турбины тосыг 2 ба түүнээс дээш жил ажиллах чанартай тосоор шинэчлэх хаягдал тосны хэмжээг бууруулах | Цахилгаан станц | Цахилгаан станцын уурын турбин №1-ийн тосыг 2025 оны 1-р сард, турбин №2-ийн тосыг 2025 оны 8-р сард GS-46 маркийн Солонгос улсын синтетик тосноос Sinopec брэндийн LTSA-46 маркийн тосоор их засварын үеэр сольсон. | 360.0 | 9 сард жилд нэг удаа |
| Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | |
| 7 | 35 кВ Баруун наран ЦДАШ-бетон хийцтэй анкер тулгуурт 40ш туузан шувуу үргээгч суурилуулах | УХГ – БН 35 кВ ЦДАШ | 35 кВ Баруун наран ЦДАШ-ийн бетон тулгуурт 40ш туузан шувуу үргээгчийн суурилуулалт 10-р сарын 15 аас 16 ний өдрийн хооронд хийгдсэн. УБ35-1 маркын давхар тросс татлагатай төмөр бетон анкер тулгуурын траверсын дээд талд полимэр изолятор бэхэлж, түүнээс шлейфийг бэхэлсэн хэсэгт шувуу сууж, хүчдэлд нэрвэгдэх өндөр магадлалтай байсан тул ийм төрлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү ажил хийгдсэн. Шувуу үргээгч төхөөрөмжийг зориулалтын сагст өргөгч ашиглан суурилуулсан. | 4,000.0 | 5-9 сард, Жилд 1 удаа, 40ш |
| 8 | Ус хангамж дэд станц ойн зурвас дэд өртөөний 9 тулгуурт 18 ш шувуу үргээгч суурилуулах | Ус хангамж ,Ойн зурвас | Ус Хангамж С трассын Ойн зурвас 10/04 кВ дэд өртөөний 9 тулгуурт 18 ш шувуу үргээгч суурилуулах ажил 5-р сард 100% хийгдэж дууссан. | 810.0 | 5-9 сард Жилд 1 удаа, 18ш |
| 9 | Наймдайн худгийн 10 кВ ЦДАШ-ийн тулгууруудад хийгдсэн шувуу хүчдэлд нэрвэгдэхээс хамгаалах бүрээсүүдийг үзлэг хийж | Наймдай хөндийн 10 кВ худгийн шугамууд | Наймдайн хөндийн гүний худгийн 10 кВ ЦДАШ-д суурилуулсан шувуу үргээгчид 9 сард үзлэг хийсэн ба үзлэгээр зөрчил илрээгүй хэвийн байсан. Трансговийн 10 кВ ЦДАШ шилжүүлэх ажил хийгдэж дууссаны дараа 10-р сарын 27, 28-ны өдрүүдэд хийгдэж илэрсэн үл тохирлыг арилгаж ажиллалаа. | Үйлдвэр лэлийн зардлаас | 5-9 сард Жилд 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шалган сайжруулах | | | | |

*Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн*

### 4.3.1 Үнс тээвэрлэлтийн тоосжилт бууруулах үзлэг, тэвшний нягтруулга сэргээх ажил

Цахилгаан станцын үнс тээвэрлэлтийн явцад үүсэх тоосжилт, үнсний алдагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор үнс тээвэрлэх автомашины тэвшний нягтруулгыг сайжруулах ажлыг хэрэгжүүлж байна.

Үүнтэй холбогдуулан тэвшний нягтруулгын материал, хэрэгслийн худалдан авалт хийгдэж, уг ажлыг засварын төвийн сарын ажлын төлөвлөгөөнд тусган, тогтмол шинэчлэл хийж байна. 2025 оны 9 дүгээр сарын байдлаар, үнс тээвэрлэлтийн автомашинуудын тэвшинд хийгдсэн нягтруулгыг сар бүр шалгаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн засварлах, дахин нягтруулах ажлыг тогтмол хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь үнс асгаралт, салхиар тарах тоосжилтыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ болж байна. Цаашид энэхүү ажлыг тогтмол хяналт, үзлэгийн хуваарьт үйл ажиллагаанд нэгтгэн, техникийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 4.3.1.1 *Үнс тээвэрлэх машины тэвшний нягтруулгыг сэргээж бэлэн байдлыг хангасан байдал.*

### 4.3.2 Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах

Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээг 2025 оны 9 сарын 19 нд зохион байгуулсан. Цогтцэций сумаас 35 км зайтай байрлах "Булгийн эх уст" орчимд 6 хүний бүрэлдэхүүнтэй баг аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулав.



Зураг 4.3.2.1 *Булгийн эх болон уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ авч буй байдал.*

### 4.3.3 Цахилгаан станцын хөргөлтийн задгай системийг битүү системээр шинэчилж усны нөөцийг хэмнэх

Үйлдвэрийн хөргөлтийн задгай системийг битүү системтэй хөргөх цамхагаар солих ажлыг БНХАУ-н мэргэжилтнүүдийн оролцоотойгоор угсралт, туршилт тохируулгын хамт гүйцэтгэлээ. Угсралтын дараа станцын хөргөлтийн системийг хоёр турбин, нэг зуухтай зэрэг ажиллуулж, битүү систем рүү 6 цагийн турш туршин шалгасан. Автоматикийн буюу алсаас удирдах системийн тохируулгын ажил хийгдэж байгаа бөгөөд бүрэн ажиллагаанд оруулах бэлтгэл хангагдаж байна.

Одоогоор хөргөлтийн задгай системээс битүү систем рүү шилжсэнээр жилд 19,300 тонн ус хэмнэх урьдчилсан тооцоо гарсан.




Зураг 4.3.3.1 *Хөргөлтийн задгай системийг битүү систем болгосон барилгын ажлын явц*

### 4.3.4 Цахилгаан станцын хашаанд мод тарих

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тоосжилтыг бууруулах, орчны гоо зүйн байдлыг сайжруулах зорилгоор Цахилгаан станцын хашааны дотор талд мод тарих ажлыг хэрэгжүүллээ.

2025 оны 5 дугаар сард нийт 200 ширхэг мод шинээр тарьж, өмнө тарьсан моддын хорогдлыг нөхөх зорилгоор 33 ширхэг модыг нөхөн тарьсан. Тарьсан модонд тогтмол усалгаа, арчилгаа, хөрс сийрүүлэх, хог ургамал түүх зэрэг арчилгааны ажлыг зохион байгуулж, ургамлын ургалтын байдлыг байнга хянаж байна.





*Зураг 4.3.4.1 Цахилгаан станцын зүүн талын талбайд мод тариж буй байдал*

**4.3.5 Нэг удаагийн батарейг дахин цэнэглэдэг лити-ион батарейгаар солих**

Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын хэмжээг бууруулах, нөөцийг үр ашигтай ашиглах зорилгоор 3А болон 2А төрлийн нэг удаагийн алкалин батарейг дахин цэнэглэж ашиглах боломжтой батарейгаар үе шаттайгаар орлуулах ажлыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд нийт 50 ширхэг лити-ион батарей болон 10 ширхэг цэнэглэгч төхөөрөмжийг худалдан авч, 2025 оны 9 дүгээр сараас эхлэн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд туршин нэвтрүүлж эхэлсэн болно. Уг арга хэмжээ нь нэг удаагийн батарейн хэрэглээг бууруулж, аюултай хог хаягдлын үүсэлтийг багасгах, улмаар байгаль орчны менежментийн тогтвортой байдлыг хангах чухал алхам болж байна.




Зураг 4.3.5.1 *Дахин цэнэглэж ашиглах боломжтой лити-ион батарей.*

**4.3.6 Уурын турбины тосыг шинэчилж, хаягдал тосны хэмжээг бууруулах**

Цахилгаан станцын уурын турбин №1-ийн тосыг 2025 оны 1-р сард, турбин №2-ийн тосыг 2025 оны 8-р сард GS-46 маркийн Солонгос улсын синтетик тосноос Sinopec брэндийн LTSA-46 маркийн тосоор их засварын үеэр сольсон. Энэхүү тос нь 2 ба түүнээс дээш жил ашиглах боломжтой бөгөөд хуучин тосыг аюултай хог хаягдлын журмын дагуу тусгай зөвшөөрөлтэй компаниар устгуулсан.




Зураг 4.3.6.1 *Нотолгоогоор ирүүлсэн ажилийн тайлангийн зураг тайлбар болон огноон хамт.*

### 4.3.7 35 кВ Баруун наран ЦДАШ-бетон хийцтэй анкер тулгуурт 40ш туузан шувуу үргээгч суурилуулах

35 кВ Баруун наран ЦДАШ-ийн бетон тулгуурт 40ш туузан шувуу үргээгчийн суурилуулалт 10-р сарын 15 аас 16 ний өдрийн хооронд хийгдсэн. УБ35-1 маркын давхар тросс татлагатай төмөр бетон анкер тулгуурын траверсын дээд талд полимэр изолятор бэхлэж, түүнээс шлейфийг бэхэлсэн хэсэгт шувуу сууж, хүчдэлд нэрвэгдэх өндөр магадлалтай байсан тул ийм төрлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү ажил хийгдсэн. Шувуу үргээгч төхөөрөмжийг зориулалтын сагст өргөгч ашиглан суурилуулсан. 35 кВ-ын "Баруун Наран" цахилгаан дамжуулах шугамын бетон тулгуурт зориулсан нийт 40 ширхэг туузан хэлбэрийн шувуу үргээгчийг худалдан авсан. Уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай өргөх машин механизмын захиалгыг өгч, суурилуулалтын бэлтгэл болон харьцуулалтын ажлуудыг хийж байна.





Зураг 4.3.7.1 *Туузан шувуу үргээгч суурьлуулж буй байдал*

### 4.3.8 Ус хангамж дэд станцын 9 тулгуурт 18 шувуу үргээгч суурилуулах ажил

Ус Хангамж С трассын Ойн зурвас 10/04 кВ дэд өртөөний 9 тулгуурт 18 ш шувуу үргээгч суурилуулах ажил 5-р сард 100% хийгдэж дууссан.




*Зураг 4.3.8.1 Шаардлагын дагуу заагдсан газруудад шувуу үргээгч суурьлуулж буй байдал.*

### 4.3.9 Наймдайн худгийн 10 кВ ЦДАШ-ийн тулгууруудын шувуу хамгаалалтын бүрээсийг шалгаж, сайжруулах

Наймдайн худгийн 10кВ ЦДАШ-ийн тулгууруудад хийгдсэн шувуу хүчдэлд нэрвэгдхээс хамгаалах бүрээсүүдийг шувууны хорогдол илэрсэн цэгүүдийн хийцлэлийг шалган сайжруулах ажлыг 2 сар дараалан хийв. 2025 оны 9 сарын 30 нд суурилуулсан шувуу үргээгчид үзлэг хийсэн ба үзлэгээр зөрчил илрээгүй хэвийн байсан. 10 сард Наймдайн гүний худгийн 10 кВ ЦДАШ-д суурилуулсан шувуу үргээгчид давтан үзлэг хийхэд 5 тулгуурын Р15-т маягийн хөндийрүүлэгчийн тусгаарлагч резин малгай унасан, бэхэлгээ салж хөндийрүүлэгчийн нэг талд гарсан үл тохиролууд гарсан ба тус тулгуур бүрт шинээр тусгаарлагч резин малгай хийв.




Зураг 4.3.9.1 *Шувууг хүчдэлд нэрвэгдэхээс хамгаалсан бүрээсүүдэд үзлэг хийж сайжруулсан байдал.*




Зураг 4.3.9.2 Тусгаарлагч малгай бэхэлгээ салж утсанд тохогдсоныг засан сайжруулж тусгаарлагч малгай шинээр хийсэн байдал.

## 4.4. Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх | НАБТ | Нүүрс ачиж буулгах талбайн дотоод тоосжилтыг бууруулах зорилгоор нарийн ширхэгтэй нүүрсээр машины дугуйны нөлөөгөөр тоосжилт үүсгэхээс сэргийлж тогтмол хусаж цэвэрлэх, хашаан доторх автомашины хурдны хязгаарыг 5км/цаг байхыг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд зам талбайд усалгаа хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Нүүрс ачиж буулгах талбайн тоосжилт дарах зориулалтаар 2025 оны 9 сарын 30-ны байдлаар 14650 тн усаар усалгаа хийсэн байна. | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12-р сард тухай бүр |
| 2 | Салхины хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах замаар тоосны тархалтыг хязгаарлах | НАБТ | Нүүрс ачиж буулгах талбайн салхины хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэх нь тоосжилтын тархалтыг хязгаарлах ач холбогдолтой ажил бөгөөд салхины хамгаалалтын 1750м хашааны засвар үйлчилгээг тогтмол хийж байна. | Үйлдвэрлэлийн зардлаас | 9-р сард |
| 3 | Шаардлагатай замуудыг хайрган хучилттай болгох | НАБТ | Цагаан хадны НАБТ-н сайжруулсан замаас төв замруу нийлэх уулзварыг 15*40м хэмжээгээр өргөсөн уг замын дэвсэлтийн ажлыг АОДЕ ХХК гэрээлж 2025 оны 5-р сарын 17-20-ны өдөр ажиллаж байна.<br><br>Тухайн замын ажилд ашигласан материалыг үерийн усны зүмпний ухалгаас шороог ашигласан болно. | Үйлдвэрлэлийн зардлаас | 1-12-р сард |
| **Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 4 | Унд ахуйн усны зөөврийн ба түр нөөцлөх савнуудад угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх | Ундны усны дамжлагын цэгүүд | Нүүрс ачиж буулгах талбайн салхины хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэх нь тоосжилтын | 500.0 | 6-р сард |
| **Хөрсөн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах; | Цагаан хад | Өмнөговь аймгийн БОГ-с 2025 оны 7-р сарын 30 нд ирүүлсэн 362 дугаарт албан тоотод Цагаанхад суурьшлын бүсэд байрлах Хандизель ОНӨААТҮГ-н хариуцдаг цэвэрлэх байгууламжийн хүчин чадал хүрэлцэхгүй, байгальд бохир ус хаягдаж байгаа гомдол иргэдээс ирүүлж байгаа тул дээрх шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх үүргийг хойшлуулж байгааг мэдэгдсэн болно. Компанийн хувьд тус цэгийн нөхөн сэргээлтийг хийж, сүүлийн үе шатанд ажиллаж байсан тул тус цэгийг цаашид ашиглах орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. | Үйлдвэрлэлийн зардлаас | 3-12 сар |
| 6 | Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах, хаягдал усыг дахин ашиглах | Цагаан хад | Цагаан хадны ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулж 2025 оны 10 сарын 25-ны байдлаар 6385 м3 бохир усыг цэвэршүүлэн саарал усыг хаягдлын зүмпэн хуримтлуулж байна. | Үйлдвэрлэлийн зардлаас | 3-12 сар |
| 7 | Цагаан хад дахь НАБТ талбайд шинээр ариун цэврийн блок хийж суурьлуулах | НАБТ | Цагаан хад дахь НАБТ-д шинээр ариун цэврийн блок суурьлуулах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллага болон Саади констракшн ХХК-иар гүйцэтгүүлсэн болно<br><br>Ариун цэврийн блокийг 40 тн контайнерийг тоноглож холбогдох инженерийн шугам сүлжээнд холбоот хийж гүйцэтгэсэн. | | 3-6-р сард |
| **Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 8 | Мод сөөг шинээр тарьж ургуулах, усалгаа арчилгаа хийх | Цагаан хад НАБТ | Цагаан хадны НАБТ болон Засварын төв орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх буюу мод тарьж ургуулах ажлын хүрээнд 2025 оны 10 сард намрын тарилтаар 200 ширхэг жигд хайлаас мод орчим мод сөөг тарьсан. | 1,600.0 | 5-р сард 200ш мод тарих |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ зохион байгуулах, | Цагаан хад орчим байгуулсан уст цэг | Тус ажлын хүрээнд засмал замаас зүүн талд 5 км байрлах ууланд 15 боодол өвс 100кг ашигт долооцыг 2025.04.23-24 өдрүүдэд байршуулсан.<br>Зэрлэг амьтны зүүн баруун 2 уст цэгийн шавар шороог цэвэрлэн усаар таслахгүй байх үүднээс 3-4 хоног тутамд хяналт хийн 4-10 сарын хугацаанд 13 удаа рейсээр 200 тн усаар дүүргэх ажлыг авто багийн жолооч нартай хамтран гүйцэтгэдэг. | 1,000.0 | 1-12 сард 1 удаа |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | 3,000.0 | |

**Үйлдвэрлэлийн зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн*

### 4.4.1. Дотоод замаас үүсэх тоосжилыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх

Нүүрс ачиж буулгах талбайн дотоод тоосжилтыг бууруулах зорилгоор нарийн ширхэгтэй нүүрсээр машины дугуйны нөлөөгөөр тоосжилт үүсгэхээс сэргийлж тогтмол хусаж цэвэрлэх, хашаан доторх автомашины хурдны хязгаарыг 5км/цаг байхыг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд зам талбайд усалгаа хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Нүүрс ачиж буулгах талбайн тоосжилт дарах зориулалтаар 2025 оны 9 сарын 30-ны байдлаар 14650 тн усаар усалгаа хийсэн байна.






Зураг 4.4.1. НАБТ-н зам, талбайн тоосжилтыг бууруулах усалгаа болон хурдны хязгаарын тэмдэг

### 4.4.2 Салхины хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах замаар тоосны тархалтыг хязгаарлах

Нүүрс ачиж буулгах талбайн салхины хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж гүйцэтгэх нь тоосжилтын тархалтыг хязгаарлах ач холбогдолтой ажил бөгөөд салхины хамгаалалтын 1144м хашааны засвар үйлчилгээг тогтмол хийж байна.




Зураг 4.4.2.1 Засмал замаас *Цагаан хадны кемп зам засварын ажил явц*

**4.4.3 Шаардлагатай замуудыг хайрган хучилттай болгох**

Цагаан хадны НАБТ-н сайжруулсан замаас төв замруу нийлэх уулзварыг 15*40 метрийн өргөсөн замаа АОДЕ ХХК гэрээлж дэвсэлтийн ажлыг 2025 оны 5-р сарын 17-20-ны өдөр ажиллаж байна.

Тухайн ажилд ашигласан замын материалыг газрын үерийн усны зүдны ухалгаас шороон материалыг ашигласан болно.




**4.4.4 Унд ахуйн усны зөөврийн ба түр нөөцлөх савнуудад угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хий**

Цагаан хадны ажилчдын кемпийн ундны усны нөөцийн 6 м3 багтаамжтай 3 ширхэг савны угаалга ариутгал халдваргүйтгэлийн улирал тутам хийж гүйцэтгэсэн. Унд ны усны нөөцийн савны угаалга, ариутгал халдваргүйтгэх ажлыг Хүслийн Хийморь ХХК-тай хамтран эрүүл ахуйн журамд заасны дагуу сар бүр хийж гүйцэтгэж байна.


ХҮСЛЭН ХИЙМОРЬ ХХК

Umnugobi aimag ,Dalanzadgad 3-р баг,
KHUSLENKHIIMORI3622177@GMAIL.COM,
TEL : 976-70537399, 99115839, 88667006

ЭНЕРЖИ РЕСУРС
ХХК-Д

2025 оны 06 дугаар сарын 15-17-ны өдөр №25/06/15-17/-01

**Усны нөөцийн саванд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн тухай акт**

"ХҮСЛЭНХИЙМОРЬ" ХХК нь "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК-тай хийсэн гэрээний дагуу 2025 оны 06 дугаар сарын 15-17-ны өдөр менежер Э.Наранчимэг, ариутгагч А.Цоодол, Н.Намжилдорж, Э.Далантай нар хамтран Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Таван толгой ордод байрлах "Энержи ресурс" ХХК-ны ундны ус цэнгэгжүүлэх байгууламжын **60тн 30тн 10тн** усны нөөцийн сав, ухаа худагын ус түгээх **18тн-н** нөөцийн сав , 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаан хад суурьшлын бүсэд байрлах "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК-ны унд ахуй усны **12тн, 6тн,** ус түгээх усны машин **18тн** нийт **148тн** унд ахуй ус хадгалах түгээх нөөцийн саванд механик цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.

Тус ажлыг Сантехникийн ахлах инженер албан тушаалтай Г.Бямбацэцэг-г байлцуулан Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн №А/-96, А/-104, А/-81 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад тусгагдсан **"Жавелион"** бодисын 0.03% бодисын уусмал бэлтгэж мананцаржуулах хэлбэрээр ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

**Ажил гүйцэтгэсэн:**

Менежер: .................. /Э.Наранчимэг/

Ариутгагч: .................. / А.Цоодол/

**Хүлээн авсан:**

Албан тушаал: Сантехникийн инженер

Нэр/гарын үсэг/: .................. / Г.Бямбацэцэг/


2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр усны нөөцийн саванд цэвэрлэгээ халдваргүйтгэл хийсэн зураг нь тайлан:

**1.**Цагаан хад кемпийн унд ахуйн хэрэглээний 6тн-н усны нөөцийн саванд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн зураг.

**Зураг 1.** Цэвэрлэхээс өмнө

**Зураг 2.** Цэвэрлэсний дараа

**Зураг 3.** Халдваргүйтгэл

**Зураг 4.** Үлдэгдэл хлор хэмжилт


Зураг 4.4.3.1 *Унд ахуйн нөөц саванд хийсэн угаалга болон ариутгалын тайлан*

### 4.4.5 Шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

Цагаан хаданд байрлах ажилчдын хотхоны ахуйн шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээхийн тулд нэмж ус хийхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн.
- Хаягдлын далангийн 50% орчим гадаргууг түрэлт хийж булсан;
- Цагаан хаданд үйл ажиллагаа явуулдаг бусад аж ахуй нэгжүүд хаягдал усаа тус цэгт хяналтгүйгээр хийлгэхгүй байлгах үүднээс байнгын ажиллагаатай харуулын пост гарган ажиллуулсан,
- Шингэн хаягдлын цэг орчмын 3 байршлаас хөрсний дээж 2-р сард авч, Өмнөговь аймгийн Стандарт хэмжилзүйн лаборатори болон УБ хотын ALS группын лабораторит шинжлүүлэхээр хүргүүлсэн.
- Шингэн хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэсэн,
- Аюулгүй байдлын үүднээс хашааны бүрэн бүтэн байдлыг хангасан,





*Зураг 4.4.5.1. Шингэн хаягдлын цэгт нөхөн сэргээлт хийж буй байдал*

Өмнөговь аймгийн БОГ-с 2025 оны 7-р сарын 30 нд ирүүлсэн 362 дугаарт албан тоотод Цагаанхад суурьшлын бүсэд байрлах Хандизель ОНӨААТҮГ-н хариуцдаг цэвэрлэх байгууламжийн хүчин чадал хүрэлцэхгүй, байгальд бохир ус хаягдаж байгаа гомдол иргэдээс ирүүлж байгаа тул дээрх шингэн хаягдлын цэгийг нөхөн сэргээх үүргийг хойшлуулж байгааг мэдэгдсэн болно.

Компанийн хувьд тус цэгийн нөхөн сэргээлтийг хийж, сүүлийн үе шатанд ажиллаж байсан тул тус цэгийг цаашид ашиглах орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.

**4.4.6 Цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулах, хаягдал усыг дахин ашиглах**

Цагаан хадны ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг горимын дагуу ажиллуулж 2025 оны 10 сарын 25-ны байдлаар 6385 м3 бохир усыг цэвэршүүлэн саарал усыг хаягдлын зүмпэн хуримтлуулж байна.

**4.4.7 Цагаан хад дахь НАБТ талбайд шинээр ариун цэврийн блок хийж суурьлуулах**

Цагаан хад дахь НАБТ-д шинээр ариун цэврийн блок суурьлуулах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллага болон Саади констракшн ХХК-иар гүйцэтгүүлсэн болно

Ариун цэврийн блокийг 40 тн контайнерийг тоноглож холбогдох инженерийн шугам сүлжээнд холбоот хийж гүйцэтгэсэн.



*Зураг 4.7.1 Цагаан хад дахь НАБТ талбайд хийсэн шинээр ариун цэврийн блок*

**4.4.9. Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ**

Цагаан хадны НАБТ болон Засварын төв орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх буюу мод тарьж ургуулах ажлын хүрээнд 2025 оны 10 сард намрын тарилтаар 200 ширхэг жигд хайлаас мод орчим мод сөөг тарьсан.

Зэрлэг амьтны зүүн баруун 2 уст цэгийн шавар шороог цэвэрлэн усаар таслахгүй байх үүднээс 3-4 хоног тутамд хяналт хийн 4-10 сарын хугацаанд 11 удаа рейсээр 180 тн усаар дүүргэх ажлыг авто багийн жолооч нартай хамтран гүйцэтгэдэг



*Зураг 4.4.8.1 Цагаан хад НАБТ болон Засварын төвийн гадаа мод тарилтын зохион байгуулав.*

### 4.4.9. Зэрлэг амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ

Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгагдсан биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд засмал замын зүүн талд 5 км байрлах ууланд 15 боодол өвс 100кг ашигт долооцыг 2025.04.23 өдрүүдэд байршуулсан.

2025.04.24 өдөр зэрлэг амьтны зүүн баруун 2 уст цэгийн шавар шороог цэвэрлэн усаар дүүргэх ажлыг эхлүүлсэн.

Уст цэгийг усаар таслахгүй байх үүднээс 3-4 хоног тутамд хяналт хийн, 4-10 сарын хугацаанд 12 удаа рейсээр 200 тн усаар дүүргэх ажлыг авто багийн жолооч нартай хамтран гүйцэтгэдэг.



*Зураг 4.4.8.1 Цагаан хад орчимд зэрлэг амьтдад зориулж өвс байруулж буй байдал*



*Зураг 4.4.7.2 Цагаан хад орчимд зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг цэвэрлэн ус хийж буй байдал*

## 4.5. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үеийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 1. | Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх | Төв зам-Гавуугийн худаг хайрганы орд | Дотоод замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарыг тогтоож, мөрдөлтөд хяналт тавьх, замын тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах, зам талбайн тогтмол цэвэрлэгээг 14 хоногт 2 удаа хийх, тоосжилт ихтэй үед замын усалгааг 7 хоногт 2-р удаа хийх гэх зэрэг арга хэмжээг авч байна. | Үйлдвэрлэлийн зардлаас | 12 |
| 2. | Зам сайжруулах, арчилгаа хийх | Төв зам-Гавуугийн худаг хайрганы орд | Уурхайн дотоод болон тээврийн шороон замуудад тогтмол засвар, арчилгааг улиралд 2-3 удаагийн давтамжтай хийгдэж байна. Зам талбай дахь шаардлагагүй зам гарцыг хаах, грейдер ашиглан тэгшлэх эвдрэл гэмтэлтэй замын дагуу материал дэвсэлт хийж хөмсөг сэргээх, хог хаягдал болон овортой хад чулууг цэвэрлэн зайлуулах зэргээр сайжруулалтыг хийж гүйцэтгэсэн. | Үйлдвэрлэлийн зардлаас | тогтмол |
| **Хөрсөн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 3 | Шатах тослох материалаар хөрс бохирдохоос сэргийлж ажлын байрны орчимд асгаралтаас сэргийлэх хэрэгсэл байрлуулах; | Хайрганы орд орчимд | Ажлын байрны орчимд тос, тослох материалаас үүдэлтэй хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор шатах тослох материалыг ашиглах, хадгалах талбайд асгаралтаас сэргийлэх иж бүрдлийг байрлуулсан ба ажилчдад тос, тослох материалтай журмын дагуу ажиллах зааварчилгаа, сургалт зохион байгуулсан. | Үйл ажиллагааны зардлаас | 6-р сард |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Хог хаягдал цуглуулах сав болон тэмдэг тэмдэглэгээг байрлуулах; | Хайрганы орд орчимд | Ажлын байр болон үйлдвэрлэлийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай байрлалуудад хог түр хадгалах цэгийг үүсгэн, хог ангилан ялгах зориулалтын савнуудыг тэмдэг тэмдэглэгээтэйгээр байрлуусан. Ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах сэвдээр сургалт, зааварчилгаа өгсөн. | Үйл ажиллагааны зардлаас | 5-р сард |
| **Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр** | | | | | |
| 5 | Шинээр салаа зам үүсгэх, хөрсний элэгдэл эвдрэл үүсгэхгүй байх талаар тээвэрлэлт хийх талаар ажилчдад сургалт, яриа хийх. | Тээвэрлэлт гүйцэтгэж буй ажилчид | Шинээр салаа зам үүсгэх, хөрсний элэгдэл, эвдрэл үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 20 ажилтанд сургалт зохион байгуулсан бөнөөл сургалтын үеэр зөвшөөрөгдсөн замаар хөдөлгөөнд оролцох,шаардлагагүй шинэ зам үүсгэх нь хөрсний эвдрэл үүсгэх, тоосжилт нэмэгдүүлэх эрсдэлтэй гэх зэрэг мэдээллийг өгсөн ба яриа хэлэлцүүлэг байдлаар харилцан санал солилцсон. | Үйл ажиллагааны зардлаас | 5-8 сард |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | Үйл ажиллагааны зардлаас | |

**4.5.1 Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, цэвэрлэгээ хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх**

Дотоод замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.Үүнд:

- Хурдны хязгаарыг тогтоож, мөрдөлтөд хяналт тавьж тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулсан.
- Зам талбайн тогтмол цэвэрлэгээг 14 хоногт 2 удаа хийж байна.
- Тоосжилт нэмэгдэх үе буюу хуурайшилт ихтэй нөхцөлд замын усалгааг 7 хоногт 2-р удаа хийж байна.



Зураг. 4.5.1 *Замын усалгааг хийж байгаа байдал*

Түүнчлэн тээврийн замын дагуу хөдөлгөөний хурдыг хянах зорилгоор шаардлагатай цэгүүд дээр хурдны хязгаар заасан тэмдэг 6ш, чиглэл заасан тэмдэг 3ш, хориглох тэмдэг 2ш, зогс тэмдэг-2ш , зогс" тэмдэг – 2 ширхэгийг тус тус байршуулснаар дотоод замаас үүсэх тоосжилт мэдэгдэхүйц буурсан.

### 4.5.2 Зам сайжруулах, арчилгаа хийх

Уурхайн дотоод болон тээврийн шороон замуудад тогтмол засвар, арчилгааг улиралд 2-3 удаагийн давтамжтай хийгдэж байна. Зам талбайн ашиглалт дээр шаардлагагүй зам гарцыг хаах, грейдер ашиглан тэгшлэх эвдрэл гэмтэлтэй замын дагуу материал дэвсэлт хийж хөмсөг сэргээх, хог хаягдал болон овортой хад чулууг цэвэрлэн зайлуулах зэргээр замын байдлыг сайжруулсан. Цаашид хуваарийн дагуу замын сайжруулалт, арчилгааг тасралтгүй хийх байдлаар төлөвлөн ажиллаж байна.




Зураг. 4.5.2 *Замын тэгшилгээ, хамгаалах хөмсөг хийж байгаа байдал*

### 4.5.3 Шатах тослох материалаар хөрс бохирдохоос сэргийлж ажлын байрны орчимд асгаралтаас сэргийлэх хэрэгсэл байрлуулах

Ажлын байрны орчимд тос, тослох материалаас үүдэлтэй хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор шатах тослох материалыг ашиглах, хадгалах талбайл асгаралтаас сэргийлэх иж бүрдлийг байрлуулсан ба ажилчдад тос, тослох материалтай журмын дагуу ажиллах зааварчилгаа, сургалт зохион байгуулсан.




Зураг. 4.5.3 *Асгаралтын иж бүрдлийг байрлуулсан байдал*

### 4.5.4 Хог хаягдал цуглуулах сав болон тэмдэг тэмдэглэгээг байрлуулах

Ажлын байр болон үйлдвэрлэлийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах, хог тарж хийсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод журамд заасны дагуу өнгөний кодчилол, тэмдэг тэмдэглэгээ бүхий хогийн савнуудыг шаардлагатай байрлалд байршуулсан ба ажилчдад сургалт мэдээллийг өгсөн.




Зураг. 4.5.4 *Өнгөний кодчилолын дагуу хогийн савнуудыг байрлуулсан ба сургалтын бүртгэл*

### 4.5.5 Шинээр салаа зам үүсгэх, хөрсний элэгдэл эвдрэл үүсгэхгүй байх талаар тээвэрлэлт хийх талаар ажилчдад сургалт, яриа хийх

Шинээр салаа зам үүсгэх нь хөрсний эвдрэл үүсгэх, тоосжилтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдад сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 20 ажилтан хамрагдсан бөгөөд сургалтын үеэр зөвшөөрөгдсөн замаар хөдөлгөөнд оролцох, шаардлагагүй шинэ зам үүсгэх нь хөрсний эвдрэл үүсгэх болон байгаль орчинд сөрөг нөлөөтэй талаарх мэдээлэл өгсөн ба яриа хэлэлцүүлэг байдлаар харилцан санал солилцсон.



Зураг. 4.5.5 *Ажилчдад сургалт мэдээлэл өгч байгаа байдал*

## 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын Гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хаягдлын овоолгыг налуулж, хэлбэршүүлэх | Уурхайн хаягдлын овоолго | Нөхөн сэргээлтийн ажлыг хаягдлын овоолгын зүүн хойд хэсэгт, холбогдох аргачлалын дагуу, стандартын шаардлагад нийцүүлэн 2025 онд нийт **10 га** талбайг налуулж хэлбэршүүлсэн. | Уулын ажлын зардлаас зарцуулах | 12.4 га |
| 2 | Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих | Уурхайн хаягдлын овоолго | 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан **14.8 га** талбайг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу шимт хөрсөөр хучин цаашид биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлэн болгов. | Уулын ажлын зардлаас зарцуулах | 9.92 га |
| 3 | Шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах, усалгаа арчилгаа хийх | Уурхайн хаягдлын овоолго | Уурхайн хаягдлын овоолго дээр шимт хөрсөөр хучсан 7 га талбайд хучин, нутгийн ургамал болон мод, сөөг тарималжуулан усалгааны системтэй бүрэн холбож биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байнахийлгэв. | 90,000.0 | 5 га |
| 4 | Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нэмэгдүүлэх | Цогтцэций сум | Цэций хорооллоос Галерей кемп хүртэлх 400м явган хүний зам дагуу хайлаас, улиас болон олон наст зүлэг, наранцэцгээр ургамлан хашлага хийж, Цэций | | 8,000ш |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чиглэлд ногоон байгууламж үүсгэж ургамлан хашлага хийх | | хороолол орчимд 5 га талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. | Тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас | |
| 5 | Цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах | Өвөрхангай аймаг Хэнтий аймаг | Шинэ Хархорум хотод хамгаалалтын ойн зурвас байгуулах чиглэлд "Энержи Ресурс" компани 54 га талбайд 20.000 ширхэг шилмүүст, 20.000 ширхэг навчит, нийт 40.000 мод тарьж эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран амжилттай гүйцэтгэсэн | | 50,000ш |
| 6 | Цогтцэций сумын хашаатай айл өрхөд тарьц суулгац олгож амьдарч буй орчноо ногооруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | Цогтцэций сум | "Модтой хашаа" төслийг 5 дахь жилдээ хэрэгжүүлж 2025 онд нийт 121 айл өрхөд 682 ширхэг модны суулгацыг олгож, зөвлөмж өгч ажилласан. | | 1,000ш |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | **90,000.0** | |

### 5.1. Хаягдлын овоолгын талбайг налуулж хэлбэршүүлэлт хийх

"Ухаа худаг" уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу **10 га** талбайд хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг хаягдлын овоолгын зүүн хойд хэсэгт, холбогдох аргачлалын дагуу, стандартын шаардлагад нийцүүлэн хийсэн бөгөөд налуугийн хажуугийн өнцөг нь дунжаар 18 градус ба 4 м өргөнтэй дэвсгээр тусгаарлагдсан тус бүр нь 30 м хүртэл урттай 5 шатлал бүхий талбай юм.




Зураг 5.1.1. *Хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбай*

### 5.2. Хаягдлын овоолгын хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих

Уурхайн хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 10 га талбайд шимт хөрсөөр хучих ажлыг хийж гүйцэтгэсэн.Хучилт хийсэн шимт хөрсний зузааныг уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу 0.3 метрээс багагүй хэмжээтэй байхаар хучилтын ажлыг явуулсан.



*Зураг 5.2.1. Хаягдлын овоолгын талбайг шимт хөрсөөр хучиж буй байдал*

## 5.3. Шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах, усалгаа арчилгаа хийх

Хаягдлын овоолгын хэлбэржүүлж шимт хөрсөөр хучсан 7 га талбайд мэргэжлийн байгууллагатай хамтран биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж байна. Биологийн нөхөн сэргээлтийн явцад нутгийн бут сөөгийг бортоготой суулгацаар болон усан үрлэгч төхөөрөмж буюу хөрс сийрүүлэгч, нэмэлт бордоо, чийг баригчийг нутгийн ургамлын үртэй хольж нөхөн сэргээлтийн талбайд 10см зузаантай жигд цацаж гүйцэтгэсэн. Үерийн усны урсац нь хөрсний элэгдэл эвдрэл үүсэхэд ихээр нөлөөлдөг учир дэвсэг дагуу хамарлах болон шуудуу ухаж даавуун бетон буюу цемент бүхий нэмэлт хольцтой нэхмэл даавуун материалыг ашиглан ус зайлуулах шуудууг хийсэн. Нөхөн сэргээлтийн талбайд 4 байршилд нийт 120 тонн бүхий усны нөөцийн савыг байршуулан дуслын усалгааны систем ашиглан усалгаа хийгдэж байна.



*Зураг 5.2.1. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын явцын зураг*

## 5.4. Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нэмэгдүүлэх чиглэлд ногоон байгууламж үүсгэж ургамлан хашлага хийх

Цогтцэций сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлж иргэдийн амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Цэций хорооллоос Галлерей кэмп хүртэлх 400м явган хүний зам дагуу хайлаас, улиас болон олон наст зүлэг, наранцэцгээр ургамлан хашлага хийж гүйцэтгэсэн. Мөн Цэций хороолол орчимд 55.000 м2 зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн.



*Зураг 5.4.1. Цэций хорооллоос Галлери кэмп хүрэх ургамлан хашлага*



*Зураг 5.4.2. Цэций хороолол болон нийтийн эзэмшлийн ногоон байгуулам зүлэгжүүлэлтийн ажил*

## 5.5. Цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд шинэ Хархорум хот ерөнхий төлөвлөлт, хамгаалалтын ойн зурвас байгуулах төлөвлөгөөний дагуу “Энержи Ресурс” ххк нь 12.000 шилмүүст мод 28.000 навчит модыг A5,A9 хувиарлагдсан 52 га талбай дээр нийт 40.000 ширхэг модыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн. Модны төрөл зүйлийг тухайн бүс нутгийн

уур амьсгал хөрсний онцлогт нийцүүлэн сонгосон бөгөөд усалгаа арчилгаа “Энержи ресурс” ххк 3-н жилийн хугацаанд хариуцан хийж гүйцэтгэнэ.



*Зураг 5.5.1 Шинэ Хархорум хот мод тарилтын ажлын зураг*

Мөн Хэнтий аймаг Хэрлэн сумын нутаг Өлзийт баг Чандганы талд байрлах Цөлжилт газрын доройтол бууруулах чиглэлд тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг 05-р сарын 10-наас 06-р сарын 18 хооронд 50.000 мянган ширхэг мод тарьж ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



*Зураг 5.5.2 Хэнтий аймаг Тариалангийн хамгаалалтын  тарилтын ажлын зураг*

### 5.6. Цогтцэций сумын хашаатай айл өрхөд тарьц суулгац олгож амьдарч буй орчноо ногооруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах

Цогтцэций сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор "Модтой хашаа" төслийг 5 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа ба тайлант онд хавар, намрын мод тарилтын үед нийт 138 айл өрхөд 780 ширхэг модны суулгацыг үнэ төлбөргүй олгож, мод бут тарих, арчлах зөвлөмжийг өгж ажилласан. Мөн төслийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилготойгоор пэйж хуудас хөтлөн ажиллуулж байгаа ба энэхүү хуудсаар дамжуулан олон нийтэд мэдлэг олгох, заавар зөвлөмжийг өгч байгаа нь үр өгөөжтэй байна.



*Зураг 5.6.1 Модны суулгац тарааж буй болон авсан суулгацаа бэлдсэн талбайд тарьсан байдал.*

## 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | Говь гурван сайханы БЦГ-н Баяндалай сумын хэсэг | Өмнөговь аймгийн Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 600кг ашигт долооцыг хүлээлгэн өгөв. | 3,200.0 | 400кг |
| 2 | Говийн ховор, нэн ховор амьтан ургамлын зүйлийг хамгаалах | Говь гурван сайханы БЦГ-н Баяндалай сумын хэсэг | Өмнөговь аймгийн говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын ургамлын судалгаа хийлгэсэн. | 10,000.0 | 8-9 сард |
| 3 | Байгалийн тооройн бүлгэмдлийг хашиж хамгаалах | Өмнөговь аймгийн Ханбогд сум | Өмнөговь аймгийн Номгон сумын Гуагийн тоорой хэмээх газарт 450 м$^2$ талбай бүхий тоорой ойн санг хашиж хамгаалсан. | 1,000.0 | 0,7 га |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Хууль бус ан, тэдгээрийн гаралтай эд, эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх” төсөлд дэмжлэг үзүүлэх | Өмнөговь аймгийн Цогтцэций сум | Өмнөговь аймгийн байгаль орчны газраас дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Цогтцэций сумын хэмжээнд хийгдэх хулгайн антай тэмцэх хөтөлбөрт 5.8 сая.төг-ийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. | 5,800.0 | 1 удаа |
| | | | | 20,000.0 | |

## 6.1 Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд, биологийн төрөл зүйлийг хамгаалах болон экосистемийн тэнцвэрт байдлыг дэмжих зорилгоор “Энержи ресурс” ХХК нь уулын туруутан болон бусад зэрлэг ан амьтдын идэш тэжээлийн хангамжийг сайжруулах тэжээлийг тайлант онд Биологийн төрөл зүйлийг хамгаалах биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэв. Тайлант онд тус компани Өмнөговь аймгийн Говь Гурван Сайхан Байгалийн Цогцолборт Газрын хамгаалалтын захиргаанд 600кг ашигт долооцыг хандивлан өгч, амьтдын өвөлжилтийн үед үүсэх идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтдын тоо толгой, амьдрах орчны тогтвортой байдлыг хадгалахад бодит хувь нэмэр оруулсан.



*Зураг 6.1.1. Ашигт долооц хүлээлгэн өгч буй нь*



Ашиг долоох хүлээлцэх акт

Биологийн төрөл зүйлийг хамгаалах биотехникийн ажлын хүрээнд Энержи Ресурс ХХК нь Өмнөговь аймгийн Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 600кг ашигт долооцыг хүлээлгэн өгөв.

Хүлээн авсан:
Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга ............ Б.Батаа

Хүлээлгэн өгсөн:
Энержи ресурс ХХК-ийн Байгаль орчны ажилтан ............ Г. Амаржаргал

*Зураг 6.1.2. Ашигт долооц хүлээлгэн өгсөн акт*

## 6.2 Говийн ховор нэн ховор амьтан ургамлын зүйлийг хамгаалах

2025 оны тайлант онд Говийн бүсийн нэн ховор амьтан, ургамлын зүйлийн бүрдлийг хамгаалах, тухайн бүс нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор “Энержи Ресурс” ХХК-ны захиалгаар “Авралын эрэлд” ХХК-ийн мэргэжлийн баг Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар-т ургамал болон амьтны иж бүрэн судалгааг хийж гүйцэтгэсэн.

Судалгааны ажлын үндсэн зорилго нь говийн экосистемийн онцлогт тохирсон ургамлын бүлгэмдэл, амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархалтын хандлага, хамгаалалтын байдалд үнэлгээ өгөхөд оршсон юм. Судалгааны баг газар дээрх хээрийн судалгаа, фото мониторинг, зүйлийн тодорхойлолт, GPS байршлын тэмдэглэл зэрэг орчин үеийн судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэсэн болно.

Үүний үр дүнд ургамлын бүрдлийг хэв шинжийн дагуу 9 үндсэн хэв шинжид ангилан, нийт 47 овгийн 320 гаруй зүйлийн гуурст дээд ургамлыг бүртгэн тодорхойлсон байна. Бүртгэгдсэн ургамлуудын дийлэнх нь хуурай говийн нөхцөлд дасан зохицсон хаг, сөөг, сөөгөнцөр төрлийн зүйлүүд бөгөөд зарим нь тухайн бүсийн ховор, хамгаалалт шаардлагатай зүйлд тооцогддог.

Мөн судалгааны хүрээнд Монгол орны нэн ховор ургамлын жагсаалтад багтсан “хонин арц” (Juniperus pseudosabina Fisch. et C.A. Mey) ургамлын тархалтын зураглалыг боловсруулж, тухайн зүйл ургамлын экологийн нөхцөл, ургах орчны онцлог, тархалтын хязгаарыг тогтоосон. Энэхүү үр дүн нь цаашид ховор ургамлын хамгаалал, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, бүс нутгийн биологийн олон янз байдлыг хадгалах бодлогын баримт бичиг боловсруулахад чухал суурь мэдээлэл болох ач холбогдолтой юм.




*Зураг 6.2.1 Ургамлын судалгаа хийгдсэн байдал ба хонин арцны тархалт*

**6.3 Байгалийн тооройн бүлгэмдлийг хашиж хамгаалах**

Тайлант онд тооройн бүлгэмдлийг хамгаалах, устаж болзошгүй модлог ургамлын тархалтыг хадгалах зорилгоор Өмнөговь аймгийн Номгон суманд орших “Гуагийн тоорой” хэмээх тоорой бүхий ойн санг хашиж хамгаалах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус ойн сан нь голын хуурай сайр дагасан, марааалаг (элсэнцэр, сул барьцтай) хөрстэй бүсэд оршдог бөгөөд байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд тооройн сэргэн ургалт буурч, зарим хэсэгт устаж үгүй болох эрсдэл нэмэгдсэн байв. Үүнд ялангуяа малын бэлчээрийн дарамт, хөрсний нягтрал, үрийн соёололт муу байх зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Иймд байгалийн унаган төрхийг хадгалах, тооройн ургалтын нөхцөлийг сайжруулах, залуу суулгацын хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 477 м$^2$ талбайг төмөр торон хашаагаар хашиж хамгаалах ажлыг төлөвлөж хэрэгжүүлж байна.

Тус талбай нь Цогтцэций сумаас 250 км-ийн зайд, Номгон сумын нутаг дэвсгэрийн баруун хэсэгт байрлах бөгөөд ургамлын бүлгэмдлийн хувьд тооройгоос гадна элсэрхэг хөрсөнд ургадаг сөөгөнцөр болон өвслөг ургамлын цөөн зүйл бүртгэгдсэн байна.

Энэхүү ажлын хэрэгжилт нь тухайн бүсийн тооройн ойн генетик нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах, цаашид тооройн нөхөн сэргээлтийн судалгаа, тарималжуулалтын ажлын суурь болох чухал ач холбогдолтой юм.





*Зураг 6.3.1 Хашиж хамгаалахаар төлөвлөсөн газрын төлөв байдлын зураг*

**6.4. Хууль бус ан, тэдгээрийн гаралтай эд, эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх" төсөлд дэмжлэг үзүүлэх**

Тайлант онд "Энержи Ресурс" ХХК нь Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын чиглэл, зөвлөмжийн дагуу дуйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Цогтцэций сумад хэрэгжиж буй "Хулгайн антай тэмцэх хөтөлбөр"-т нийт 5.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэв.






*Зураг 6.4.1 Хууль бус ан, тэдгээртэй тэмцэх төсөлд оролцсон байдал*

Мөн дуйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Цогтцэций сумын Хангинах, Тугийн цохио орчмыг хариуцсан идэвхтэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжиж дулаан өвлийн хувцас, олон хиймэл дагуул дэмждэг гар утас, шаардлага хангасан 2 нүдний дуран, өврийн дэвтэр зэрэг хариуцаж байгаа газар нутагтаа ажиллахад шаардлагатай хэрэгслээр хангасан.





Зураг 6.4.1 *Хулан хамгаалах өдрийн сургалт болон идэвхттэн байгаль хамгаалагч нарыг урамшуулсан байдал*

## 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энержи Ресурс ХХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд орон нутгийн малчдад өвөл хаврыг өнтэй давахад нь туслах зорилгоор жил бүр өвс, тэжээлийн тусламжийг 2009 оноос хойш жил бүр үзүүлсээр ирсэн.

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх | Нөлөөллийн бүсийн айл өрх | Цогтцэций сумын 4 багийн 350 малчин өрх, уурхайн нөлөөллийн бүсийн 16 малчин өрх, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Манлай сумдын малчин өрхүүд болон аюулгүй фондод нийт 9,000 боодол өвс, 1800 уут тэжээлийн дэмжлэг үзүүлсэн. | Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас | 6000 боодол өвс |

Тайлант жилд нийт 9,000 боодол өвс, 1800 уут тэжээлийг Дорнод аймгийн Булган сумд үйл ажилладаг “Өег гурил” ХХК-иас худалдан авч “Ухаа худаг”-ийн нөөцийн цэгт төвлөрүүлж, нөөцлөх хураах, хадгалах, малчдад хүлээлгэн өгөх ажлуудыг зохион байгуулсан. Цогтцэций сумын 4 багийн 350 өрх, “Ухаа худаг” уурхайн нөлөөллийн бүсийн 16 малчин өрхөд 5490 боодол өвс, 1128 уут тэжээлийг хандивласан. Мөн Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Манлай сумдын малчин өрхүүд болон аюулгүй фондод 3510 боодол өвс, 672 уут тэжээлийг хандивласан.





*Зураг 7.1. Малчдад өвс, тэжээл өгч буй байдал*

## 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Телевизийн нэвтрүүлэг бэлтгэж түгээх | Цогтцэций сумын соёлын биет бус өв болох Говь шанхын уртын дууг таниулан, | Говь Шанхын уртын гурван дууг сэргээн таниулах зорилгоор “Холч морь”, “Өндрийн өвс”, “Хурдан сайхан” дуунуудыг түүхийн хамт, клипжүүлэн Централ ТВ- | Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас | Жилд 1 удаа |

| | |
|---|---|
| сэргээн алдаршуулах | ийн Монгол өв соёл нэвтрүүлэг болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. |

Манай компани нь 2009 оноос хойш холбогдох хууль ба компанийн нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр дараах гол ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд :

- Холбогдох хуулийн дагуу төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө археологи палентлогийн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 2013 онд Говь шанхын уртын дууг заах сургагч багшийн сургалт явуулж, зохиогчийн эрхийн патентыг Цогтцэцийн сумын Соёлын төвийн нэр дээр авах ажлыг зохион байгуулсан.
- 2014 онд Ганжуур Данжуур судрыг Төвд хэлнээс хөрвүүлэн хэвлүүлэх ажлыг “Цогт цагийн хүрдэн” ТББ –тай хамтран гүйцэтгэж, Улсын төв номын санд хүлээлгэн өгсөн.
- Цогтцэцийн жонон морин хуурын татлагын сургалтыг 2 жилийн хугацаанд зохион байгуулж, сургалтанд хамрагдсан хүүхдүүдээс бүрдсэн морин хуурын хамтлаг байгуулж, хамтлагийг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээг хүлээлгэн өгсөн.
- Цогтцэций суманд байрлах Монгол улсын баатар Т.Борын нэрэмжит музейн нэг танхимыг тохижуулсан.
- Цогтцэций сумын хэмжээнд соёлын биет болон биет бус өв тээгчдийн судалгааг хийж, нэгдсэн бүртгэлийг тус суманд хүлээлгэн өгсөн.

2025 онд Монгол үндэсний соёлын өвөө сэргээн таниулах зорилгоор Өмнийн говийн ард түмний соёлын гайхамшигт биет бус өв болох Говь Шанхын уртын гурван дууг сэргээн таниулах, нутгийн залуусын дунд түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх зорилгоор Энержи Ресурс компаниас санаачлан Уртын дуучин МУСТА О.Оюун-Эрдэнэтэй хамтран “Холч морь”, “Өндрийн өвс”, “Хурдан сайхан” дуунуудыг түүхийн хамт, клипжүүлэн Централ ТВ-ийн Монгол өв соёл нэвтрүүлэг болон олон нийтийн сүлжээнд байрлуулан түгээсэн. Цаашид “Говь Шанхын уртын гурван дуун”-д зориулан нэмэлт контент бүхий нэвтрүүлгийг тогтмол давтамжтайгаар бэлтгэн хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.




*Зураг 8.1. Монгол өв соёл нэвтрүүлэг*

## 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9.1 | Химийн бодисын агуулахад хадгалж байгаа бодисуудыг асгаралт, гоожилтоос урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг тогтмол хийх | Химийн бодисын агуулах | “Химийн бодисын удирдлага зохицуулалтын журам”-ын дагуу химийн бодис ашиглагддаг байршлуудад хуваарийн дагуу үл тохирлыг залруулж хяналт тавин ажиллав. | 2,000.000 | Улирал бүр |
| 9.2 | Хийн алдагдал илрүүлэгч автомат төхөөрөмжийг суурилуулах | Химийн бодисын агуулах | Химийн агуулахад хадгалагдаж буй хий ялгаруулдаг химийн хорт бодисонд өртөх эрсдэлээс сэргийлэх болон химийн аюултай бодис, бүтээгдэхүүнийг агуулах ерөнхий шаардлага болох MNS 6458:2014 дагуу хийн алдагдал илрүүлэгч *Sensepoint XCD* автомат төхөөрөмжийг 2025 онд суурилуулан ашиглаж эхэлсэн. | 8,000.000 | Жилд удаа |
| 9.3 | Химийн хорт болон аюултай бодисын ослын үед ажиллах төлөвлөгөөний дагуух практик сургалт хийх | Химийн бодисын агуулах Химийн бодисын агуулах | Химийн хорт болон аюултай бодисын ослын үед авах арга хэмжээний практик сургалт нь химийн бодисын ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө шинэчлэн боловсруулагдаж батлуулсаны дараа хийгддэг болно.Ослын үеийн төлөвлөгөө дахин боловсруулагдаж байна. | Үйл ажиллагааны зардлаас | Жилд удаа |
| 9.4 | Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах | Химийн бодисын агуулах | Химийн лаборатори болон химийн бодис ашигладаг хэсгүүдээс цугларсан химийн бодисны сав болон шилнээс бүрдсэн 201 кг 67-н нэр төрлийн аюултай хог хаягдлыг химийн бодис устгах эрх бүхий байгуулагд хүлээлгэн өгч Аюултай хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу устгуулсан. | 3,000.000 | |
| 9.5 | Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг сургалтанд хамруулах | Ухаа худаг төсөл | Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр батлагдсаны дараа химийн бодисын сургагч багшийн эрх бүхий 2 химич 11-р сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү сургалтанд химийн бодист харьцаж ажилладаг, хяналт | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тавьдаг 100 гаруй ажилтан хамрагдана. | | |
| 9.6 | Гамшгийн эмзэг байдал эрсдлийн үнэлгээ хийлгэх | Ухаа худаг төсөл | Ухаа худаг уурхайн, Цагаан хад суурьшлын бүс, Хангад эксплорейшн ХХК-ийн суурьшлын бүс болон барилга байгууламжид 5 жил тутам 1 удаа эрсдэлийн үнэлгээ хийлгэх журмын дагуу гамшгийн эмзэг байдал эрсдэлийн үнэлгээг хийлгэн баталгаажуулж авсан. | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |
| 9.7 | Уурхайн галын насос станцыг шинэчлэх | Ухаа худаг төсөл | Галын төслийн 1 дүгээр шатны хүрээнд галын насос станц, галын усны цагираг шугам, засварын төвийн галын дохиоллын систем, НБҮ-ийн ХУХ-ийн галын дохиолол, гал унтраах системийн угсралт суурилуулатын ажлыг хийж дуусгасан | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |
| 9.8 | Гамшиг, галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох | Ухаа худаг төсөл | Гашгаас урьдчилан сэргийлэх, гал түймрийн практик сургуулалтыг сар бүр аврах бүлгийн ажилтанууд, улиралд 1 удаа мэргэжлийн байгуулагатай хамтран зохион байгуулсан. | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |
| 9.9 | Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг тогтмол хийх | Ухаа худаг төсөл | Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, ажлын байрны үзлэгийг уурхайн барилга байгууламж, цагаан хад, баруун наран уурхайн барилга байгууламж, туслан гүйцэтгэгч компаниудын барилга байгууламжид тус тус хуваарийн дагуу зохион байгуулж илэрсэн үл тохирлуудыг холбогдох илтгэх хуудсаар холбогдох хэлтэс, алба, нэгжид хүргүүлэн ажилласан. | Үйл ажиллагааны зардлаас | Сар бүр |
| 9.10 | Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээлэх | Ухаа худаг төсөл | Тайлант онд Онцгой байдлын нэгжээс цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг и-майл, мэдээллийн самбарууд, олон нийтийн сүлжээгээр нийт 13 удаагын давтамжтай мэдээлсэн байна. | Үйл ажиллагааны зардлаас | Жилийн турш |
| НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | | **13,800.0** | |

## 9.1 Химийн бодисын хадгалалтын хяналт

Тайлант онд Ухаа худаг салбарын химийн бодисын удирдлага зохицуулалтын журмын дагуу химийн бодис ашигладаг байршлуудад хувиарын дагуу ажлын байрны үзлэг болон дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллав. Мөн химийн агуулахад бодисуудын асгаралт, гойжилтоос урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийж ирсэн. Үүнд асгаралт болсон тохиолдолд яаралтай холбогдох хүмүүсийн дугаар болон анхан шатны арга хэмжээний талаар зааврыг өрөө болгонд байршуулсан. Өдөр тутмын шалгах хуудсаар үзлэгийг хийж үл тохирлыг илрүүлдэг. Мөн сар тутам нэгдсэн үзлэгийн хуудасны дагуу үзлэг шалгалтыг тогтмол хийсэн. Өрөө болгонд асгаралтыг шингээх болон хязгаарлах материал байршуулсан.



ОЛБОРЛОЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЭЛ, ЗӨВЛӨМЖ

2025.06.22

| Хяналтын чиглэл | Ажиглалт | Эрсдлийн түвшин | Зөвлөмж |
|---|---|---|---|
| 01.1.2 Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах | 6. 2025 оны химийн бодистой харьцаж ажиллах ажилтнуудад химийн бодисын аюулгүй ажиллагааны онол, практик сургалт зохион байгуулаагүй байгаа нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдэлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтыг өөрийн зардлаар зохион байгуулсан эсэх" заалт хэрэгжээгүй. | H18 | 6. 2025 оны химийн бодистой харьцаж ажиллагч ажилтнуудад аюулгүй ажиллагааны онол, практикийн сургалт зохион байгуулахыг зөвлөж байна. |
| | 19. Химийн бодисын агуулахад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө байхгүй нь MNS 6458:2014 – Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага "50 тн-оос доош бараа бүтээгдэхүүн хадгалдаг агуулах нь дотроо эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хайрцагтай байх ба 50 тн-оос дээш бараа бүтээгдэхүүн хадгалдаг агуулах нь эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөөтэй эсэх" заалт хэрэгжээгүй. | H18 | 19. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө тохижуулахыг зөвлөж байна. |
| | 20. Хийн алдагдлыг илрүүлэх автомат мэдрэгч (сенсор) төхөөрөмжгүй нь MNS 6458:2014 – Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага "Агуулахад онцгой хортой, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх хий ялгаруулдаг химийн хорт болон аюултай бодис хадгалж байгаа тохиолдолд зайлшгүй хийн алдагдал илрүүлэгч автомат төхөөрөмжийг суурилуулсан байна" заалт хэрэгжээгүй. | H18 | 20. Хий алдагдлыг илрүүлэх автомат мэдрэгч "сенсор"-г заавал суурилуулан техник угсарсан акт үйлдүүлэхийг зөвлөж байна. |




*Зураг 9.1.1 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн үл нийцлийг залруулах хуваарь*

## 9.2 Хийн алдагдал илрүүлэгч автомат төхөөрөмжийг суурилуулах

Химийн агуулахад хадаглагдаж буй хий ялгаруулдаг химийн хорт бодисонд өртөх эрсдлээс сэргийлэх болон химийн аюултай бодис, бүтээгдэхүүнийг агуулах ерөнхий шаардлага болох MNS 6458:2014 дагуу хийн алдагдал илрүүлэгч *Sensepoint XCD* автомат төхөөрөмжийг 2025 онд суурьлуулан ашиглаж эхэлсэн.






*Зураг 9.2.1. Хийн алдагдал илрүүлэг Sensepoint XCD төхөөрөмж*

Энэхүү хийн илрүүлэгч төхөөрөмж нь хүчилтөрөгч ($O_2$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), устөрөгчийн сульфид ($H_2S$), метан ($CH_4$) зэрэг шатамхай болон хорт хийг илрүүлэх зориулалттай бөгөөд сонгосон мэдрэгчээс хамааран аммиак ($NH_3$), хлор ($Cl_2$), хүхрийн давхар исэл ($SO_2$) зэрэг бусад хийг мөн илрүүлэх боломжтой. Хий илэрсэн тохиолдолд төхөөрөмж нь дэлгэц дээр анхааруулга гаргаж, гэрэл болон дууны дохио өгч, шаардлагатай тохиолдолд хяналтын систем рүү дохио дамжуулан мэдээлдэг.

## 9.3 Химийн хорт болон аюултай бодисын ослын үед ажиллах төлөвлөгөөний дагуух практик сургалт хийх

Химийн хорт болон аюултай бодисын ослын үед авах арга хэмжээний практик сургалт нь химийн бодисын ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө шинэчилэн боловсруулагдаж

батлуулсаны дараа хийгддэг болно.Ослын үед ажиллагах төлөвлөгөөг боловсруулж, эрх зүйн шаардлагын дагуу төрийн байгууллагаар батлуулахаар Өмнөговь аймгийн онцгой байдлын газарт хүргүүлсэн, хүлээгдэж байна.

### 9.4 Химийн бодисын савыг эрх бүхий байгууллагад хүргүүлж устгуулах

“Ухаа худаг” уурхайн химийн лаборатори болон химийн агуулахад ашиглагдаж байсан 68 нэр төрлийн нийт 201 кг химийн бодисын шилэн болон хуванцар савны хаягдлыг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль (2017 он), Байгаль орчныг хамгаалах тухай хууль, мөн Аюултай хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, устгах журам (БОАЖ-ын сайдын 2018 оны А/123 дугаар тушаалаар батлагдсан)-ын хүрээнд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Эдгээр бодис, сав баглаа боодлыг “Элемент” ХХК-д хүлээлгэн өгч, тус компанийн аюултай хог хаягдал устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу устгал хийгдсэн. Устгал нь аюултай хог хаягдлыг устгах комиссын хяналт дор, 1200°C температурт шатаах зууханд бүрэн шатаах аргаар явагдсан бөгөөд энэ нь MNS 6458:2014 “Аюултай хог хаягдлын менежмент – Ерөнхий шаардлага” стандартын шаардлагын дагуу хийгдсэн болно.



ELEMENT LLC

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж
Хаяг: НД, 3-р хороо Бүс нуур 12610 гудамж 77 тоот Утас: 7707-3790

2025 оны 10 сарын 20 өдөр Актын дугаар: 25/188 Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: **Паблик сервис ХХК**

*Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт*

| № | Хаягдлын нэр, төрөл | Хэмжээ | Нэгж кг | Аюулын ангилал |
|---|---|---|---|---|
| 1 | Бодисын хоосон шилэн сав | 73.6 | кг | Аюултай |
| 2 | Бодисын хоосон хуванцар сав | 42.7 | кг | Аюултай |
| 3 | Бодисын хоосон төмөр сав | 82.5 | кг | Аюултай |
| 4 | Хөөсөнцөр | 2.2 | кг | Аюултай |
| | Нийт | 201.0 | кг | - |

**Устгасан аргачлал:**

Дээрх **201 кг** аюултай хог хаягдлыг "Элемент" ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200°C -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландфиллдэж устгав.

**Жич:** Устгалд орсон бодисын нэр төрөл, жагсаалт , устгалын зураг хавсаргав.

**Устгал хийсэн**
Химийн мэргэжилтэн /Э.Халиун/

**Акт хүлээн авсан**
................ /................/



Зураг 9.4.2. Химийн бодисын сав боодлыг мэргэжлийн байгууллагад хүргүүлэн устгасан баримт



Зураг. 9.4.1. Аюултай хог хаягдалыг устгаж буй байдал

### 9.5 Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг сургалтанд хамруулах

Тайлант онд Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажллагааны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн А/130 тушаалын дагуу батлуулахаар ХАБЭМ-ийн төвд хүргүүлсэн.

Сургалтын хөтөлбөр батлагдсаны дараа химийн бодисын сургагч багшийн эрх бүхий 2 химич 11-р сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү сургалтанд химийн бодист харьцаж ажилладаг, хяналт тавьдаг 100 гаруй ажилтан хамрагдана.

ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

*БАТЛАВ.*

*(ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА*

*М. УНДРАМ*

*БАТЛАВ.*

*САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЗАХИРАЛ ЗАХИРГАА, ХАРИУЦСАН*

*А.БАТБАЯСАХ*

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСТОЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

**Хөтөлбөр боловсруулсан:** Арьяа Төгсжаргал /Ахлах химич/

Энхтайван Содцэцэг /Химич/

**Хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн:**

**Хөтөлбөр баталсан:** Овог, нэр /албан тушаал/- хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтэд үндэслэн ХАБЭМТ батална

**Хөтөлбөр баталсан огноо:** 2025 он 10 сар 15 өдөр

**Сургалт зохион байгуулагч:** Энержи Ресурс ХХК, сургалтын нэгж

**Холбогдох утасны дугаар:**

**Сургалтын байгууллагын нэр:**

**Сургалт үргэлжлэх хугацаа:** *Лекц 10 цаг, дадлага 2 цаг*

**Багц цаг:** *12 академик цаг /45 минутаар тооцсон/ нь нэг багц цаг болно*

**Нэг удаагийн сургалтад хамрагдах хүний тоо:** 40

**Жилд зохион байгуулах сургалтын нийт тоо:** 3

ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**2.2. СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Сэдэв | Арга зүй | Цаг | Агуулга |
|---|---|---|---|---|
| 1. | ХАБЭА-н хууль, химийн хорт ба аюултай бодисын тухай хууль, дүрэм, журам, олон улсын конвенц | Лекц | *07:30-08:00* | • ХАБЭА-н тухай хууль 12-р зүйл<br>• Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль<br>• Холбогдох дүрэм журмууд<br>• Олон улсын конвенц |
| 2. | Химийн бодистой холбоотой нэр томъёоны тайлбар | Лекц | *08:00-08:30* | • Химийн бодис<br>• Химийн хорт бодис<br>• Химийн аюултай бодис<br>• Хориглосон химийн бодис<br>• Хязгаарласан химийн бодис<br>• Химийн хорт болон аюултай бодисын хаягдал<br>• Химийн хорт болон аюултай бодисыг устгах |
| 3. | Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьчилан сэргийлэх арга хэмжээ | Лекц | *08:30-09:00* | • Хөдөлмөрийн нөхцөл<br>• Хөдөлмөрийн нөхцөлд химийн хорт болон аюултай бодисын үзүүлэх сөрөг нөлөөлөл<br>• Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилласнаас үүдэлтэй хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх |
| 4. | Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ | Лекц | *09:00-09:30* | • Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилласанаас үүдэлтэй мэргэжлээс шалтгаалах өвчин<br>• Химийн бодисын өртөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэхэд ашиглагддаг зөвшөөрөгдөх дээд хэмжээний талаарх ойлголт<br>• Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилласанаас үүдэлтэй мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга |
| 5. | Ажлын байранд ашиглахыг зөвшөөрсөн химийн хорт бодисын хор аюулын талаар | Лекц | *09:30-10:05* | • Химийн бодисын зөвшөөрөл<br>• ХАЛМ гэж юу вэ?<br>• ХАЛМ-д тусгагдах мэдээллүүд<br>• Компанийн хэмжээнд түгээмэл ашиглагддаг химийн хорт болон аюултай бодисуудын хор аюулын талаар |
| 6. | Химийн бодисын таних тэмдэг, хаягжилтын ангилал, хаяг шошго | Лекц | *10:15-11:00* | • Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэгний стандарт MNS 5029:2011 стандарт<br>• Аюултай бодисыг шошголох, ангилах, бэлтгэхэд тавигдах ерөнхий шаардлага<br>• Пиктограммын тэмдэглэгээ |
| 7. | Химийн хорт болон аюултай бодисын тээвэрлэлт, хадгалалт | Лекц | *11:15-12:15* | • Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлтийн журамд тусгагдсан хадгалалт болон тээвэрлэлтийн шаардлагууд |

*Зураг 9.5.1. Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр*

## 9.6 Гамшгийн эмзэг байдал эрсдэлийн үнэлгээ хийлгэх

Тайлант онд "Ухаа худаг" уурхайн болон "Цагаан хад" суурьшлын бүсийн барилга байгууламжид болзошгүй гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулсан.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль" (2020 он)-ийн 7 дугаар зүйл ("Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх"), мөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ын хүрээнд хэрэгжсэн болно.

Дээрх журамд зааснаар, барилга байгууламж бүр нь 5 жил тутамд нэг удаа гамшгийн эрсдэлийн болон эмзэг байдлын үнэлгээ хийлгэж, шинэчлэн баталгаажуулах үүрэгтэй бөгөөд энэ шаардлагын дагуу уурхайн болон суурьшлын бүсийн бүх объектод үнэлгээ хийгдсэн.

Үнэлгээний дүнгээр, уурхайн болон суурьшлын бүсийн барилга байгууламжууд нь гол эрсдэлийн хүчин зүйлсийн хувьд "бага" түвшинд хамаарах дүнтэй гарч, хамгаалалтын бүтэц, аюулгүй ажиллагааны зохион байгуулалт хангалттай түвшинд байгаа гэж дүгнэгдсэн.





ЭНЕРЖИ РЕСУРС ХХК-ИЙН УХАА ХУДАГ УУРХАЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ЗАХИАЛАГЧ
ЭНЕРЖИ РЕСУРС ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ
С.ЛХАГВА-ОЧИР

ГҮЙЦЭТГЭГЧ
ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ МОНГОЛЫН НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН
С.БААТАРСҮРЭН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ЭНЕРЖИ РЕСУРС ХХК-ИЙН УХАА ХУДАГ УУРХАЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2025 он

ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ МОНГОЛЫН НИЙГЭМЛЭГ


ЭНЕРЖИ РЕСУРС ХХК-ИЙН УХАА ХУДАГ УУРХАЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| д/д | Овог нэр | Мэргэжил | Эрдмийн зэрэг цол | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | С.Баатарсүрэн | Галын аюулгүй байдлын инженер. | Техникийн ухааны магистр, Монгол улсын зөвлөх инженер | |
| 2 | Ө.Эрдэнэбилэг | Малын их эмч | Мал эмнэлгийн ухааны доктор | |
| 3 | Б.Баярмаа | Химийн инженер | Химийн ухааны доктор | |
| 4 | М.Должинсүрэн | Цаг уурын инженер | Аюулгүй байдлын доктор | |
| 5 | Б.Батболд | Галын аюулгүй байдлын инженер. | Техникийн ухааны магистр, Монгол улсын Зөвлөх инженер | |
| 6 | Н.Гэрэлтцолмон | Барилгын инженер | Техникийн ухааны магистр, Монгол улсын Зөвлөх инженер | |
| 7 | Б.Туул | Хүний их эмч | Анагаах ухаан магистр | |
| 8 | Г.Болоржаргал | Усны инженер | Ус зүй ухааны магистр | |
| 9 | Г.Пэрлиймаа | Газар зохион байгуулалтын мэргэжилтэн | Газар зүйн ухааны магистр | |
| 10 | О.Эрдэнэтуяа | Газар зохион байгуулалтын мэргэжилтэн | Газар зүйн ухааны магистр | |

ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ МОНГОЛЫН НИЙГЭМЛЭГ

*Зураг 9.6.1. 1Гамшгийн эрсдлийн үнэлгээ -2025*

## 9.7 Уурхайн галын насос станцыг шинэчлэх

Галын аюулгүй байдлын тухай хууль болон Барилгын норм ба дүрэм БНбД 21-04-05-ын шаардлагыг хэрэгжүүлэх, мөн даатгалын аудитын шалгуурыг хангах зорилгоор манай компани 2024 оноос эхлэн галын аюулын чиглэлээр мэргэшсэн *"Таван-Орд"* ХХК-тай гэрээ байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Уг гэрээнд тусгасны дагуу NM Fire брендийн дизель хөдөлгүүртэй иж бүрэн галын насос болон цахилгаан моторoор ажиллах галын насос гэсэн 2 төрлийн иж бүрэн галын насосны систем угсарсан. Уг галын насоснууд нь галын дохиоллын системийн удирдлагын самбараас дохиолол ирэхэд насос автоматаар ажиллахаар NFPA 20 шаардлагын дагуу угсралт суурилуулалт болон тохиргоо хийгдсэн. Мөн насосны удирдлагын самбараас насосыг гараар асаах боломжтой.




*Зураг 9.7.1. Галын насос станцын барилгын ажил болон станцын угсралтын ажил*

## 9.8 Гамшиг, галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх” журамд заасны дагуу жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль"-ийг хийдэг билээ. Энэ хүрээнд манай компани 2025 оны тайлант жилд Уурхайн хэмжээнд нийт 8 байгууламж дээр сэрээнэн дохиогоог ажлуулж нийт 496 ажилтан хамрагдсан. Нийт 7 туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын 110 ажилтан хамрагдсан.



*Зураг 9.8.1 Гамшигийн үед дуут дохиогоор ажиллах сургалтанд оролцсон байдал*

Мөн Ухаа худаг уурхайн Онцгой байдлыг нэгж болон Уурхайн засварын ажилчдад гал түймэр унтраах, аврах 44-р ангитай хамтарсан гал унтраах тактикын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд “Интермед эмнэлэг” яаралтай тусламжийн нэгжийн 2 ажилтан, онцгой байдлын нэгж аврах бүлгийн 7 ажилтан, уурхайн засварын 87 ажилтан, гал түймэр унтраах 44-р ангийн 6 ажилтан нийт 102 хүнийг хамарсан пратик сургалтыг хийв.



Зураг 9.8.2 *Гамшиг, галын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх практик сургалт хийж буй байдал*

## 9.9 Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийх

Тайлант онд Ухаа худаг уурхай, Баруун наран уурхай, Цагаан хад суурьшлын бүс, мөн туслан гүйцэтгэгч компаниудын барилга байгууламжид галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг болон

ажлын байрны ерөнхий үзлэгийг сар бүрийн эхний долоо хоногт 12 төрлийн шалгах хуудсаар тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж, ажилласан.

- Нийт 12 удаагийн сар бүрийн үзлэг зохион байгуулж,
- 3 уурхайн бүс, 1 суурьшлын бүс, нийт 54 барилга байгууламж,
- Мөн 11 туслан гүйцэтгэгч компанийн 26 объект хамрагдсан.
- Үзлэгт нийт ХАБЭА, Галын аюулгүй байдлын 8 мэргэжилтэн, Онцгой байдлын хэсгийн 3 төлөөлөл оролцсон.

Тайлант хугацаанд нийт **137 зөрчлөөс 130 (94.9%)**-ийг бүрэн арилгасан.



*Зураг 9.9.1. ГАУС-ын үзлэгийн шалгах хуудас*



*Зураг 9.9.2. ГАУС-ын үзлэгийн шалгах хуудсаар илрүүлсэн үл тохирлын бүртгэл*

## 9.10. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээлэх

Говийн бүсэд хур тунадасны хэмжээ 50-100 мм байдаг бөгөөд 2025 онд олон жилийн дунджаас 2.1 мм-р илүү унасан байна. Компаны хэмжээнд цаг агаарын урьдчилсан мэдээллийг мэдээллийн самбар болон ажилчдын майл хаягаар өдөр бүр мэдээлэлдэг. Тайлант онд Онцгой байдлын нэгжээс цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг и-майл, мэдээллийн самбарууд, олон нийтийн сүлжээгээр нийт 13 удаагын давтамжтай мэдээлсэн байна.




*Зураг 9.10.1. Компанийн нийт ажилтнуудад и-мэйл хаягаар илгээсэн цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ*

## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал, мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хуванцрын хог хаягдлыг ангилан ялгах | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | 2025 онд хуванцар хог хаягдлыг эх үүсвэр дээр 390 $м^3$ ангилан ялгасан ба тайлант онд Улаанбаатар хотод хаягдал хуванцар сав дахин боловсруулдаг “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК -тай гэрээ хийн нийт 137 м3 хаягдал хуванцар савыг хүргүүлсэн. Одоогоор дахиврын цехд 81 м3 хуванцрыг эх үүсвэрээс татан түр хадгалж байна. | 3,000.0 | 300 |
| 2. | Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах, Бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох | Төслийн талбай<br><br>Цагаан хад НАБТ<br><br>Ажилчдын хотхон | Ухаа худаг төслийн талбайн зам, талбайд хийсэж тарсан хогны цэвэрлэгээг 84 удаа хийж нийт 22 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээнд компанийн бүх хэлтсүүд болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын нийт 63 ажилтан, 1 хово машин, 1 ковш оролцож, хариуцсан талбайн 5 цэгээс нийт $80м^3$ хур хог $16м^3$ салхиар тархсан хог, нийт $96м^3$ хаягдлыг цэвэрлэн зайлуулав. | 800.0 | 4 |
| 3. | Дахин ашиглагдах мод, төмөр зэрэг хаягдлыг 2-догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | 2025 онд нийт 245м3 хаягдал модыг сайтаас татан авснаас 130 м3 модыг орон нутгийн иргэдэд ахуйн хэрэглээнд, мөн 18м3 хаягдал модыг орон нутгийн тохижилтын ТӨК-д түлшний зориулалтаар тус тус өгсөн байна.<br>Түүнчлэн 804 тонн хаягдал төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг “Шанхын | Үйл ажиллагааны зардлаас | 1-12-р сард |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Эрдэнэ” ХХК-д хүлээлгэн өгсөн байна. | | |
| **4** | Хаягдал дугуйг эрх бүхий байгууллагад шилжүүлэх | Хогийн цэг | Тайлант онд хүнд даацын автомашины 14.336 ширхэг хаягдал дугуйг “Үйлсийн дэлгэрэх говь” ХХК, Сайхан улаан оргил ХХК, Эко лонг грийн ХХК-уудад хүлээлгэн өгсөн байна. | Үйл ажиллагааны зардлаас | 1-12-р сард |
| **5.** | Хог хаягдлын устгалын ландфилл байгуулах | Хогийн цэг | Хог хаягдлыг булшлах байгууламжийг байгуулах ажлын хүрээнд 8га талбайг сумын засаг даргын захирамжаар батлуулах, инженер геологи, геотехникийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, компанийн ландфиллын зураг төсөл, төсөв боловсруулах тухай ER24/06 дугаар ажлын даалгаврын дагуу мэргэжлийн байгууллага болох “Эн Си Си Эс” ХХК - аар эскиз зураг болон ажлын зургийг гүйцэтгүүлэх зэрэг ажлыг хийлгээд байна. Ерөнхий төлөвлөлтөөр 2025 онд талбай тэгшилгээний газар шорооны ажил, эхний ландфиллын үүр, уршуулах цөөрөм, хашаа барих, гэрэлтүүлэг хийх, пүүний суурийг байрлуулах ажлуудыг хийхээр төлөвлөсөн ба барилга угсралтын ажлыг дуусгаж хог хүлээн авахад бэлэн байдлаар ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан боловч зах зээлийн нөхцөл байдлаас хамааран энэ онд хийгдэх боломжгүй болсон тул 2026 оны төсөв, төлөвлөгөөнд тусгагдсан байна. | Үйл ажиллагааны зардлаас | 1-12 сард |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **6.** | Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх | Уурхайн засварын төв, 1тн ээзлхүүнтэй IBC сав | 2025 оны 10 сарын 15- ны байдлаар уурхайн засвар болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн 1744 ширхэг аюултай хог хаягдал болох 1 тонны тосны IBC савыг нийлүүлэгч компаниудад буцаан ачуулсан байна. | 4000.0 | 400 |
| **7.** | Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Засварын төвүүд | Төслийн хэмжээнд энэ онд 578тн хаягдал тос үүссэн ба засварын төвд суурилуулсан 50 болон 30тн багтаамжтай зориулалтын нөөцлүүрт цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Об ойл” ХХК ,“Хай би ойл ” ХХК, “Монпити ойл” ХХК -иудтай гэрээ байгуулсан ба хаягдал тосоо нийлүүлэн хамтарч ажиллаж байна. | 3,000.0 | 300 |
| **8.** | Аюултай хог хаягдал болох аккумляторыг нийлүүлэгч болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх | Засварын төв | Хүнд даацын автомашинаас гардаг хаягдал аккумляторыг эх үүсвэр дээр болон дахивар хогийн цэг дээр тусгай талбай дээр хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба дахин боловсруулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж хүдэр”, “Оч гал баян энерги” ХХК-тай 2025 онд гэрээ хийж хамтран ажиллаж байгаа ба тайлант онд нийт 465 ширхэг хаягдал аккумляторыг тус компанид нийлүүлээд байна. | Үйл ажиллагааны зардлаас | 200 |
| **9.** | Аюулын зэрэглэл нь “Х” тэмдэглэгээтэй буюу хяналттай хог хаяглууд дээр шинжилгээ хийлгэж, аюулын | Засварын төвүүд, Дахивар хогийн цэг | Аюултай хог хаягдлын менежментийн хүрээнд үйл ажиллагаанаас үүсдаг зарим хяналттай хог хаягдлыг хуулийн шаардлагын хүрээнд Хими, хими технологийн хүрээлэнд шинжлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн ба зарим хяналттай хог хаягдлын дээжийг ХАЛМ-н хамт хүргүүлсэн. Дээж | 3,000.0 | 3-р улиралд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зэрэглэлийг тодорхойлох | | хүргүүлсэн хаягдлын шинжилгээний хариуг хүлээн авсан ба ХАЛМ -д үндэслэн дүгнэлт гаргуулах ажил хийгдэж байна. | | |
| **10.** | Е- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийх | Бүх алба хэлтэс | Тайлант онд эрх бүхий байгууллага болох "Нью метод" ХХК -д гэрээний дагуу гар станц 20ш, зөөврийн компьютер 9ш, суурин компьютер дэлгэц 4ш, проектор 3ш гэх мэт электрон хаягдлыг устгуулахаар хүлээлгэн өгсөн. | 4,000.0 | 1-12 сард |
| НИЙТ ЗАРДАЛ, мян төг | | | | **17,800,0** | |

**10.1. Хуванцар хог хаягдлыг ангилан ялгалт**

2025 оны 09 дугаар сарын 30-ны байдлаар хуванцар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь 390м3 ангилан ялгасан ба дахиврын цех дээр хуванцар сав преслэгч машиныг суурилуулсан бөгөөд уг машинаар хуванцрыг шахаж овор хэмжээг багасгаж дахин боловсруулах болон орон нутгийн дахивар хүлээн авдаг байгууллагуудад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж ажиллаа. Тайлант онд Улаанбаатар хотод хаягдал хуванцар сав дахин боловсруулдаг "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК -тай гэрээ хийн нийт 137$м^3$ хаягдал хуванцар савыг хүргүүлсэн. Одоогоор дахивар хаягдлын цэг дээр 81$м^3$ хуванцрыг эх үүсвэрээс татан түр хадгалж байна.




Зураг 10.1.1 *Хуванцар савыг дахиврын цехд төвлөрүүлэн дахин ангилан ялгалтыг хийж, дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэхээр тээвэрлэж байгаа байдал*

**10.2. Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох**

Төслийн талбайн зам талбайд хийсэж тарсан хогны цэвэрлэгээг 2025 онд 84 удаа хийж нийт 22 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын Засаг даргын 2025 оны А/47 дугаар албан бичгийн дагуу 2025 оны 02-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд "Энержи Ресурс ХХК" нь туслан гүйцэтгэгч компаниудын хамт хуваарилагдсан талбайг цэвэрлэв. Тус цэвэрлэгээнд компанийн бүх хэлтсүүд болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын нийт 63 ажилтан, 1 хово машин, 1 ковш оролцож, хариуцсан талбайн 5 цэгээс нийт 80$м^3$ хур хог 16$м^3$ салхиар тархсан хог, нийт 96$м^3$ хаягдлыг цэвэрлэн сумын хогийн төвлөрсөн цэг рүү татан зайлуулав.



*Зураг 10.2.1. Ухаа худаг-ийн зам дагуу хог цэвэрлэгээз хийж байгаа байдал*



Зураг 10.2.2. *Сумын ЗДТГ-с өгсөн албан бичгийн дагуу их цэвэрлэгээнд оролцож байгаа байдал*

## 10.3 Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх

2025 онд нийт 245м3 хаягдал модыг сайтаас татан авснаас 130 м3 модыг орон нутгийн иргэдийн ахуйн хэрэглээнд, мөн 18м3 хаягдал модыг орон нутгийн тохижилтын ТӨК-д түлшний зориулалтаар тус тус өгсөн байна.

Түүнчлэн 804 тонн хаягдал төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг "Шанхын Эрдэнэ" ХХК-д хүлээлгэн өгсөн байна.



Зураг 10.3.1. Хаягдал мод,төмөр ачиж байгаа байдал

Хоол үйлдвэрлэлээс үүсдэг хүнсний ногооны хальсыг ашиглан органик бордоо хийх нь хог хаягдлын менежментийн хувьд оновчтой нэгэн арга зам юм. Тиймээс бид кэмп болон нэгдсэн оффисын хоол үйлдвэрлэлээс гарсан ногооны хальс болон малын бууц, мод үржүүлгийн талбайн хог ургамал зэргийг хольж бордоо хийх ажлыг 2020 оноос эхлүүлсэн ба 2025 онд энэхүү ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Энэхүү эхлүүлсэн ажлыг сайжруулахын тулд хоолны хаягдлаар бордоо хийх зориулалтын савыг 2025 оны 11 сарын худалдан авалтын захиалга хүргүүлсэн байгаа.



Зураг 10.3.2. *Хаягдал ногооны хальсаар чийгийн улаан ашиглан бордоо хийж байгаа байдал ба захиалганд хүргүүлсэн байгаа зориулалтын савны байдал*

## 10.4 Хаягдал дугуйг эрх бүхий байгууллагад шилжүүлэх

Тайлант онд хүнд даацын автомашины 14.336 ширхэг хаягдал дугуйг "Үйлсийн дэлгэрэх говь" ХХК, "Сайхан улаан оргил" ХХК, "Эко лонг грийн" ХХК-уудад хүлээлгэн өгсөн байна.




Зураг 10.4.1. *Хаягдал дугуйг ачиж байгаа байдал*

## 10.5 Хог хаягдлын устгалын ландфилл байгуулах

Ухаа худаг нүүрсний уурхайн бүсэд байгуулах хог хаягдлыг булшлах байгууламж нь 10 жил ашиглагдах 90.0x50.0м-ийн хэмжээтэй 9м-н өндөртэй 30.000м3 -ийн багтаамжтай 4 үүртэй, 65.0x35.0x1м хэмжээтэй 2030м3 багтаамжтайууршуулах цөөрөмтэй, 120м2 шороо нөөцлөх талбайтай, 280м2 талбайг цаг агаарын нөлөөнд өртдөг аюултай хог байрлуулах контайнэр байрлуулахаар, бусад аюултай хог хаягдлыг цуглуулах зориулалтаар 4900м2 талбайг, нөөцөд 6400м2 талбайг, 6100м2 талбайг хаягдал дугуйг цуглуулахад мөн нөөцөд 7900м2 талбайг ногооны хаягдал болон хүнсний хаягдлаар бордоо хийх зориулалтаар 920м2, дахивар хаягдлыг түр хадгалах болон дахиврын цех 260м2 хэмжээтэй талбайг тус тус төлөвлөсөн байна. Түүнчлэн хий зайлуулах системтэй, газар доорх усны хяналт- шинжилгээний цооног 4-с доошгүй байх, хог хаягдал хийсэж тарахаас хамгаалсан 2.5м-ээс багагүй өндөр хашаатай байхаар төлөвлөөд байна.

Хог хаягдлыг булшлах байгууламжийг байгуулах ажлын хүрээнд 8га талбайг сумын засаг даргын захирамжаар батлуулах, инженер геологи, геотехникийн судалгааг мэргэжлийн байгууллагаар

хийлгэх, компанийн ландфиллын зураг төсөл, төсөв боловсруулах тухай ER24/06 дугаар ажлын даалгаврын дагуу мэргэжлийн байгууллага болох “Эн Си Си Эс” ХХК -аар эскиз зураг болон ажлын зургийг гүйцэтгүүлэх зэрэг ажлыг хийлгээд байна.

Ерөнхий төлөвлөлтөөр 2025 онд талбай тэгшилгээний газар шорооны ажил, эхний ландфиллын үүр, ууршуулах цөөрөм, хашаа барих, гэрэлтүүлэг хийх, пүүний суурийг байрлуулах ажлуудыг хийхээр төлөвлөсөн ба барилга угсралтын ажлыг дуусгаж хог хүлээн авахад бэлэн байдлаар ашиглалтанд оруулахаар төлөвлөж байсан боловч зах зээлийн нөхцөл байдлаас хамааран энэ онд хийгдэх боломжгүй болсон тул 2026 оны төсөв, төлөвлөгөөнд тусгагдсан байна.




Зураг 10.5.1. *Ландфиллын батлагдсан зураг төсөл*



Зураг 10.5.2. *Ландфиллын ерөнхий төлөвлөлт, харагдах байдал*

**10.6 Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд хадгалж, нийлүүлэгчид буцаан хүргүүлэх**

Хүнд машин механизмын засварын төвийн үйл ажиллагаанаас үүссэн 1 тонны савлагаатай тосыг “Майнс Ап” ХХК-аас худалдан авалтыг хийдэг бөгөөд гэрээнд тусгасны дагуу ашигласан тосны саваа тус компанид буцаан нийлүүлдэг.

2025 оны 10 сарын 15- ны байдлаар 1552 ширхэг аюултай хог хаягдал болох 1 тонны тосны савыг нийлүүлэгч компаниудад буцаан ачуулсан байна.

Түүнчлэн баяжуулах үйлдвэрийн хөөсрүүлэгч урвалжийн сав 192 ширхэгийг нийлүүлэгч компани болох НИП ХХК-д буцаасан байна.



Зураг 10.6.1 *Засварын төвөөс гарсан тонны савыг нийлүүлэгчид буцаахаар цуглуулсан байгаа байдал*

## 10.7 Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Ил задгай хаягдсан тос тосолгооны материал нь хөрс болон гүний усанд бохирдол үзүүлэх сөрөг нөлөөтэй тул хаягдал тосыг байгальд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх нь байгаль хамгаалах чухал арга хэмжээ юм.

Төслийн хэмжээнд энэ онд 578тн хаягдал тос үүссэн ба засварын төвд суурилуулсан 50 тн багтаамжтай зориулалтын нөөцлүүр саванд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Об ойл” ХХК ,“Хай би ойл ” ХХК, “Монпити ойл” ХХК -иудтай гэрээ байгуулсны үндсэн дээр хаягдал тосоо нийлүүлэн хамтарч  ажиллаж байна.



Зураг 10.7.1 *Хаягдал тосыг эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч байгаа байдал*




Зураг 10.7.2. *“Хай би Ойл”ХХК-н тусгай зөвшөөрлийн гэрчилгээ“Монпити Ойл ”ХХК-н “Об Ойл” ХХК гэрээтэй, дагалдах хуудас*

2025 оны БОМТ-н зөвлөмжид хаягдал тосны эх үүсвэр бүрт хаягдал тос түр хадгалах цэгийг стандартын дагуу хийх, хөрсний бохирдлоос хамгаалах, дотоод хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэх гэж тусгагдсаны дагуу сайтын бүх алба хэсэг болон гэрээт компаниудын хаягдал тос хадгалалтын байдлыг үнэлэх хяналтын хуудсыг боловсруулан хяналтын хуудасны дагуу үзлэг хийж, тус бүрт зөвлөмжийг бэлтгэн хүргүүлсэн ба залруулах арга хэмжээний биелэлт 72.5% тай байна. Түүнчлэн уурхайн засварын төвийн хаягдал тос түр хадгалах нөөцлүүр савны газар дээрх талбайг бетондож хөрсөн дээр асгаралт үүсэх сэргийлэх арга хэмжээг авсан.



Зураг 10.7.3. *Уурхайн засварын төвийн хаягдал тосны 2 нөөцлүүрийн дээд талын хөрсийг бетондсон байга байдал*

## 10.8 Аюултай хог хаягдал болох аккумляторыг нийлүүлэгч болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх

Хүнд даацын автомашинаас гардаг хаягдал аккумляторыг эх үүсвэр дээр болон дахивар хогийн цэг дээр тусгай талбай дээр хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба дахин боловсруулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж хүдэр”, “Оч гал баян энерги” ХХК-тай 2025 онд гэрээ хийж хамтран ажиллаж байгаа ба тайлант онд нийт 465 ширхэг хаягдал аккумляторыг нийлүүлээд байна.





Зураг 10.8.1. *Хаягдал аккумляторыг түр хадгалж байгаа байдал ба эрх бүхий байгууллагад шилжүүлсэн дагалдах хуудас*

**10.9 Аюулын зэрэглэл нь “X” тэмдэглэгээтэй буюу хяналттай хог хаяглууд дээр шинжилгээ хийлгэж, аюулын зэрэглэлийг тодорхойлох**

Аюултай хог хаягдлын менежментийн хүрээнд үйл ажиллагаанаас үүсдаг зарим хяналттай хог хаягдлыг хуулийн шаардлагын хүрээнд Хими, хими технологийн хүрээлэнд шинжлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн ба зарим хяналттай хог хаягдлын дээжийг ХАЛМ-н хамт хүргүүлсэн. Дээж хүргүүлсэн хаягдлын шинжилгээний хариуг хүлээн авсан ба бусад хаягдлын шинжилгээг ХАЛМ -д үндэслэн хийж дүгнэлт гаргуулах ажил хийгдэж байна.


ЭНЕРЖИ РЕСУРС ХХК-ИЙН УХАА ХУДАГ САЛБАР

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Л.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2025.06.05 № 232

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ ...БАТБАЯСАХ


ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН /TEST REPORTS OF ACCREDITED LABORATORY/

Бүртгэлийн дугаар: 2025-0173

Захиалагчийн нэр: Энержи ресурс ХХК-ийн Ухаа худаг салбар

Шинжилгээ хийсэн лабораторийн нэр: Түлшний хими, технологийн лаборатори

Шинжилгээний төрөл: Хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүний агуулга, Хартугалганы хэмжээ

Дээжийн нэр: Тосоор бохирдсон шороо, хөрс

Дээжийн тоо, хэмжээ: 1ш

Хүлээн авсан огноо: 2025.06.05

Шинжилгээ эхэлсэн огноо: 2025.09.15

Шинжилгээ дууссан огноо: 2025.10.30

Хэвлэсэн огноо: 2025.10.30

Шинжилгээ явуулсан нөхцөл: Температур 20°C, Чийгшил 40%

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

| Код | Дээжийн нэр | Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж, мг/кг | Шинжилгээний аргын стандарт | MNS 5850:2019 Хүлцэх агууламж, мг/кг | Шинжилгээний дүн, мг/кг |
|---|---|---|---|---|---|
| 263 | Тосоор бохирдсон шороо, хөрс | Хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүний нийт агуулга | САЗ 06-02 | 2000 | 12231.71 |
| | | Хартугалга, Pb | ICP-OES-ийн анализаар | 100 | 85.1 |

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ХУЛАН/

БАТАЛГААЖУУЛСАН ЗАХИРАЛ /Л.ЖАРГАЛСАЙХАН/

Зураг. 10.9.1 *Хяналттай хог хаягдлыг шинжлүүлэхээр Хими, хими технологийн хүрээлэнд хүргүүлсэн албан бичиг болон тостой шороог шинжлүүлсэн хариу*

**10.10 Е- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийх**

Уухайн үйл ажиллагаанаас үүссэн Е- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийж эхлүүлсэн байгаа ба тайлант 64м3 хаягдлыг дахивар хог хаягдлын цэг дээр татан хуримтлуулан түр

хадгалж байна. Түүнчлэн оффисын хэрэглээнээс үүссэн жижиг электрон хаягдал болон хаягдал баттерэй цуглуулах зориулалтын савнуудыг шаардлагатай байрлалуудад тавьсан ба ажилчдад мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Тайлант онд эрх бүхий байгууллага болох “Нью метод ХХК”-д гэрээний дагуу гар станц 20ш, зөөврийн компьютер 9ш, суурин компьютер дэлгэц 4ш, проектор 3ш гэх мэт электрон хаягдлыг устгуулахаар хүлээлгэн өгсөн.




Зураг. 10.10.1 *Е-хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах савнууд байрлуулсан ба ангилан ялгасан байгаа зарим хаягдлын байдал*



*Зураг. 10.10.2 Эрх бүхий байгууллагатай хийсэн байгаа хүчин төгөлдөр гэрээ*

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх | Ухаа худаг, төсөл гэрээт компаниуд | 2025 оны 1-10 сарын байдлаар хийсэн ажлын байрны үзлэгээр нийт 197 байгаль орчн ы үл тохирол илэрсэн ба гүйцэтгэл нь 82% залруулагдсан байна. | Үйл ажиллагааны зардлаас | Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирвол илэрвэл |
| 2 | Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих | Ухаа худаг төсөл | “Энержи ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” уурхайн цогцолбор байгууламж төслийн үйл ажиллагаанд ашиглах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт зөвшөөрлийг хуулийн дагуу авч, ус ашигласны төлбөрийг усны ашиглах дүгнэлтийн дагуу сар тутамд төлж байна. | - | - |
| 3 | Байгаль орчны эрх зүйн төлөвлөгөөт аудит хийлгэх | Ухаа худаг төсөл | Төлөвлөгөөт аудитын нээлтийн хурлыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд одоогоор баримт бичгийн аудитын шат үргэлжилж байна. Харин газар дээрх аудитын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 7–10-ны өдрүүдэд БОАД ХХК-ийн таван аудиторын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 4,000.0 | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хоёр жил тутамд хийлгэх |
| 4 | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд бүтээлч ажил зохион байгуулах | Ухаа худаг төсөл | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Дэлхийн усны өдөр, Бүх нийтийн мод тарих өдөр, Хулан хамгаалах өдрүүдээр олон нийтийн оролцоотой арга хэмжээнүүдийг зохион байгуулав. | 5,000.0 | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдөр 3 доошгүй арга хэмжээ зохион байгуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Нийт ажилтнуудад байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах | Ухаа худаг төсөл | 2025 онд давхардсан тоогоор 3,783 ажилтанд нийт 41,613 хүн/цагийн сургалт зохион байгуулсан. | 2,000.0 | БО-ныг хамгаалах, байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой мэдлэг ойлголтыг түгээх, |
| 6 | Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах, хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох | Ухаа худаг төсөл | Байгаль орчны ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор БОУАӨЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв зэрэг дотоодын болон олон улсын байгаль орчны чиглэлээр тэргүүлэх 7 байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинаруудад давхардсан тоогоор нийт 11 байгаль орчны ажилтан оролцов. | 3,000.0 | ISO стандарт Стандарт болон ногоон байгууламжийн чиглэлээр, Салбарын чиглэлийн аливаа үйл ажиллагаанд санаачлагатай оролцох |
| 7 | Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ISO:14064 стандартыг нэвтрүүлэх | Ухаа худаг төсөл | Компанийн үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн хэмжээг тооцоолж Сингапурын SGS олон улсын баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг компаниар 2024 оны 3 сарын 20 баталгаажуулж, сертификат авсан. Энэхүү баталгаажуулалтыг жил бүр хийж байх бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 13-нд дараагийн баталгаажуулалтын | - | |
| 8 | Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагад хяналт тавьж ажиллах | Ухаа худаг төсөл | Ухаа Худаг уурхайн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компаниудын гэрээнд байгаль орчны чиглэлийн шаардлагуудыг тусгаж, сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хянаж, гүйцэтгэлийг тогтмол үнэлдэг. | - | Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагад хуваарийн дагуу үзлэг шалгалт хийх |
| 9 | Булгийн эх хашиж хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах | Ухаа худаг төсөл | Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах Сайн бичигтийн задгай гэх цэвэр усны ундрага бүхий газрын булгийн эхийг хашиж, хамгаалав. | 8,000.0 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ТЭЗҮ боловсруулах | Ухаа худаг төсөл | Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 40 сая мод тарьж ургуулах Техник эдийн засгийн үндэслэлийг Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл ТББ-р гүйцэтгүүлсэн ба уг баримт бичигт улсын стратеги төлөвлөгөөний зорилтуудын хүрээнд Хангай болон Говийн бүсэд тарьж ургуулах модны тоо хэмжээ, байршил зэргийг тодорхойлсон. | - | |
| **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | | | **22,000.0** | |

**11.1.Байгаль орчны дотоод хяналт**

Компанийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны осол, зөрчил, үл тохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн хэлтэс нь батлагдсан хуваарийн дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулсан. Уг хуваарийн дагуу 3 хэлтэсийн 8 албанд сар бүр, 4 гэрээт компанид улирал тутам ажлын байрны үзлэг хийж гүйцэтгэсэн.

Ажлын байрны үзлэгээр **2025** оны **1-10**-р сарын хооронд **197** үл тохирол илрүүлж, үл тохирол залруулалтын гүйцэтгэл **82%** байна.




Зураг 11.1.1. Тухайн сарын ажлын байрны үзлэгийн хуваарь



| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | C | C1-р зэргийн эрсдэлийг илэрхийлсэн тэмдэгт харагдах байдал муудсан. | | Тэмдэгтийг шинэчлэх. | Засварын менежер, ахлах мастерууд | 2025.10.25 | |
| 35 | C | Хөнгөн тэрэг арын плант дугаар байхгүй. | | Плант дугаар хийх | Засварын менежер, ахлах мастерууд | 2025.10.25 | |
| 36 | C | Дугуй засварын ажил гүйцэтгэж байх үедээ орчноо тусгаарлаагүй. | | Нийт ажилтнуудад сэрэмжлүүлэх. | Засварын менежер, ахлах мастерууд | 2025.10.25 | Дугуй засварчид болон нийт ажилчдад мэдээлэл хүргүүлсэн |

Зураг 11.1.2. Тухайн сарын ажлын байрны үзлэгээр илрүүлсэн үл тохирол болон залруулсан байдал

**11.2.Ус ашигласны төлбөр**

"Энержи ресурс" ХХК-ийн "Ухаа худаг" уурхайн цогцолбор байгууламж төслийн үйл ажиллагаанд ашиглах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт зөвшөөрлийг хуулийн дагуу авч, ус ашигласны төлбөрийг усны ашиглах дүгнэлтийн дагуу сар тутамд төлж байна.

### 11.3. Байгаль орчны аудит

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу Ухаа худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн хоёр жил тутмын аудитыг 2023 онд зохион байгуулж, аудитын явцад илэрсэн үл тохирлыг 95%-ийн гүйцэтгэлтэйгээр залруулан тайланг ӨМАБОГ-т хүргүүлсэн.

Тайлант онд дараагийн аудитын хугацаа тохиож байгаа бөгөөд энэхүү ажлыг гүйцэтгүүлэхээр байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Төлөвлөгөөт аудитын нээлтийн хурлыг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд одоогоор баримт бичгийн аудитын шат үргэлжилж байна. Харин газар дээрх аудитын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 7–10-ны өдрүүдэд БОАД ХХК-ийн таван аудиторын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



"ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМАНД БАЙРЛАЛТАЙ "УХАА ХУДАГ" НҮҮРСНИЙ УУРХАЙН ЦОГЦОЛБОР, ХАНХОНГОР СУМАНД БАЙРЛАЛТАЙ "ЦАГААНХАД" НҮҮРС АЧИЖ-БУУЛГАХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН НЭЭЛТИЙН УУЛЗАЛТ БОЛОН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН ДҮГНЭЛТ

**Удиртгал:**
"БОАД" ХХК болон "Энержи ресурс" ХХК-ийн хооронд байгуулсан ER-25-737 дугаартай "Байгаль орчны аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу 2025 оны 10 сарын 14-ний өдөр "Энержи ресурс" ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь "Ухаа худаг" нүүрсний уурхайн цогцолбор болон "Цагаанхад" нүүрс ачиж-буулгах талбайн үйл ажиллагаанд "БОАД" ХХК-ийн 6 хүний бүрэлдэхүүнтэй аудитын баг Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 10[1] зүйлийг мөрдлөг болгон ажиллаж байна. Байгаль орчны аудитын багийн гишүүд:

| № | Овог, нэр | Чиг үүрэг | Аудитын чиглэл | Аудиторын гэрчилгээ |
|---|---|---|---|---|
| 1. | О.Алтансүх | Ахлах аудитор | Усан орчны менежмент | 2013/001 |
| 2. | Д.Даваадорж | Аудитор | Хөрсөн орчин ба газрын менежмент | 2013/025 |
| 3. | Б.Батдэлгэр | Аудитор | Агаарын чанар, хий ялгаруулалтын менежмент | 2013/035 |
| 4. | Н.Оюунчимэг | Аудитор | Хог хаягдлын менежмент | 2015/010 |
| 5. | Б.Баярмаа | Аудитор | Хими болон аюултай бодисын менежмент | 2015/129 |
| 6. | Т.Нармандах | Аудитор | Биологийн олон янз байдлын менежмент | 2015/119 |

**Нээлтийн уулзалт болон урьдчилсан үзлэгийн зорилго:**
Аудитын багийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэх, "Ухаа худаг" нүүрсний уурхайн цогцолбор болон "Цагаанхад" нүүрс ачиж-буулгах талбайн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, урьдчилсан дүгнэлт гаргах зорилготой.

**Нээлтийн уулзалт болон урьдчилсан үзлэгийн явц:**
Ажлын төлөвлөгөөний дагуу байгаль орчны аудитын нээлтийн уулзалт болон газар дээрх урьдчилсан үзлэгийг 2025 оны 10 сарын 14-ний өдөр "Энержи ресурс" ХХК-ийн Байгаль орчин менежер М.Мөнгөнхонх, байгаль орчны ахлах ажилтан Г.Ган-Эрдэнэ, байгаль орчны ажилтан Г.Амаржаргал, У.Энхтулга нартай хамтран хийсэн.

11952А тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол:

| Дугаар | X | У |
|---|---|---|
| 11952А-1 | 4839519.390 | 536085.354 |
| 11952А-2 | 4839364.841 | 543699.684 |
| 11952А-3 | 4835676.639 | 543725.328 |
| 11952А-4 | 4835630.651 | 536106.290 |

Хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах өнгөний кодчилол бүхий хогийн савнуудыг байрлуулсан.

**Урьдчилсан үзлэгийн дүгнэлт:**
"Энержи ресурс" ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь "Ухаа худаг" нүүрсний уурхайн цогцолбор болон "Цагаанхад" нүүрс ачиж-буулгах талбайн үйл ажиллагаа 2025 оны 10 сарын 14-ний өдрийн байдлаар хэвийн явагдаж байсан.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гэрээний дагуу усан орчны менежмент, биологийн олон янз байдлын менежмент, хими болон аюултай бодисын менежмент, хөрсөн орчин-нөхөн сэргээлтийн менежмент, агаар орчны менежмент, хог хаягдлын менежмент гэсэн үндсэн 6 чиглэлээр хийж байгаа бөгөөд 2025 оны 12-р сард багтаан Захиалагч талд хүрнэ.

АХЛАХ АУДИТОР О.АЛТАНСҮХ



*Зураг 11.3.1. БОАД ХХК-ийн урьдчилсан үзлэгийн дүгнэлт*

### 11.4. Байгаль орчны тэмдэглэлт өдөр

Тайлант онд Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Дэлхийн усны өдөр, Бүх нийтийн мод тарих өдөр, Хулан хамгаалах өдрүүдээр олон нийтийн оролцоотой арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Эдгээр тэмдэглэлт өдрүүдэд компанийн ажилтнууд, Цогтцэций сумын оршин суугчид, сургуулийн сурагчдыг хамарсан нийт 300 гаруй хүн оролцож, байгаль орчныг хамгаалах чиглэлээр мэдээлэл өгч, идэвхтэй оролцоог урамшуулсан.

#### 11.4.1. Дэлхийн усны өдөр

2025 оны дэлхийн усны өдрийг дэлхий нийтээр "Мөсөн голыг хамгаалах нь" уриан дор тэмдэглэсэн. Энержи Ресурс ХХК-ийн хувьд энэ жилийн дэлхийн усны өдрийг ахлах сургуулийн сурагчид болон Ухаа худаг уурхайн ажилтнуудад тус өдрийг танин мэдүүлэх, цэвэр усаа хэмнэх ач холбогдлыг ойлгуулах зорилготой тэмдэглэн өнгөрүүлсэн.

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж мөстлөг, мөсөн голууд хурдацтай хайлж энэ нь дэлхийн цэнгэг усны нөөцөд сөргөөр нөлөөлж байгаа асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах,

мэдээллээр хангах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 33 болон Мөрөөдөл сургуулийн 31 хүүхдэд “Мөсөн гол гэж юу вэ?” “Хүлэмжийн хийн ялгарал нь мөсөн голд нөлөөлөх нь” гэсэн сэдвүүдийн хүрээнд сургалтыг 2025 оны 3-р сарын 21-ны өдөр зохион байгуулсан.



*Зураг 211.4.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт орох үеийн зураг*

Мөн компанийн хэрэгжүүлж буй Цогтцэций сум болон Ухаа худаг уурхайн ажилчдын кемпийн ундны усаар хангах зорилготой “Ундны усыг цэнгэгжүүлэх үйлдвэр”-ийг танилцуулах бичлэг болон сумын иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, уурхай ажилчдын усны талаарх мэдлэгийг шалгах богино хэмжээний бичлэгийг хийж компанийн албан ёсны фейсбүүк хаягт нийтэлсэн. Усны талаарх мэдлэгийг шалгах богино хэмжээний бичлэгт сумын 5 иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн 10 сурагт, уурхайн 11 хүн оролцсон.



*Зураг 311.4.1.2. Богино хэмжээний бичлэгт оролцсон иргэд*







*Зураг 411.4.1.3. Компанийн фейсбүүк хаягт байрлуулсан мэдээлэл*

### 11.4.2. Бүх нийтийн мод тарих өдөр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг **"**Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" болгон тэмдэглэж байна.

Энэхүү өдрийн хүрээнд манай компани "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрт идэвхтэй оролцож, Ухаа худаг уурхайн ажилтнууд хамт олноороо нэгдэн Цогтцэций сум болон уурхайчдын "Цэций" хорооллын зорилтот талбайд нийт 1,000 гаруй мод тарив.





*Зураг 11.4.2.1. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тэмдэглэв*

### 11.4.3. Хулан хамгаалах өдөр

Монгол орны ховор амьтан болох Хулан адууны нөөц, тархац нутгийг хамгаалах, олон нийтэд биологийн олон янз байдлын хамгааллын ач холбогдлыг таниулах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 25-ны өдрийг "Хулан хамгаалах өдөр" болгосон юм.

Хулан хамгаалах өдрийг тохиолдуулан Цогтцэций сумын 1-р сургуулийн 6-9-р ангийн 40 сурагчдад "Хулан хамгаалах өдөр" сэдэвт сургалт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Хулан сэдэвтэй соронзон наалт боршуур тарааж, хичээлийн үр дүнд АХА тэмцээн зохион байгуулж 3 хүүхэд урамшууллаа.






*Зураг 11.4.3.1. Хулан хамгаалах өдрийн сургалт*

## 11.5. Нийт ажилтнуудын байгаль хамгаалах чиглэлээрх сургалт

Ухаа худаг уурхайн хэмжээнд ажиллаж буй үндсэн болон гэрээт компанийн ажилтнуудад ХАБЭА-н тухай хуулийн шаардлагыг хангуулах болон компанийн дагаж мөрддөг аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгааллын журам, дүрмийн хамруулсан сургалтыг 6 сар тутамд зохион байгуулдаг.

2025 онд давхардсан тоогоор **3,783 ажилтанд нийт 41,613 хүн/цагийн сургалт** зохион байгуулсан бөгөөд үүнд:

- **Шинэ ажилтны сургалтанд** – 1,208 ажилтан,
- **Нийт ажилтны сургалтанд** – 2,435 ажилтан,
- **Удирдлагын түвшний сургалтанд** – 140 гаруй удирдах ажилтан тус тус хамрагдсан байна.

Тайлант онд сургалтын агуулгыг шинэчилж, байгаль орчны зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, удирдлагын түвшний ажилтнуудад байгаль орчны бодлого, ирээдүйн чиг хандлагын талаар мэдлэг, мэдээлэл түгээх чиглэлээр сургалтыг оновчтой зохион байгуулсан.




*Зураг 11.5.1. Удирдлагын түвшний ажилтнуудын сургалтын материалаас*




*Зураг 11.5.2. Нийт ажилтнуудын сургалтын материалаас*

## 11.6. Байгаль орчны ажилтнуудыг чадавхжуулах сургалт

Тайлант онд байгаль орчны ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор БОУАӨЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв зэрэг дотоодын болон олон улсын байгаль орчны чиглэлээр тэргүүлэх 7 байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинаруудад давхардсан тоогоор нийт 11 байгаль орчны ажилтан оролцов. Ажилтнууд сургалтын хүрээнд олж авсан мэдлэгээ ашиглан байгаль

орчны хэсгийн үйл ажиллагааг сайжруулах, мөн байгаль орчны шинэ чиг хандлагад нийцсэн ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

### 11.6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний хорооноос ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдэд салбарын онцлогт тохирсон хууль тогтоомжийг сурталчлах сургалт

Ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН, байгууллагуудад салбарын хууль тогтоомжыг сурталчлах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, аюултай хог хаягдал үүсгэгч иргэн, ААН байгууллагуудад “Химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдлын ашиглалт, хамгаалалт, түүнд тавих хяналт” анхаарал асуудлаар хууль тогтоомжыг сурталчлах; мөн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага сургалтанд манай компаниас байгаль орчны ажилтан Ж.Урансайхан болон холбогдох ажилтнууд хамрагдав.

Сургалтын үеэр Өмнөговь аймгийн хог хаягдлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж байгааг танилцуулсан ба,  оролцогчдоос санал хүсэлтээ илэрхийлсэн. Манай компанийн зүгээс дараах саналыг илэрхийлсэн. Үүнд:

- Жил бүр сумаас их цэвэрлэгээг зохион байгуулдаг ба энэ ажилд уурхайнууд хүн хүч гарган оролцдог ч нөхцөл байдал бодитоор сайжирдаггүй ба айл өрхүүдийн хогны асуудалд хариуцлагын асуудлыг зааж өгөх
- Хог хаягдлын үүсгэх үр дагавар, ангилан ялгах ач холбогдол гэх мэт агуулгын мэдлэг мэдээллийг сургуулийн болон сургуулийн өмнөх хүүхдүүдэд сонирхолтой, дадал суухуйц байдлаар өгөх зэрэг саналуудыг хүргүүлсэн.

### 11.6.2.“Монголын говийн Биологийн олон янз байдал”-ын форум, “Байгаль хамгаалалд Хувийн хэвшлийн оролцоо” хэлэлцүүлэг

"Биологийн олон янз байдлын олон улсын өдөр"-ийг тохиолдуулан Байгаль Орчин Уур Амьсгалын Яамнаас зохион байгуулсан "Монголын говийн биологийн олон янз байдал" форумд 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгаль орчны ажилтан Ж.Урансайхан, Э.Уранчимэг нар Өмнөговь аймгийн Даланзадгад хотод оролцов. Энэхүү форум нь говийн бүсэд анх удаа болсон бөгөөд төр, хувийн хэвшлийн олон төлөөлөгчид болох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөр, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчны газар, Монголын ан агнуурын холбоо хамтран зохион байгуулсан бөгөөд Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Дундговь аймгийн байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч, Тусгай хамгаалалттай газар нутгийн дарга, мэргэжилтнүүд, аж ахуйн нэг байгууллага, ТББ-ын төлөөллүүд оролцлоо.

“Байгаль хамгаалалд хувийн хэвшлийн оролцоо” салбар хуралдаанд оролцож, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлэх саналд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нэгдсэн системтэй болох саналаа тусгав.





*Зураг 11.6.2.1. Монголын говийн Биологийн олон янз байдал"-ын форум*

### 11.6.3. "Цөлжилтийн эсрэг ногоон ирээдүй" олон улсын эрдэм шинжилгээний хурал

"Цөлжилтийн эсрэг ногоон ирээдүй" олон улсын эрдэм шинжилгээний хуралд 2025 оны 10-р сарын 3-4-ний өдрүүдэд байгаль орчны ажилтан Н.Төгөлдөр, А.Мөнхчулуун, Б.Төгөлдөр нар ханын илтгэлээр доорхи хоёр сэдвээр оролцов.

- Уулын налуугийн нөхөн сэргээлтэнд нутгийн ургамал тарьмалжуулж, ургуулсан туршилт,ололт амжилт
- Хур борооны ус хуримтлуулах боломжит газарзүйн байршлыг зайнаас тандан судлалаар тогтоох нь нэртэй ханын илтгэлүүдээр оролцов.




*Зураг 11.6.3.1. Хур борооны ус хуримтлуулах боломжит газарзүйн байршлыг зайнаас тандан судлалаар тогтоох нь ханын илтгэл*



**УУЛЫН НАЛУУГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТЭНД НУТГИЙН УРГАМАЛ ТАРИМАЛЖУУЛЖ, УРГУУЛСАН ТУРШИЛТ, ОЛОЛТ АМЖИЛТ**

Н.Төгөлдөр[1,*], М.Мөнгөнхонх[1], Г.Ган-Эрдэнэ[1], Ж.Урансайхан[1], А.Мөнхчулуун[1]
[1] *Энержи ресурс ХХК*
* *Холбоо барих зохиогчийн цахим хаяг: Tuguldur_n@mmc.mn*

**Хураангуй**

Ухаа худаг төслийн талбайн газар нутаг нь байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн завсрын бүсэд, Монгол орны ургамал-газарзүйн 16 тойргоор (Өлзийхутаг, 1989) Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаардаг. Цөлөрхөг хээрийн бүс нь бие даасан эртний үүсэлтэй, зонхилогч ургамлуудтай, энд нийтдээ 705 зүйл ургамал бүртгэгдсэнээс олон наст өвслөгүүд 72%, нэг наст өвслөгүүд 15%, сөөг сөөгөнцрүүд 13% -ийг эзэлдэг. Энэ бүсэд хуурайсаг сөөг сөөгөнцрүүд ургамлын бүлгэмдэлд үзүүлэх үүрэг их, өвслөг ташингын түвшинд дэгнүүлт жижиг үетнүүд, тэр дундаа нам уул толгодын бэл, хөндийд одлог хялгана зонхилдог. Ургамалжилтад хэд хэдэн зүйлийн хялгана, хазааргана, таана, агъ, төлөгчдүү боролзой, дэлхээ тогторгоно, баглуур, буурал янгиц, амманы сэдэргэнэ, өргөст ортууз, цомцогт тэсэг ихээхэн тохиолдохоос гадна түр зуурын борооны чийг шүтэн амьдардаг ямаан шарилж, шүлхий шарилж, хамхаг, хамхуул мэтийн нэг ба цөөн наст зүйлүүд их ургана.

Энержи ресурс ХХК нь хаягдал чулуулгийн овоолгын налуугийн нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд биологийн нөхөн сэргээлтийн ургамалжуулалтын дараах өөрчлөлт ургамлын зүйлийн бүрдэл болон ургамлан нөмрөгийн өөрчлөлтийг тодорхойлох цаашид говийн бүс нутгийн ижил төстэй уул уурхайн нөхөн сэргээлтэд тохирох зүйлийн бүрдлийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийсэн болно. Бид цэгүүдэд мониторингийн бичиглэл хийж ургамалжилтын төлөв байдлыг илэрхийлэх, нөхөн сэргээсэн талбайд үнэлэлт өгөн бүлгэмдэл үүсгэлт, зонхилох зүйл, ургамлын тусгагийн бүрхэц, нэг цэгт бүртгэгдэх зүйлийн тоо, зүйлийн бүрэлдэхүүний амьдралын хэлбэрийн онцлог, доройтлыг илэрхийлэгч зүйлүүдийн эзлэх хувь, усалгаагүй нөхцөл дэх ургамлын ургалтын байдал зэргийг тодорхойлов.

Ухаа худаг төслийн хаягдал чулуулгийн овоолго дээр 2020 онд нутгийн ургамлаар хийсэн биологийн нөхөн сэргээлтийг 43.691590 N; 105.535800 E; 1487.5 м. байршилд Коржинскийн харгана (*Caragana korshinskii* Kom.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylum* (Bunge) Maxim.), Одой хайлаас (*Ulmus pumila* L.), Муркофтын жигд (*Elaeagnus moorcroftii* Wall. ex Schltdl.) гэсэн говь, цөлөрхөг

*Зураг 11.6.3.2 Уулын налуугийн нөхөн сэргээлтэнд нутгийн ургамал тарьмалжуулж, ургуулсан туршилт,ололт амжилт*

### 11.6.4. Нүүрсний хаагдсан уурхай орчмын тогтвортой хөгжлийн орчныг бүрдүүлэх замаар ногоон үйлдвэрлэлийн инновацын орчныг бий болгох төслийн семинар

БНСУ-ын ашигт малтмал, уул уурхайн корпорацийн Монгол дахь төлөөлөгчийн газар Комир Монгол байгууллагаас “Налайх дүүргийн нүүрсний хаагдсан уурхайн орчимд тогтвортой хөгжлийн орчныг бүрдүүлж, ногоон үйлдвэрлэлийн инновацийн экосистемийг бий болгох төсөл”-ийн хүрээнд зохион байгуулагдсан семинарт байгаль орчны ажилтан Н.Төгөлдөр, А.Мөнхчулуун, Э.Уранчимэг нар оролцов.



*Зураг 16.4.1. Налайх дүүргийн нүүрсний хаагдсан уурхайн орчимд тогтвортой хөгжлийн орчныг бүрдүүлэх нь сургалтын сертификат гардан авсан нь*

### 11.6.5. Carbon Conscious Mining in Mongolia сургалт

Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн санаачилгаар, Австралийн Засгийн газрын *Australia Awards – Mongolia* хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Австралийн Куинсландын их сургуультай хамтран хэрэгжүүлсэн **“**Carbon Conscious Mining in Mongolia” сургалтад Байгаль орчны ажилтан Э. Уранчимэг хамрагдав. Мөн Байгаль орчны ахлах ажилтан Г.Ган-Эрдэнэ зочин илтгэгчээр оролцож өөрийн компанийн сайн туршлагыг бусад уул уурхайн компаниудад хуваалцав.

Сургалтын үр дүнд уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн тооцоолол болон ялгаруулалтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний суурь ойлголт, олон улсын хандлага, уул уурхайн салбарт тохирох шийдлүүдийг эзэмшиж, тэдгээрийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.



Зураг 11.6.5.1 Carbon Conscious Mining in Mongolia сургалт

## 11.7. Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагын хяналт

Ухаа Худаг уурхайн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компаниудын гэрээнд байгаль орчны чиглэлийн шаардлагуудыг тусгаж, сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хянаж, гүйцэтгэлийг тогтмол үнэлдэг.

Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг дараах хоёр үндсэн шалгуураар сар бүр хийж, хэрэгжилтийг хянадаг. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийг бууруулах болон гүйцэтгэлийг сайжруулахтай холбоотой хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажил
- Захиалагч талтай байгуулсан гэрээний БО-той холбоотой заалт зөрчигдсөн, үл биелэгдсэн нөхцөл

2025 онд уурхайн олборлолт, тээвэрлэлт, хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 6 гэрээт компанийн байгаль орчны үйл ажиллагааг үнэлж, сар бүр сайжруулах санал, зөвлөмж өгч ажиллав.



ENERGY RESOURCES LLC

1.6 Байгаль орчны мэдээлэл

**1. Байгаль орчны 09-р сарын ажлын гүйцэтгэл**

2025 оны 09-р сарын ажлын гүйцэтгэл 100%-тай байна.

**2. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

**2.1. Уурхайн зам усалгаанд ашиглаж буй усыг бүртгэх**

2025.08.28-09.27-ний өдрүүдэд 3 усны машин нийт 21930 тонн усыг зам талбайн усалгаа ашигласан байна. Өмнө сартай харьцуулахад усны хэрэглээ 17.4%-р өссөн байна.

| № | Ажилласан техник | Ажилласан байдал | № | Ажилласан техник | Ажилласан байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | HWT010 усны машин | 10940 тонн ус | 6 | HGV012 автогредер | 235.1 мот/цаг |
| 2 | HWT005 усны машин | 5120 тонн ус | 7 | HGV015 автогредер | 390 мот/цаг |
| 3 | HWT006 усны машин | 6320 тонн ус | 8 | HGV018 автогредер | - мот/цаг |
| 4 | HGV010 автогредер | 514.5 мот/цаг | 9 | HGV020 автогредер | 153.1 мот/цаг |
| 5 | HGV011 автогредер | 253.2 мот/цаг | 10 | HGV021 автогредер | 113.4 мот/цаг |

*Зураг 1. Гэрээт компанийн тухайн сард байгаль орчны чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажлын тайлан*



ENERGY RESOURCES LLC

**3.Булгийн эх газар хамгаалалтын хашаа байрлуулах**

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах Сайн бичигтийн задгай гэх цэвэр усны ундрага бүхий газарт булгийн эхийг хамгаалах ажлыг 2025.09.24-09.27-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Хашааны нийт урт 100 метр орчим 510 метр$^2$ газрыг хашиж хамгаалсан. Хашаанд мал амьтан орсон тохиолдолд тууж гаргах зориулалт бүхий 2 хаалга хийсэн. Бүх хашааг гагнан холбож газарт суурилуулсан шонгуудыг бетон цутгаж бэхэлсэн. Тус булаг нь үерийн хүчтэй урсгал дамжин өнгөрдөг тул сайран хэсгийг хашаанд нэмэлт бэхэлгээ гагнан суурилуулсан.

**III-р хэсэг: Дүгнэлт**

**Тайлан бичсэн:**

| | |
|---|---|
| **Албан тушаал:** | ХАБЭА-н ахлах ажилтан |
| **Овог, нэр:** | Г.Бямбаравдан |
| **Гарын үсэг:** | |
| **Огноо:** | 2025.09.30 |

**Дүгнэлт, зөвлөмж / Энержи Ресурс ХХК-ийн БОХАБЭА-н менежер, ахлах ажилтан /**

**Байгаль орчин:**

- Тайлантай танилцав. Саналгүй.

**ХАБЭА:**

- Давтагдсан аюул дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар тайланд тодорхой оруулах
- Тайланд орсон зургийн формат нэг байх дээр анхаарах

| | |
|---|---|
| **Албан тушаал:** | Байгаль орчны ажилтан, ХАБ-ын ажилтан |
| **Овог, нэр:** | Э.Уранчимэг, С.Жамьян-Очир |
| **Гарын үсэг:** | |
| **Огноо:** | 2025.10.02 |

*Зураг 2. Байгаль орчны багийн зүгээс тухайн тайланд өгсөн зөвлөмж, сайжруулалтын санал*

## 11.8. Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ISO:14064 стандартыг нэвтрүүлэх

Энержи Ресурс ХХК-нь 2016 онд CDP (Carbon Disclosure Project)-ын уур амьсгалын өөрчлөлтийн тайланд хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллыг хийж эхэлсэн. 2023 онд хүлэмжийн хийн баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллагын сургалтад хамрагдаж, тооцооллын аргачлалд суралцав. 2023 онд олон улсын хүлэмжийн хийн баталгаажуулалт олгодог, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас сургалт авч тооцооллын аргачлалд суралцаж, компанийн хэмжээнд 2023 онд нийт ялгарсан нийт хүлэмжийн хийн хэмжээг тооцоолж Сингапурын SGS олон улсын баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг компаниар 2024 оны 3 сарын 20 баталгаажуулж, сертификат авсан. Энэхүү баталгаажуулалтыг жил бүр хийж байх бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 13-нд дараагийн баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авсан.



DRAFT

SGS

Statement SG25/0000006

The inventory of Greenhouse Gas emissions in year 2023 of

**MONGOLIAN MINING CORPORATION**

16F, Central Tower, Sukhbaatar District Ulaanbaatar 14200, Mongolia

has been verified in accordance with ISO 14064-3:2019 as meeting the requirements of

**ISO 14064-1:2018**

Direct Emissions
**1,168,554.35** tonnes of $CO_2e$
Indirect Emissions
**29,561,464.43** tonnes of $CO_2e$
Direct and Indirect Emissions
**30,730,018.78** tonnes of $CO_2e$

Authorized by

Susan Law
SEAP Regional Manager
Date: *13 Jan 2025*
Version 1.0

SGS International Certification Services Singapore Pte Ltd
30, Boon Lay Way
#03-01, Singapore 609957

This Statement is not valid without the full verification scope, objectives, criteria and findings available on pages 2 to 8 of this Statement

Page 1 of 8



DRAFT

SGS

**Confidentiality**
The reports and attachments may contain relevantly confidential information of the clients. In addition to being submitted as governmental application or certification documents, the reports and attachments are not allowed to be edited, duplicated, or published without the clients' agreement in written form.

**Avoidance of Conflict of Interest**
The reports and attachments are completely complied with the standards and procedures that related-authorities established. The reports and attachments of auditing process are conduct with fairness and honesty. If not, the auditing institution not only has to bear the relevant compensation duties, but also to receive legal charge and punishment.

This statement shall be interpreted with the GHG assertion of MMC as a whole.

**Verifier Group**
Above statements coincide with auditing process with fairness and impartiality, and aim at the emission of year 2023 of clients.

Lead Verifier: Adrian Lamano

Note: This Statement is issued, on behalf of Client, by SGS International Certification Services Pte Ltd. ("SGS") under its General Conditions for Green Gas Verification Services available at http://www.sgs.com/terms_and_conditions.htm. The findings recorded hereon are based upon an audit performed by SGS. A full copy of this statement, the findings and the supporting GHG Assertion may be consulted at Mongolian Mining Corporation, 16F, Central Tower, Sukhbaatar District Ulaanbaatar 14200, Mongolia. This Statement does not relieve Client from compliance with any bylaws, federal, national or regional acts and regulations or with any guidelines issued pursuant to such regulations. Stipulations to the contrary are not binding on SGS and SGS shall have no responsibility vis-à-vis parties other than its Client.

This Statement is not valid without the full verification scope, objectives, criteria and findings available on pages 2 to 8 of this Statement

Page 8 of 8

*Зураг 11.8.1. SGS Сингапур* компанийн олгосон хүлэмжийн хийн баталгаажуулалтын гэрчилгээ

Цаашид хүлэмжийн хийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ISO 14064-1:2018 "Хүлэмжийн хийн тооцолол ба баталгаажуулалтын менежментийн тогтолцооны стандарт"-ыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв. Энэ хүрээнд 2024 оноос зөрүүгийн шинжилгээ хийж, SGS Сингапур компаниар аудит хийлгэн бэлтгэл ажил ханган ажиллаж байна.

## 11.9. Булгийн эх хаших хамгаалах

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах Сайн бичигтийн задгай гэх цэвэр усны ундрага бүхий газарт булгийн эхийг хамгаалах ажлыг 2025.09.24-09.27-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Хашааны нийт урт 100 метр орчим 510 метр$^2$ газрыг хашиж хамгаалсан. Хашаанд мал амьтан орсон тохиолдолд тууж гаргах зориулалт бүхий 2 хаалга хийсэн. Бүх хашааг гагнан холбож газарт суурилуулсан шонгуудыг бетон цутгаж бэхэлсэн. Тус булаг нь үерийн хүчтэй урсгал дамжин өнгөрдөг тул сайран хэсгийг хашаанд нэмэлт бэхэлгээ гагнан суурилуулсан.








*Зураг 11.9.1. Сайн бичигтийн задгайн булгийн эхийг хашсан байдал*

## 11.10. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ТЭЗҮ

"Энержи ресурс" ХХК нь Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 40 сая мод тарьж ургуулах Техник эдийн засгийн үндэслэлийг Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл ТББ-р гүйцэтгүүлсэн ба уг баримт бичигт улсын стратеги төлөвлөгөөний зорилтуудын хүрээнд Хангай болон Говийн бүсэд тарьж ургуулах модны тоо хэмжээ, байршил зэргийг тодорхойлсон. Мөн Говийн бүсэд ойжуулалт хийх, мод тарьж ургуулахтай холбоотой хээрийн нарийвчилсан судалгааг хийлгэсэн.


ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

ЭНЕРЖИ РЕСУРС ХХК
40.0 САЯ МОД ТАРЬЖ УРГУУЛАХ ТӨСЛИЙН
УРЬДЧИЛСАН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛ

Захиалагч: "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК

Боловсруулсан: МОНГОЛЫН ОЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН НЭГДЭЛ ТББ


МОНГОЛЫН ОЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН НЭГДЭЛ ТББ

ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ, ХАНХОНГОР, БАЯНДАЛАЙ, ЦОГТ-ОВОО СУМАНД МОД ТАРИХААР УРЬДЧИЛАН ТӨЛӨВЛӨСӨН ТАЛБАЙД ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

*Зураг 11.10.1. Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх компанийн ТЭЗҮ*

# 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

## 12.1. Гадаргын ба газрын доорх усны хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээний төрөл | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 12.1.1 | Малчдын гар худгуудын усны түвшин хэмжих болон усны эрдэсжилт болон pH, ЦДЧ | Наймантын Наймдайн хөндийд байрлах малчдын 24 гар худаг | 2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд Наймантын худгийн хэмжилтийг 128 удаа, Наймдайн худгийн хэмжилтийг 104 удаагийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. | 3,300.0 | Сар тутамд хэмжилт хийгдсэн байх |
| 12.1.2 | | Наймантын хөндий болон Наймдайн хөндий 24 гар худаг | 23 худгаас дээж авч дээж авч Ухаа худаг уурхайн усны шинжилгээний лабораторит шинжилгээ хийсэн. | 2,000.0 | 2 Сард нэг удаа |
| 12.1.3 | Ашиглалтын хяналтын цооногийн усны түвшин хэмжих | Наймдайн, Наймантын хөндийд байрлах 13 ажиглалтын цооног | Наймдайн, Наймантын ажиглалтын цооногуудад 1-р сараас 10-р сарын хооронд 65 удаагийн хэмжилтийг хийсэн. | - | Сар тутамд хэмжилт хийгдсэн байх |
| 12.1.4 | Газар доорх усны хяналтын цооногуудын усны түвшин хэмжих | Эргэлтийн усан сан орчмын 4 уурхай орчмын хяналтын 3 цооног | Эргэлтийн усан сан орчим болон Уурхай орчмын 7 цооногт 1-р сараас 10-р сарын хооронд нийт 70 удаагийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. | 1,480.0 | Сар тутам |
| 12.1.5 | Малчдын гар худгуудын усны чанарын хяналт, шинжилгээ | Наймант болон Наймдайн хөндийд байрлах 20 гар худаг | Малчдын 23 гар худгийн уснаас дээж авч Ухаа худаг уурхайн усны шинжилгээний лабораторит шинжилгээ хийсэн. | 1,200.0 | Усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн байх |
| 12.1.6 | Газар доорх усны хяналтын цооногуудаас дээж авах, микро элементийн агуулгыг шинжлүүлэх | Эргэлтийн усан сан 4, уурхайн хяналтын 3 цооног | Нийт 7 цооногоос усны дээжийг авч лабораторит шинжлүүлсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн хяналтын цооногт илэрсэн манганы (Mn) агууламж нь стандартад заасан хэмжээнээс 0.13 мг/л-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна. | 1,700.0 | Сар тутамд хэмжилт хийсэн байх |
| **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | | | **9,680.0** | |

### 12.1.1 Наймантын хөндийн малчдын худгуудын хэмжилт

Наймантын хөндийд байрлах малчдын гар худгуудын усны түвшнийг 2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд сар бүр нэг удаа нийт 128 удаа хэмжиж, бүртгэл хийсэн. Наймантын хөндийн малчдын гар худгуудын усны түвшинг 2025 оны хэмжилтийн үр дүнг доорх графикт харуулав.




График 12.1.1.1. Наймантын хөндийн малчдын худгуудын усны түвшин, 2025 он

2025 оны усны түвшин хэмжилтээс харахад Хармагтай, Маахууз, Хулгарын зэрэг худгуудын усны түвшин хэлбэлзэл багатай байсан бол Хоолойн гучин, Гучин ус, Адгийн ус зэрэг худгуудын усны түвшин хэлбэлзэлтэй байсан.




График 12.1.1.2 Наймантын хөндийн малчдын худгуудын жилийн усны түвшний дундаж, 2019-2025 он

Наймантын хөндийн малчдын худгуудын 2019–2025 оны хоорондох жилийн дундаж усны түвшинг дээрх графикт үзүүлэв. Наймантын хөндийн нийт 13 худгаас 8 худгийн усны түвшин нэмэгдэх хандлагатай байгааг хэмжилтийн дүн харуулж байна. Шугамын худгийн усны түвшин 2019–2024 оны хооронд тогтмол өсөлттэй байсан боловч 2025 онд өмнөх оноос 0.97 м-ээр буурсан

байна. Харин Батчулууны худгийн усны түвшин 2019–2025 оны хооронд тогтвортой, хэлбэлзэл багатай үзүүлэлттэй байсан байна.

2025 оны 9-р сарын хэмжилтээр Хармагтай худгийн ус ширгэсэн байдалтай байсан. Харин 2019–2025 оны хоорондох жилийн дундаж усны түвшний өөрчлөлт харьцангуй бага, дунджаар 2.51 м гүнтэй байжээ. Худгийн битүүмжлэл сул, бүтцийн бүрэн байдал хангалтгүй байснаас шалтгаалан элс, шавар хуримтлагдаж, худгийн эхийг дарсан байх магадлалтай. Үүнээс гадна говийн уур амьсгалын онцлогоос шалтгаалан тунадас багасч, газрын доорх усны сэлбэлт хангалтгүй болсон нь худгийн ундаргыг бууруулж, ус түр ширгэх нөхцөл бүрдүүлсэн байх боломжтой.



Зураг 12.1.1.1 Хармагтай худгийн ширгэсэн байдал, 2025 оны 9-р сар

Малчдын гар худгийн усны түвшний хэлбэлзэл нь тухайн худгийн ашиглалтын байдал, усалж буй малын тоо толгой, тухайн жилийн хур тунадасны хэмжээ, худгийн ундарга болон ул хөрсний онцлогоос хамаардаг. Наймантын хөндийн малчдын худгуудын хэмжилтийн үр дүнд улирлын онцлог, хур тунадасны хэмжээ, мөн хэмжилт хийгдсэн өдөрт мал усалсан байдлаас шалтгаалан усны түвшин хэлбэлзэж байна.

### 12.1.2 Наймдайн хөндийн малчдын худгуудын хэмжилт

Наймдайн хөндийн орчмын малчдын худгуудын суурь мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор 2012 оноос хойш усны түвшний хэмжилтийг тогтмол хийж ирсэн. 2025 оны 1-ээс 10 дугаар сарын хооронд Наймдайн хөндийд байрлах малчдын 11 гар худагт нийт 104 удаагийн хэмжилтийг зөөврийн усны түвшин хэмжигч багаж ашиглан хийж гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлсөн.



Зураг 12.1.2.1. Малчдын гар худгуудад усны түвшин хэмжилт хийж буй нь, 2025 оны 10-р сар

Наймдайн хөндийн малчдын гар худгуудын усны түвшний 2025 оны хэмжилтийн үр дүнг дараах графикт үзүүлэв.




График 12.1.1.3 Наймдайн хөндийн малчдын худгуудын усны түвшин, 2025 он

Наймдайн хөндийн малчдын гар худгуудын усны түвшний хэмжилтийн дүнгээс үзэхэд ихэнх худгуудын усны түвшин хэлбэлзэлтэй байна. Сондуулын худгийн болон Баруун сайрын худгийн усны түвшин бусад худгуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой, хэлбэлзэл багатай байв.




Жилийн дундаж хэмжилтийн үр дүнгээс харахад Наймдайн худаг, Улаан худаг зэрэг худгуудын усны түвшин багасах хандлагатай байсан бол Зүүн сайр, Шангай, Сондуул худгуудын усны түвшин нэмэгдэх хандлагатай байна. Баруун сайр худгийн усны түвшин 2024 хүртэл тогтвортой, хэлбэлзэл бага байсан бол 2024 оноос нэмэгдэх хандлагатай байна.

### 12.1.3 Ашиглалтын хяналтын цооногийн усны түвшин хэмжих

Ухаа худаг төслийн хэрэгцээний ус ашиглалтыг хянах зорилгоор Наймантын хөндийн 7 хяналтын цооногуудын усны түвшний хэмжилтийг 2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд нийт 5 удаагийн хэмжилтийг хийж гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлсөн ба усны түвшин огцом буурсан болон нэмэгдсэн үр дүн ажиглагдахгүй байна.

Хүснэгт 12.1.3.1. Наймантын хөндийн хяналтын цооногуудын усны түвшний хэмжилтийн дүн, 2025 он

| | 1-р сар | 3-р сар | 6-р сар | 8-р сар | 10-р сар |
|---|---|---|---|---|---|
| DZ08EB01 | 72.7 | 75.6 | 76.02 | 77.83 | 73.36 |
| DZ08EB02 | 48.6 | 48.62 | 49.01 | 49.57 | 49.19 |
| DZ08EB04 | 43.74 | 44.51 | 43.67 | 44.73 | 43.61 |
| DZ08EB08 | ГӨД Сав газрын автомат мэдрэгчтэй | | | | |
| DZ08EB06 | 67.82 | 68.02 | 67.67 | 68.26 | 67.72 |
| DZ08EB08 | ГӨД Сав газрын автомат мэдрэгчтэй | | | | |
| DZ09EB11 | 24.87 | 24.04 | 24.54 | 25.75 | 29.3 |
| DZ09EB15 | 56.37 | 61.4 | 55.23 | 62.22 | 56.57 |

DZ08EB01, DZ09EB11, DZ08EB02 цооногуудын усны түвшин жилийн турш буурах хандлагатай байсан. DZ08EB04 болон DZ08EB06 цооногуудын усны түвшин жилийн туршид хэлбэлзэл багатай, харьцангуй тогтвортой байв. DZ09EB15 цооногийн усны түвшин 3 болон 8-р саруудад буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Наймдайн хөндийн 6 хяналтын цооногуудын усны түвшний хэмжилтийг 2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд нийт 5 удаагийн хэмжилтийг хийж тэмдэглэл хөтөлсөн.

Хүснэгт 12.1.3.2. Наймдайн хөндийн ашиглалтын цооногийн усны түвшний хэмжилтийн дүн, 2025 он

| | 1-р сар | 3-р сар | 6-р сар | 8-р сар | 10-р сар |
|---|---|---|---|---|---|
| NK10EB14 | 9.55 | 9.14 | 7.32 | 6.95 | 6.52 |
| NK12-OB03 | 26.17 | 26.3 | 26.33 | 26.91 | 26.32 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| NK12-OB05a | 9.7 | 12.38 | 10.86 | 11.99 | 10.87 |
| NK12-OB07 | 25.83 | 25.97 | 26 | 26.36 | 25.37 |
| NK12-PB06 | 12.23 | 12.34 | 12.32 | 12.91 | 12.28 |
| NK12-OB05b | 7.33 | 7.95 | 7.96 | 8.45 | 7.87 |

NK10EB14 цооногийн усны түвшин жилийн туршид нэмэгдэх хандлагатай байсан. Харин NK12-OB03, NK12-OB07, NK12-OB06 цооногуудын усны түвшин харьцангуй тогтвортой, жилийн турш хэлбэлзэл багатай байсан. NK12-OB05a болон NK12-OB05b цооногуудын усны түвшин жилийн туршид буурах хандлагатай байсан.

### 12.1.4 Газрын доорх усны хяналтын цооногуудын хэмжилт

Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрээс гарсан усыг эргэлтийн усан сан (ЭУС)-д төвлөрүүлж байсан ба ЭУС орчмын газар доорх усанд чанарын хяналт хийх зорилгоор 4 цооногт сард нэг удаа нийт 40 удаагийн хэмжилтийг хийсэн.
Мөн уурхайн олборлолт явуулж байгаа бүсэд гүний усны хяналт хийх зорилгоор 3 цооногт хэмжилт хийсэн. Уурхайн цооногууд нь шатахуун түгээх станц, нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц орчимд байрладаг. Усны түвшин зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж, бүртгэл хөтөлдөг.

Хүснэгт 12.1.4.1. Эргэлтийн усан сан болон уурхайн бүс орчмын усны хяналтын цооногуудын байршил

| № | Цэгийн дугаар | Цэгийн байршил | Цэгийн координат |
|---|---|---|---|
| 1 | Цооног 2 | “Түмэн заг” ХХК-ын харуулын постны зүүн талд | X 43.668286, Y 105.595272 |
| 2 | Цооног 3 | Эргэлтийн усан сангийн зүүн хойно | X 43.664357, Y 105.593947 |
| 3 | Цооног 4 | Эргэлтийн усан сангийн зүүн талд | X 43.655998, Y 105.587902 |
| 4 | Цооног 5 | Эргэлтийн усан сангийн зүүн урд | X 43.651612, Y 105.584215 |
| 5 | Цахилгаан станц | Цахилгаан станцын баруун хойд талд | X 43.673627, Y 105.538163 |
| 6 | Шатахуун түгээх станц | ШТС-ын баруун талд НАБТ тээврийн машин зогсоолын зүүн талд | X 43.657411, Y 105.539755 |
| 7 | Нүүрс баяжуулах үйлдвэр | НБҮ-ийн халаалтын зуухны хойно | X 43.668777, Y 105.535016 |




График 12.1.4.1. Эргэлтийн усан сан орчмын хяналтын цооногуудын усны түвшин, 2025 он

Эргэлтийн усан сан орчмын хяналтын цооногуудын хэмжилтийн үр дүнг дээрх графикт харуулав. ЭУС орчмын 4 цооногт 2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд нийт 40 удаагийн хэмжлтийг хийж гүйцэтгэсэн. Бүх цооногуудын усны түвшин 8-р сараас хойш нэмэгдсэн. Цооног 2-ын усны түвшин 7-р сар хүртэл бага зэрэг буурах хандлагатай байсан ч 8-р сараас 1.10 м-ээс 1.18 м хооронд нэмэгдсэн. Цооног 3-ын усны түвшин 2-р сараас 7-р сар хүртэл хэлбэлзэл багатай байсан бөгөөд 8-р сараас 0.5 м-ээс 0.82 м хооронд нэмэгдсэн.




График 12.1.4.2. Уурхайн бүс орчмын хяналтын цооногуудын усны түвшин, 2025 он

### 12.1.5 Малчдын гар худгуудын усны чанарын хяналт, шинжилгээ

Наймант, Наймдайн хөндийн малчдын 22 худгаас усны дээж авч Ухаа худаг уурхайн дотоодын итгэмжлэгдсэн лабораторит өгч шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг “MNS0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандарттай харьцуулсан. *Лабораторийн шинжилгээний хариуг хавсралтаас харна уу.*



Зураг 12.1.5.1. Малчдын худгуудаас усны дээж авч буй нь

Наймдайн хөндий орчмын нийт 10 худгийн уснаас дээж авч, усны ерөнхий химийн 7 үзүүлэлтийг Ухаа худаг уурхайн дотоодын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 12.1.5.1. Наймдайн хөндийн малчдын гар худгуудын усны шинжилгээний үр дүн, 2025 он

| № | Шинжилгээний үзүүлэлтүүд | MNS 0900:2018 стандарт | Шангай | Сондуул | Наймдайн худаг | Долоодой | Улаан худаг | Зүүн сайр | Сүүжийн худаг | Баруун сайр | Зүүн хирс | Баруун хирс |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өнгө, градус | 20 | **38.6** | **28.1** | **529.7** | **24.6** | **49.1** | **70.2** | **21.05** | **115.8** | **28.1** | 17.5 |
| 2 | ЦДЧ ц/см | 1.0 | **1.17** | **3.03** | 0.97 | **3.39** | **2.71** | **3.59** | **1.09** | **5.57** | 0.84 | **1.35** |
| 3 | Усны орчин, pH | 6.5 – 8.5 | 7.95 | 7.90 | 7.63 | 7.34 | 7.65 | 7.76 | 7.70 | 8.01 | 8.34 | 8.26 |
| 4 | Ерөнхий хатуулаг, мг-экв/л | 7 | 3.54 | **7.49** | **17.46** | **14.88** | **12.60** | 6.05 | 6.58 | **15.69** | 1.05 | 1.97 |
| 5 | Аммоны ион (NN4), мг/л | 1.5 | 0.49 | 0.20 | **9.05** | 0.11 | 0.49 | 0.26 | 0.06 | **2.28** | 0.11 | 0.07 |
| 6 | Нитритийн ион (NO2), мг/л | 1 | 0.05 | 0.05 | 0.06 | 0.03 | 0.06 | 0.03 | 0.03 | 0.05 | 0.07 | 0.01 |
| 7 | Нийт төмөр (Fe), мг/л | 0.3 | 0.25 | 0.06 | **1.36** | 0.13 | 0.05 | 0.10 | ≤0.05 | **0.86** | 0.07 | ≤0.05 |

Наймдайн хөндий орчмын нийт 10 худгийн уснаас дээж авч, усны ерөнхий химийн 7 үзүүлэлтийг Ухаа худаг уурхайн дотоодын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дээрх хүснэгтэд нэгтгэн харуулав. Шинжилгээний үр дүнгээс харахад 9 худгийн усны өнгө Монгол Улсын стандартаас 1.4-26.5 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байсан. Цахилгаан дамжуулах чанар нь Наймдай болон Зүүн Хирсийн худгаас бусад бүх худгуудад стандартаас 1.09-5.57 дахин өндөр гарсан. Ерөнхий хатуулаг нь 5 худгийн хувьд 1.07-2.21 дахин хэтэрсэн байна. Харин Наймдай болон Баруун сайрын худгуудын аммонийн ион ($NH_4^+$) стандартаас 0.75-7.55 мг/л-ээр, нийт төмрийн (Fe) агууламж 0.56-1.06 мг/л-ээр тус тус их гарсан байна.

Хүснэгт 12.1.5.2. Наймантын малчдын гар худгуудын усны шинжилгээний үр дүн, 2025 он

| № | Шинжилгээний үзүүлэлтүүд | MNS 0900:2018 стандарт | Шугамын худаг | Цагаан эрэг | Гучин ус | Бунхант | Батчулуун | Хоолойн гучин | Хулгарын худаг | Адгийн ус | Хулсан ус | Маахууз | Шинэ ус | Хажуу ус |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өнгө, градус | 20 | 14.0 | **91.2** | **70.2** | **185.9** | **21.1** | **24.6** | **70.2** | **143.8** | **28.1** | **42.1** | **157.8** | 17.5 |
| 2 | ЦДЧ ц/см | 1.0 | **2.39** | 0.45 | **4.71** | 0.84 | **4.44** | **4.04** | 0.55 | **2.02** | **3.03** | **1.53** | **1.15** | **4.97** |
| 3 | Усны орчин, pH | 6.5 – 8.5 | 7.89 | 7.69 | 7.47 | 7.95 | 7.65 | 8.09 | 8.14 | 7.81 | 7.90 | 7.69 | 7.99 | 7.65 |
| 4 | Ерөнхий хатуулаг, мг-экв/л | 7 | 6.52 | **7.69** | **11.08** | 3.54 | **12.60** | **7.08** | 2.25 | **9.64** | **7.49** | 6.50 | 3.57 | **12.25** |
| 5 | Аммоны ион (NN4), мг/л | 1.5 | 0.05 | 0.24 | 0.29 | 0.49 | 0.49 | 0.33 | 0.19 | 0.60 | 0.20 | 0.14 | 0.40 | 0.43 |
| 6 | Нитритийн ион (NO2), мг/л | 1 | ≤0.007 | 0.03 | 0.03 | 0.05 | 0.06 | 0.16 | 0.06 | 0.07 | 0.05 | 0.02 | 0.03 | 0.02 |
| 7 | Нийт төмөр (Fe), мг/л | 0.3 | 0.13 | 0.14 | 0.13 | 0.25 | 0.05 | 0.07 | 0.13 | 0.17 | 0.06 | 0.10 | 0.17 | 0.16 |

Наймантын хөндий орчмын 12 худгийн уснаас дээж авч, усны ерөнхий химийн 7 үзүүлэлтийг Ухаа худаг уурхайн дотоодын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дээрх хүснэгтэд нэгтгэн харуулав. Шинжилгээний үр дүнгээс харахад 10 худгийн өнгө стандартаас 1.05-9.3 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байсан. 7 худгийн ерөнхий хатуулаг 0.08-5.6 мг-экв/л-ээр хэтэрсэн байна. Цахилгаан дамжуулах чанар нь 9 худагт стандартаас 2.02-4.71 дахин хэтэрсэн байна.

Наймант болон Наймдайн малчдын худгуудын усны чанарын лаборторийн шинжилгээний үр дүнгээс харахад усны өнгө, цахилгаан дамжуулах чанар, ерөнхий хатуулаг “MNS0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартаас давсан тохиолдол их байна. Эдгээр үзүүлэлтүүдийн хэтрэлт нь тухайн худгийн битүүмжлэл сул, үер гадаргын бохир ус орж нэвтэрсэн байдал, тухайн худгийн эрдэсжилт өндөртэй хөрс, чулуулгийн давхаргаар ус дамжин урсах геологийн онцлогоос шалтгаалсан байж болзошгүй юм.

### 12.1.6 Газар доорх усны хяналтын цооногуудаас дээж авах, микро элементийн агуулгыг шинжлүүлэх

Эргэлтийн усан сан орчмын гүний усны хяналтын 4 цооног, Уурхай орчмын бүсийн 3 цооногоос дээж авч микро элементийн шинжилгээг ALS Group LLC-ын лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг MNS 6148:2010 “Усны Чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ” стандарттай харьцуулж үр дүнг боловсруулсан.

Хүснэгт 12.1.6.1 ЭУС болон Уурхай орчмын хяналтын цооногийн усны микро элементийн шинжилгээний дүн, 2025 он

| Элементүүд | Al | As | Ba | Cd | Cr | Cu | Fe | Mn | Mo | Pb | Sb | Sr | V | Zn | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| MNS 6148:2010 | 0.5 | 0.01 | 2 | 0.003 | 0.07 | 1 | 0.3 | 0.1 | 0.04 | 0.05 | 0.006 | - | 5 | 0.3 | 0.01 |
| Цооног 2 | 0.08 | <0.001 | 0.02 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.08 | 0.01 | 0.03 | <0.02 | <0.04 | 1.18 | <0.01 | 0.07 | <0.01 |
| Цооног 3 | 0.03 | <0.001 | 0.02 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.08 | 0.01 | 0.02 | <0.02 | <0.04 | 0.63 | <0.01 | 0.08 | <0.01 |
| Цооног 4 | 0.09 | <0.01 | 0.03 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.09 | 0.01 | 0.02 | <0.02 | <0.04 | 0.84 | <0.01 | 0.08 | <0.01 |
| Цооног 5 | 0.08 | <0.01 | 0.03 | <0.01 | <0.01 | 0.02 | 0.08 | 0.08 | 0.01 | 0.02 | <0.04 | 2.36 | <0.01 | 0.24 | <0.01 |
| НБҮ | 0.03 | <0.01 | 0.04 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.05 | **0.23** | 0.01 | <0.02 | <0.04 | 1.90 | <0.01 | 0.13 | <0.01 |
| ДЦС | 0.02 | <0.01 | 0.04 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.04 | 0.01 | 0.01 | <0.02 | <0.04 | 4.54 | <0.01 | 0.13 | <0.01 |
| ШТС | 0.13 | <0.01 | 0.04 | <0.01 | <0.01 | 0.01 | 0.07 | 0.01 | 0.01 | 0.02 | <0.04 | 2.20 | 0.01 | 0.06 | <0.01 |

Дээрх хүснэгтэд Эргэлтийн усан сан (ЭУС) болон уурхайн орчмын нийт 7 цооногт хийсэн усны микро элементийн шинжилгээний үр дүнг нэгтгэн үзүүлэв. Шинжилгээний дүнг MNS 6148:2010 “Усны чанар**.** Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартад заасан хэм хэмжээнд тулгуурлан харьцуулсан.

Шинжилгээний үр дүнгээс харахад Нүүрс баяжуулах үйлдвэрийн хяналтын цооногт илэрсэн манганы (Mn) агууламж нь стандартад заасан хэмжээнээс 0.13 мг/л-ээр хэтэрсэн байна.

### 12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

| № | Хяналт шинжилгээний төрөл | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1. | Тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах нарийн ширхэгт тоосонцорыг хэмжих | Ухаа худаг уурхай, Цогтцэций сум | Цогтцэций сум болон уурхай орчим 9 цэг сар бүр, Цагаан хад орчмын 3 цэгт улирал бүр хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Нийт 10 цэг дээр 109 удаа хэмжилт хийхэд 25 тохиолдол стандарт үзүүлэлтээс өндөр үзүүлэлттэй бүртгэгдсэн байна.<br>Цагаан Хад НАБТ дээр бүх сард 0.024мг/м3-ээс 0.109 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй, Цагаан Хад Кемп-д 2-р сард 0.076мг/м3-ээр хэтэрсэн байсан бусад саруудад агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. | 11,400.0 | Сар тутамд хэмжилт хийгдсэн байх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | Уурхайн орчмын агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцрын агууламжийг хянах | Ухаа худаг уурхай | Ухаа Худаг төслийн хамрах хүрээнд тоосжилтын хяналт хийх зорилгоор 2025 оны 1-р сарын 1-ээс эхлэн сургалтын төв дээр байрлуулан 10-р сарын 30-н хүртэлх өдөр бүр тоосны концентрацийн хэмжилтийг хийсэн. Тоосны хэмжилтээр PM2.5 буюу нарийн ширхэглэгт тоосонцрыг 2 минутын дундаж агууламжийг 24 цагт 2 минутын зайн давтамжтай нийт 285 өдрийн агууламжийг тодорхойлсон ба нийт 28 өдөр стандартаас хэтэрсэн байсан. | 4,300.0 | Хэмжилт хийгдсэн байх |
| 3. | Гадаад орчны агаарын чанарын \ $NO_2$, $SO_2$\ хэмжилт хийх | Ухаа худаг уурхай, ЦС, Цэвэрлэх байгууламж, Хогийн цэг, Цагаан хад НАБТ, НБҮ | Агаарын чанарын шинжилгээг 6 цэгт итгэмжлэгдсэн лаборатори Ногоон Титэм ХХК-иар хийлгэсэн. Азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2025 стандарттай харьцуулахад аль ч цэгт хүхэрлэг хий (SO2) болон азотын давхар исэл (NO2) стандартаас давсан үзүүлэлт ажиглагдахгүй байна. | 1,600.0 | Хөндлөнгийн хяналт хийлгэсэн байх |
| 4. | Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу шуугиан хянах | Ухаа худаг уурхай, Цогтцэций сум | Дуу шуугианы хэмжилтийг 10 цэг дээр хийсэн | 400,0 | Хэмжилт хийгдсэн байх |
| 5. | Цахилгаан станцын зуух болон халаалтын газруудын зуухнуудын утааны найрлага хэмжилт хийлгэх | Цахилгаан станц, Галлерей, Цэций хороолол, НБҮ | Цахилгаан станц болон Халаалтын зуухны утааны найрлагын хэмжилтийг мэргэжлийн эрх бүхий байгууллага болох Термокалор ХХК-иар 2025 оны 10-р сарын 29-нд хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн. | 4,000.0 | Хэмжилт хийгдсэн байх |
| | **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | | **21,700.0** | |

### 12.2.1. Гадаад орчны тоосны концентрацийн хэмжилт

Ухаа Худаг төслийн агаарт агуулагдах тоосны концентрацийн хяналт шинжилгээний ажлын хүрээнд Ухаа Худаг уурхай, Цогтцэций сум, Эргэлтийн усан сан зэрэг газруудад 2025 оны 1-р сараас 11-р сар хүртэлх хугацаанд сар бүр тогтмол хийж гүйцэтгэсэн. Тоосны хэмжилтийг Dust Trak TSI 8530 болон 8533 загварын агаар дахь аэрозолийн хэмжээг тодорхойлдог багажаар 9 цэгийг, Oizom dust pro тоосны хэмжилтийн суурин автомат станцаар Нэгдсэн оффис орчмын PM2.5 буюу нарийн ширхэглэгт тоосонцрыг 24 цаг хүртэлх хугацааны дундаж агууламжаар тодорхойлсон. Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2025 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргаж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Хүснэгт 12.2.1.1. *Уурхайн орчмын сар тутмын тоосны хэмжилтийн үр дүн*

| Цэгүүдийн байршил | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сумын төв | 0.046 | 0.094 | 0.036 | 0.025 | 0.016 | 0.019 | 0.022 | 0.016 | 0.025 | 0.009 |
| Галлерей кемп | 0.051 | 0.086 | 0.013 | 0.005 | 0.014 | 0.027 | 0.042 | 0.010 | 0.019 | 0.023 |
| Ундны ус цэнгэгжүүлэх байгууламж | 0.020 | 0.058 | 0.009 | 0.006 | 0.003 | 0.007 | 0.016 | 0.020 | 0.026 | 0.025 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Майга усан сан | 0.018 | 0.049 | 0.023 | 0.01 | 0.006 | 0.02 | 0.011 | 0.020 | 0.020 | 0.036 |
| 212-р пост | 0.170 | 0.041 | 0.012 | 0.025 | 0.084 | 0.063 | 0.316 | 0.054 | 0.029 | 0.04 |
| Ойн зурвас | 0.030 | 0.024 | 0.020 | 0.019 | 0.021 | 0.020 | 0.024 | 0.008 | 0.038 | 0.022 |
| Нэгдсэн оффис | 0.019 | 0.024 | 0.019 | 0.018 | 0.022 | 0.015 | 0.017 | 0.011 | 0.021 | 0.027 |
| Хогийн цэг | 0.052 | 0.088 | 0.019 | 0.006 | 0.022 | 0.015 | 0.030 | 0.035 | 0.042 | 0.069 |
| Эргэлтийн усан сан | 0.020 | 0.028 | 0.021 | 0.035 | 0.011 | 0.020 | 0.021 | 0.018 | 0.040 | 0.024 |
| Лаборатори | 0.129 | 0.074 | 0.015 | 0.022 | 0.021 | 0.021 | 0.019 | 0.022 | 0.034 | 0.021 |




Дээрх графикаас харахад PM 2.5 нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийн үр дүнд 1-р сард 5 цэгт агууламж 0.0085 мг/м3-ээс 0.1325 мг/м2-ээр хэтэрсэн, 2-р сард 7 цэгт агаарын чанарын стандартаас 0.0035 мг/м3-0.0565 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байна. Дээрхи хэмжилтийн цэгүүдээс 212-р пост дээр хамгийн ихээр буюу нийт 10 удаа хэмжилт хийхэд 7 хэмжилтэнд стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байна. 9-р сард Ойн зурвас, Нэгдсэн оффис, Эргэлтийн усан сан орчимд 0.0005 мг/м3-ээс 0.0045 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан. 10-р сарын хувьд 212 пост дээр агаарын чанарын стандартаас 0.005 мг/м3 хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаж байна. 212 постны хувьд Баруун Наран уурхайн нүүрс тээврийн хүнд даацын машинууд олноор зөрж өнгөрдөг нь хэмжилтийн үр дүн хэтрэх үндсэн суурь шалтгаан болдог.

### 12.2.2. Гадаад орчны тоосны концентрацын өдөр тутмын хэмжилт

Ухаа Худаг төслийн хамрах хүрээнд тоосжилтын хяналт хийх зорилгоор Oizom dust pro тоосны хэмжилтийн суурин автомат станцыг уурхайн нэгдсэн оффисийн урд талд 2025 оны 1-р сарын 11-ний өдөр суурьлуулан тоосжилтийг хянаж байна.






Зураг 12.2.2.1 Oizom dust pro тоосны хэмжилтийн суурин автомат станцыг суурьлуулав

Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2025 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргасан.




График 12.2.2.1 *Ухаа худаг уурхай орчмын нарийн ширхэгт тоосонцорын өдөр тутмын концентрацийн хэмжилтийн үр дүн, 2025 он*

Дээрх графикаас харахад PM2.5 тоосонцор эхний улирал буюу 1-ээс 3 сар хүртэлх хугацаанд нийт 9 удаа агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцрын агууламжийн хэмжээ стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй ба **2-р сард** тоосжилт харьцангуй өндөр буюу MNS стандартаас хэтэрсэн тохиолдол хамгийн олноор бүртгэгдсэн байна. 2-р улирал буюу 4, 5 болон 6-р сарууддад 6 удаа хэтэрсэн үзүүлэлт ажиглагдсан ба 7, 8, 9-р сарууддад нийт мөн 6 удаа агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй бол 10-р сард нийт 7 удаа хэтэрсэн үзүүлэлтэй байна.

Мөн тоосны концентрацийн утга стандартаас өндөр гарсан тохиолдлууд нь хүйтний улиралд агаарын инверсийн үзэгдэл үүсэж тоос үүссэн орчиндоо тогтож хуримтлагддаг, уурхайн зам усалгаа аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлагддаг, зэрэг шалтгаантай холбоотой байж болох бол хаврын улиралд салхины хүч нэмэгдэж, шороон шуургатай өдрүүдийн тоо нэмэгддэг, агаарын чийг багасаж хуурай үе тохиолддог нь үндсэн суурь нөхцөл болох талтай. Компанийн зүгээс үйл ажиллагаанаас

үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор эргэлтийн усан санг технологийн нөхөн сэргээлт хийж байгаа ба уурхайн олборлолтын хэсгийн технологийн зам дээр дулааны улиралд тогтмол усалгаа хийсэн, тоосжилт бага үүсгэдэг замын материал дэвссэн. Мөн хүйтний улиралд уурхайн олборлолтын технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах тал дээр анхаарал хандуулж ажиллаж байна.

**Цагаан хадны тоосны концентрацийн хэмжилтийн дүн**

Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайн тагаарт агуулагдах тоосны концентрацийн хяналт шинжилгээний ажлын хүрээнд кемп, НАБТ болон ойролцоох харьцуулах цэгт 2025 оны 2, 4 болон 10-р сард хэмжилтүүдийг хийж гүйцэтгэсэн.




График 12.2.2.2 *Цагаан хад орчмын нарийн ширхэгт тоосонцорын концентрацийн хэмжилтийн үр дүн, 2025 он*

Дээрх графикаас харахад PM 2.5 нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийн утга Цагаан Хад НАБТ дээр бүх сард 0.024мг/м3-ээс 0.109 мг/м3-ээр хэтэрсэн үзүүлэлттэй, Цагаан Хад Кемп-д 2-р сард 0.076мг/м3-ээр хэтэрсэн байсан ба бусад саруудад агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

**12.2.3. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ**

Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг хийнүүдийг итгэмжлэгдсэн “Ногоон титэм” лабораториор шинжүүлсэн болно.





*Зураг 12.2.3.1 Гадаад орчны агаарын чанарын хэмжилт*

Хүснэгт 12.2.3.1. *Агаарын шинжилгээний дүн*

| Цэгийн нэр үзүүлэлт | Агаарын чанарын MNS4585:2016 стандарт | Цахилгаан станц | Цэвэрлэх байгууламж | Уурхайн төв цэг | Хогийн цэг | Шатахуун түгээх станц | Цагаан хад НАБТ | Нүүрс Баяжуулах үйлдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий **SO2, мкг/м3** | 450 **мкг/м3** | 51.51 мкг/м3 | 112.42 мкг/м3 | 102.97 мкг/м3 | 82.17 мкг/м3 | 110.61 мкг/м3 | 186.90 мкг/м3 | 155.62 мкг/м3 |
| Азотын давхар исэл, **мкг/м3** | 200 **мкг/м3** | 45.76 мкг/м3 | 26.56 мкг/м3 | 56.09 мкг/м3 | 79.08 мкг/м3 | 52.29 мкг/м3 | 98.67 мкг/м3 | 83.21 мкг/м3 |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, **мкг/м3** | 60 **мкг/м3** | <1ppm | <1ppm | <1ppm | <1ppm | <1ppm | <1ppm | <1ppm |
| Хүхэрт үстөрөгч, **мкг/м3** | - | Илрээгүй | | 1.68 мкг/м3 | Илрээгүй | | | |

Дээрх дүнгүүдээс харахад азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад аль ч цэгт хүхэрлэг хий (SO2) болон азотын давхар исэл (NO2) стандартаас давсан үзүүлэлт ажиглагдахгүй байна.

### 12.2.4. Гадаад орчны дуу шуугианы хяналт шинжилгээ

Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, ойн зурвасын ойролцоох 10 цэгт дуу шуугианы хэмжилтийг 2025 оны 9-р сарын 9-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үр дүнг MNS 4858:2025 дуу шуугианы стандарттай харьцуулахад 6 цэгт стандартаас 0.9 дБ-ээс – 12.0 дБ-ээр давсан үзүүлэлттэй байгаа бол бусад 4 цэгт даваагүй үзүүлэлттэй байна . Хэмжилт хийх үед салхины хурд ойролцоогоор 12 км/цаг орчим байсан болно. Таван толгой орчмын цэгт уурхайн нүүрс тээврийн хүнд даацын машинууд, Сумын зүүн хойд цэгт автомашины хөдөлгөөн их байсны улмаас дуу шуугиан стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байсан. Бусад цэгүүдийн хувьд салхи ихтэй байсны улмаас дуу шуугиан стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байсан.

График 12.2.4.1 *Ухаа худаг уурхай орчмын дуу шуугианы хэмжилтийн үр дүн, 2025 он*




### 12.2.5. Цахилгаан станцын зуух болон Халаалтын зуухнуудын утааны найрлагын хэмжилтийн тайлан

Халаалтын зуухны утааны найрлагын хэмжилтийг мэргэжлийн эрх бүхий байгууллага болох Термокалор ХХК-иар 2025 оны 10-р сарын 29-ны өдөр хэмжилтийн ажлыг хийлгэсэн. Хэмжилтийг Testo LX350 загварын багажаар хийсэн бөгөөд энэ багаж нь $O_2$, $CO_2$, CO, NO, $NO_2$, $SO_2$, утааны температур , утааны хурд зэрэг үзүүлэлтүүдийг хэмждэг.

| | Хэмжилтийн үр дүн | Дүгнэлт |
|---|---|---|
| CO, нүүрстөрөгчийн дутуу исэл |  | *Хэмжилтээр НБҮ болон Цэций хороолольн зуухнуудын утааны хийн дэхь CO-ын агууламж стандарт утгаас 1666-3300 мг/м³-ээр бага агууламжтай нормт хэмжээнд байна. Галлерэй кемпын зуух 1371 мг/м³-ээр их байна.* ***Зөвлөмж:*** *Зуухны шаталтын горимыг мөрдөж ажиллах.* |
| ***Тайлбар:*** *усан халаалтын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ 4100 мг/м³ агууламжтай байна.* | | |
| NOx, азотын давхар исэл |  | *Хэмжилтээр зуухнуудын утааны хийн дэхь NOx-ын агууламж стандарт утгаас 617-762 мг/м³-ээр бага агууламжтай нормт хэмжээнд байна.* |
| ***Тайлбар:*** *усан халаалтын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу азотын давхар ислийн хэмжээ 1500 мг/м³ агууламжтай байна.* | | |
| SO2, азотын давхар исэл |  | *Хэмжилтээр зуухнуудын утааны хийн дэхь $SO_2$-ын агууламж стандарт утгаас 1100 мг/м³-ээр бага агууламжтай нормт хэмжээнд байна.* |
| ***Тайлбар:*** *усан халаалтын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу хүхрийн давхар ислийн хэмжээ 1630 мг/м³ агууламжтай байна.* | | |

Цахилгаан станц зуухны утааны найрлагын хэмжилтийг мэргэжлийн эрх бүхий байгууллага болох Термокалор ХХК-иар 2025 оны 10-р сарын 29 өдөр хийлгэсэн. Хэмжилтийг Testo LX350 загварын багажаар хийсэн бөгөөд энэ багаж нь $O_2$, $CO_2$, CO, NO, $NO_2$, $SO_2$, утааны температур , утааны хурд зэрэг үзүүлэлтүүдийг хэмждэг.




*Зураг 12.2.7.1 Термокалор ХХК-ний хэмжилтийн үеийн фото тайлан*

<table>
<tr><th></th><th>Хэмжилтийн үр дүн</th><th>Дүгнэлт</th></tr>
<tr><td>CO, нүүрстөрөгчийн дутуу исэл</td><td>
</td><td>Хэмжилтээр зуухнын утааны хийн дэхь CO-ын агууламж стандарт утгаас 1144 мг/м<sup>3</sup>-ээр их агууламжтай нормт хэмжээнээс өндөр байна.<br>Зөвлөмж: Зуухны шаталтын горимыг мөрдөж ажиллах.</td></tr>
<tr><td colspan="3"><u>Тайлбар:</u> уурын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ 3320 мг/м³ агууламжтай байна.</td></tr>
<tr><td>NOx, азотын давхар исэл</td><td>
</td><td>Хэмжилтээр зуухнуудын утааны хийн дэхь NO<sub>X</sub>-ын агууламж Зуухнуудын хувьд стандарт утгаас 648 мг/м³-ээр бага.<br><u>Зөвлөмж:</u> Зуухны шаталтын горимд тохируулга хийх.</td></tr>
<tr><td colspan="3"><u>Тайлбар:</u> уурын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу азотын давхар ислийн хэмжээ 900 мг/м³ агууламжтай байна.</td></tr>
<tr><td>SO2, азотын давхар исэл</td><td>
</td><td>Хэмжилтээр зуух №1 утааны хийн дэхь SO2-ын агууламж стандарт утгаас 52 мг/м³-ээр бага агууламжтай</td></tr>
<tr><td colspan="3"><u>Тайлбар:</u> уурын зуухнуудад MNS 5919:2008 стандартын дагуу хүхрийн давхар ислийн хэмжээ 1740 мг/м³ агууламжтай байна.</td></tr>
</table>

Термокалор ХХК-ны инженерууд дараах зөвлөмжийг бичсэн байна. Хэмжилт хийсэн зуухны хувьд CO буюу нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж стандарт утгаас их хэмжээтэй байгаа нь нүүрс болон агаарын тохиромжтой хэмжээнд хангагдахгүй байгаа нь зуухны шаталтын горимын тохируулга алдагдсан байна. Иймээс шаталтын горимыг барьж ажиллах шаардлагатай байна.

**12.3 Хөрсний судалгаа**

| № | Хяналт шинжилгээний төрөл | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөрсний агрохимийн шинжилгээ | Шимт хөрсний овоолгууд | Ухаа худаг уурхай орчмын 9 шимт хөрсийн овоолго ба ойн зурвасаас хөрсний дээж авч “Инженер геодези ХХК”-д шинжилгээ хийлгэсэн. Ялзмагийн хувьд ихэнх онуудын шимт хөрсөнд агууламж ихэссэн үзүүлэлттэй байгаа ба шалтгаан нь энэ жил өмнөх жилээс хур тунадас бага орж хөрс бага урссантай холбоотой. 2025 оны ойн зурвасын хашааны гадна хөрсийг дотор хөрсний шинжилгээний дүнтэй харьцуулан шинжлэхэд Цахилгаан дамжуулах чадвар нь 1.82 дахин бага, бусад үзүүлэлтүүд дээр харьцангүй зөрүү бага байсан. Мөн 2025 оны ойн зурвасын гадна хөрсийг 2024 ойн зурвасын гадна хөрсний шинжилгээтэй харьцуулахад ялзмагын агууламж 2.57 дахин их, CaCO3-ийн агууламж 15 дахин бага байсан ба суурь шалтгаан нь | 700.0 | 10 цэг |

### 12.3.1. Хөрсний агрохимийн шинжилгээ

Ухаа худаг уурхайн шимт хөрсний овоолгын 9 цэгээс дээж авч хөрсний агрохимийн шинжилгээг “Инженер геодези ХХК”-д хийлгэсэн. Дээрх цэгүүдээс авсан дээжийн задлан шинжилгээний үр дүнг харьцуулах цэг буюу ойн зурвасын гадна талбайгаас авсан хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнтэй харьцуулан (*Хүснэгт 12.3.1.1*)-д үзүүлэв. *Лабораторийн шинжилгээний хариуг доорх хавсралтаас харна уу.*

| Дээжний нэр | | Шимт хөрс 2011 | | Шимт хөрс 2012 | | Шимт хөрс 2013 | | Шимт хөрс 2016 | | Шимт хөрс 2017 | | Шимт хөрс 2018 | | Шимт хөрс 2024 | | Ойн зурвас дотор | | Ойн зурвас гадна талбай (Харьцуулах цэг) | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| pH | | **8.97** | 8.52 | **9.08** | 8.93 | **8.75** | 8.84 | **8.68** | 8.84 | **8.87** | 8.89 | **8.78** | 8.90 | **9.01** | 8.91 | **9.21** | 8.84 | **8.76** | 8.94 |
| ЦДЧ dsm | | **0.283** | 0.535 | **0.192** | 0.672 | **0.205** | 0.155 | **1.761** | 0.793 | **0.250** | 0.274 | **0.263** | 0.758 | **0.371** | 0.430 | **0.253** | 0.179 | **0.139** | 0.145 |
| Давс % | | **0.14** | 0.26 | **0.09** | 0.33 | **0.10** | 0.07 | **0.88** | 0.39 | **0.12** | 0.13 | **0.13** | 0.37 | **0.18** | 0.21 | **0.12** | 0.08 | **0.06** | 0.07 |
| Ялзмаг % | | **0.97** | 0.75 | **0.56** | 0.85 | **1.05** | 0.52 | **1.25** | 0.65 | **0.80** | 0.66 | **0.82** | 0.35 | **0.80** | 0.98 | **1.44** | 0.62 | **1.26** | 0.49 |
| $CaCO_2$% | | **1.65** | 0.00 | **0.66** | 0.99 | **0.99** | 0.99 | **1.15** | 1.48 | **2.14** | 1.98 | **0.66** | 1.15 | **1.48** | 1.81 | **0.16** | 0.99 | **0.16** | 2.47 |
| Шингээг дсэн сууриуд, мг-экв/100 гр | Ca | **9.1** | 8.0 | **6.2** | 6.4 | **11.8** | 6.6 | **13.4** | 9.5 | **9.6** | 7.9 | **10.1** | 7.2 | **12.9** | 8.1 | **10.3** | 10.2 | **10.9** | 12.5 |
| | Mg | **6.7** | 2.6 | **6.0** | 3.8 | **6.7** | 6.8 | **8.5** | 3.8 | **4.6** | 9.6 | **9.1** | 7.5 | **8.3** | 8.1 | **6.8** | 4.9 | **9.0** | 4.0 |
| Шим тэжээлийн элемтүүд мг/100 гр | $P_2O_5$ | **2.0** | 1.6 | **1.7** | 1.2 | **2.0** | 1.9 | **2.7** | 1.8 | **2.0** | 2.4 | **2.1** | 2.3 | **2.2** | 2.2 | **2.6** | 2.6 | **2.1** | 1.7 |
| | $K_2O$ | **14** | 36 | **94** | 22 | **109** | 22 | **43** | 30 | **14** | 20 | **34** | 27 | **50** | 27 | **32** | 20 | **34** | 17 |
| Он | | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** | **2025** | **2024** |

Хүснэгт 12.3.1.1. *Хөрсний химийн задлан шинжилгээний дүн, Ухаа худаг*

2025 оны хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг 2025 оны ойн зурвасын гадна талбайн цэгээс авсан дээжийн шинжилгээний үр дүнтэй болон 2024 оны шинжилгээний үр дүнтэй харьцуулав.

2025 үр дүнг 2024 оны үр дүнтэй харьцуулан үзэхэд хүчил, шүлтийн түвшин бүх цэгүүдэд өөрчлөлт багатай байсан бол цахилгаан дамжуулах чанар 2011,2012 болон 2018 онуудын шимт хөрсөнд 0.252-оос 0.495-өөр буурсан үзүүлэлттэй гарсан, 2016 оны шимт хөрсний хувьд 0.968 ихэссэн үзүүлэлттэй байна. Ялзмагийн хувьд ихэнх онуудын шимт хөрсөнд агууламж ихэссэн үзүүлэлттэй байгаа ба шалтгаан нь энэ жил өмнөх жилээс хур тунадас бага орж хөрс бага урссантай холбоотой. Бусад үзүүлэлтийн хувьд өмнөх оны үр дүнтэй харьцуулахад харьцангүй хэлбэлзэл багатай байна.

Хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг харьцуулах цэг буюу ойн зурвасын гадна талбайн цэгээс авсан дээжийн шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэхэд хүчил, шүлтийн харьцаа харьцангүй ижилхэн түвшинд байгаа бол цахилгаан дамжуулах чадвар нь 2011, 2012 2013, 2017, 2018 болон 2024 онуудын шимт хөрсөнд 1.38-2.67 дахин өндөр байсан бол 2016 оны шимт хөрсөнд 12.67 дахин өндөр байна. Ялзмагийн хувьд бүх онуудын шимт хөрс харьцуулах цэгээс 0.01-ээс 0.46 %-иар бага агууламжтай байсан. Бусад үзүүлэлтийн хувьд харьцуулахад харьцангүй зөрүү бага байсан.

2025 оны ойн зурвасын хашааны гадна хөрсийг дотор хөрсний шинжилгээний дүнтэй харьцуулан шинжлэхэд Цахилгаан дамжуулах чадвар нь 1.82 дахин бага, бусад үзүүлэлтүүд дээр харьцангүй зөрүү бага байсан. Мөн 2025 оны ойн зурвасын гадна хөрсийг 2024 ойн зурвасын гадна хөрсний шинжилгээтэй харьцуулахад ялзмагын агууламж 2.57 дахин их, CaCO3-ийн агууламж 15 дахин бага байсан ба суурь шалтгаан нь бороо бага орж хөрсөнд CaCO3 тунадас харьцангүй бага үүссэн, дээж авсан цэгт концентрац багассан байх магадлалтай.

*Хүснэгт 12.3.1.2. Хөрсний механик (ширхэгийн) бүрэлдэхүүн*

| Дээжний нэр | | Шимт хөрс 2011 | Шимт хөрс 2012 | Шимт хөрс 2013 | Шимт хөрс 2016 | Шимт хөрс 2017 | Шимт хөрс 2018 | Шимт хөрс 2024 | Ойн зурвас дотор | Ойн зурвас гадна |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ. Мм | 2-0.25 | 23.9 | 33.1 | 15.9 | 21.6 | 16.4 | 21.4 | 23.0 | 27.9 | 28.7 |
| | 0.25-0.05 | 49.6 | 47.0 | 62.7 | 47.9 | 54.7 | 52.7 | 49.9 | 47.1 | 50.3 |
| | 0.05-0.01 | 6.0 | 6.8 | 8.8 | 11.6 | 10.7 | 10.3 | 8.9 | 7.4 | 6.7 |
| | 0.01-0.005 | 4.2 | 2.5 | 2.3 | 2.8 | 4.0 | 3.6 | 2.0 | 2.3 | 1.3 |
| | 0.005-0.001 | 10.3 | 7.9 | 8.6 | 13.0 | 9.5 | 5.8 | 11.5 | 7.2 | 7.0 |
| | <0.001 | 5.9 | 2.7 | 1.7 | 3.1 | 4.6 | 6.1 | 4.7 | 8.1 | 5.7 |
| | <0.01 | 20.5 | 13.1 | 12.6 | 18.9 | 18.2 | 15.5 | 18.2 | 17.6 | 14.1 |

График 12.3.1 *Хөрсний механик бүрэлдэхүүн, 2025 он*




Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2 мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Ширхэглэг 2-0.05мм байвал элс, тоосных 0.05-0.002мм, шавар <0.002мм тус тус байдаг (“Guidelines for soil description”. 2006). Судалгааны үр дүнгээс харахад хөрсөн дэх элсэн фракцын утгын хэлбэлзэл буюу 2-0.05 мм-д 71.1% - 80.1% байсан. Тоосны фракцын утгын хэлбэлзэл буюу 0.05-0.01 мм-ийн хооронд 15.0% - 20.5% байна. Шаврын фракцын утгын хэлбэлзэл буюу 0.01-0.001 мм-ийн хооронд 1.7% - 8.1% байсан. Дээрх графикийн үзүүлэлтээс харахад хөрсний механик бүрэлдэхүүний ихэнх хувийг элсэн фракц буюу 2-0.05 мм бүрэлдэхүүн эзэлж байгааг харуулж байгаа ба харин тоос болон шаварлаг бүтэц нь харьцангуй бага байгааг харуулж байна.

### 12.3.2. Хөрсний микро элементийн шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхай орчмын хөрсний бохирдлын мониторингийн 10 цэгээс, цагаан хадны ормын 3 цэгээс хөрсний микроэлементийн шинжилгээнд дээж авч ALS MINERALS итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн.




*Зураг 12.3.2.1. Хөрсний микроэлементийн шинжилгээний дээж авч буй байдал*

Хүснэгт 12.3.2.1 *Хөрсний микроэлементийн шинжилгээний дүн, 2025 он*

| № | Байршил | Pb | Cd | Hg | As | Cr | Sr | V | Cu | Ni | Co | Zn | B |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | MNS 5850:2019 | 500 | 10 | 10 | 20 | 400 | 800 | 150 | 100 | 150 | 50 | 300 | 25 |
| 1 | Тээвэр, ложистик засвар | 12 | <0.5 | <1 | 9 | 16 | 109 | 37 | 25 | 12 | 7 | 47 | 10 |
| 2 | Уурхайн засвар | 10 | <0.5 | 1 | 11 | 12 | 157 | 60 | 57 | 9 | 9 | 47 | 20 |
| 3 | Нүүрс баяжуулах үйлдвэр | 9 | <0.5 | <1 | 17 | 14 | 184 | 31 | 34 | 12 | 9 | 47 | 20 |
| 4 | Дулаан цахилгаан станц | 10 | <0.5 | <1 | 8 | 17 | 136 | 37 | 26 | 15 | 9 | 44 | 20 |
| 5 | Шатахуун түгээх станц | 9 | <0.5 | 1 | 7 | 18 | 34 | 35 | 20 | 15 | 6 | 41 | 10 |
| 6 | Хогийн цэг | 9 | <0.5 | 1 | 12 | 21 | 63 | 41 | 25 | 14 | 8 | 47 | 10 |
| 7 | Насос станц | 8 | <0.5 | <1 | 7 | 18 | 55 | 36 | 21 | 14 | 7 | 42 | 10 |
| 8 | Уурхай цэвэрлэх байгууламж | 9 | <0.5 | 1 | 6 | 19 | 48 | 35 | 21 | 17 | 7 | 42 | 10 |
| 9 | Сумын цэвэрлэх байгууламж | 10 | <0.5 | <1 | 8 | 24 | 39 | 43 | 27 | 19 | 9 | 53 | 10 |
| 10 | Ойн зурвас | 11 | <0.5 | <1 | 10 | 23 | 45 | 41 | 22 | 19 | 9 | 44 | 10 |
| № | Байршил | Pb | Cd | Hg | As | Cr | Sr | V | Cu | Ni | Co | Zn | B |
| 11 | Цагаан хад ковш засвар | 13 | <0.5 | <1 | 11 | 24 | 68 | 42 | 21 | 20 | 9 | 46 | 20 |
| 12 | Цагаан хад засварын төв | 16 | <0.5 | <1 | 11 | 24 | 121 | 35 | 27 | 26 | 9 | 56 | 10 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Цагаан хад хяналтын цэг | 17 | <0.5 | 1 | 12 | 22 | 115 | 33 | 26 | 27 | 14 | 64 | 20 |

Шинжилгээний дүнгээс харахад элементийн агууламж MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна.

### 12.4 Ургамал, амьтны аймгийн судалгаа

| № | Хяналт шинжилгээний төрөл | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ухаа Худаг уурхай орчим болон дэд бүтцийн барилга байгууламж, ус олборлолтын талбай орчмын ургамлан бүрхэвчийн ажиглалт хийх | -Наймантын хөндий<br>-Нисэх буудал -Хулсан ус худаг<br>-Шинэ ус худаг<br>-Эргэлтийн усан сан<br>-Цагаан хад кемп -Цагаан хад НАБТ | Геоботаникийн бичиглэлийг 13 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэвч, зонхилогч зүйлүүдийг тодорхойлж, амьдралын хэлбэрээр дүн шинжилгээ хийж, Excel программ ашиглан боловсруулсан. | 5,000.0 | Жилд нэг удаа |
| 2 | Амьтны судалгаа хийх | Тугийн цохио, Хангинах орчим Ойн зурвас, ТТНБ | Шувуудын судалгааг харуул цэг, талбайн ажиглалт, тор ашиглан барих аргаар гүйцэтгэж, 62 зүйлийг бүртгэсэн (нийт мониторингоор 130 зүйл). Туруутан амьтдын судалгааг шугаман замнал, автомат камераар (4 ширхэг) хийсэн. Жижиг хөхтөн амьтдын судалгааг 40 амьд баригч болон гэрэлтүүлэг ашиглан гүйцэтгэж, Симпсоны индекс, Jackknife аргаар дүн шинжилгээ хийсэн. | 10,000.0 | Жилд нэг удаа |
| 3 | Уст цэг дээр автомат камераар ажиглалт явуулах | Цагаан хад | Цагаан хадны зүүн уст цэг дээр 2025 оны 9-р сарын 16 -аас 10-р сарын 25 ны хооронд нийт 40 хоногийн турш автомат камер байршуулж, амьтдын зураг, видео баримтжуулалт хийсэн. | 2,000.0 | Жилд нэг удаа |
| | | | **17,000.0** | | |

#### 12.4.1 Ургамлын бүрхэвчийн судалгаа

Ургамалжилтын доройтлын түвшнийг илэрхийлэх болон нөхөн сэргээсэн талбайд үнэлгээ хийх зорилгоор ургамлын бүлгэмдэл үүсгэн зонхилох зүйл, ургамлын тусгагийн бүтэц, нэг цэгт бүртгэгдэх

зүйлийн тоо, зүйлийн бүрэлдэхүүний амьдралын хэлбэрийн онцлог, доройтлыг илэрхийлэгч зүйлүүдийн эзлэх хувь зэргийг мониторингийн бичиглэлийн үр дүнгээс тодорхойлсон. Ургамлын хээрийн судалгаагаар 13 цэгт геоботаникийн бичиглэл хийсэн. Үүнд:

1. Ухаа худаг уурхай орчим -5 цэг
2. Баруун наран уурхай орчим- 4 цэг
3. Ойн зурвасын хашааны гадна болон дотор талд -2 цэг
4. Нөхөн сэргээлт хийсэн талбайд- 3 цэг

### 12.4.1.1. Ухаа худаг уурхай орчмын ургамалжилт

Ургамлын аймгийн задлан шинжилгээ хийхэд судалгааны талбайд нийт 13 овгийн 44 төрөлд хамаарах 51 зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдэв. Ухаа худаг уурхай орчимд ургамалжилтын мониторингийн 5 цэгт бичиглэл хийж боловсруулахад Хөмөл - хялганат, Өмхий өвс-шарилж-боролзот, Шарилж-өмхий өвст, Лууль -өмхий өвст, Таана –хазаар өвс- хялганат гэсэн 5 бүлгэмдэл илрэв.

Хүснэгт 12.4.1.1.1 *Ухаа худаг уурхай орчмын ургамлын нөмрөгт бүлгэмдэл үүсгэлт, зүйлийн бүрэлдэхүүн*

| **Ухаа худаг уурхай** | | | Наймантын хөндий | Нисэх буудал | Хулсангийн ус худаг | Хаягдлын далан | Шинэ усны худаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бичиглэлийн код | | Амьдралын хэлбэр (Raunkiaer, 1934) | UHGSF01 | UHGSF02 | UHGSF03 | UHGSF05 | UHGSF04 |
| Өндөршил (м) | | | 1328.6 | 1388 | 1411.9 | 1453 | |
| Өргөрөг (N) | | | 43.851820 | 43.770310 | 43.729920 | 43.65951 | 43.670330 |
| Уртраг (E) | | | 105.490500 | 105.576890 | 105.541950 | 105.59049 | 105.456560 |
| Өвслөг ташингын (H) бүрхэц (%) | | | 45 | 35 | 20 | 25 | 30 |
| Зонхилогч зүйл (H) | | | *Stipa glareosa* | *A. achilloides* | *P. nigellastrum* | *P. nigellastrum* | *A. polyrrhizum* |
| Зүйлийн тоо | | | 13 | 14 | 10 | 17 | 17 |
| **Зүйлийн шинжлэх ухааны нэр** | **Зүйлийн монгол нэр** | | | | | | |
| *Allium polyrhizum* Turcz. ex Regel | Таана, Багалгар сонгино | G | 1 | 1 | | 1 | 2a |
| *Puccinellia tenuiflora* (Griseb.) Scribn. & Merr. | Турьхан цэцэгт зурман сүүл | H | 1 | | | + | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Ajania achilleoides* (Turcz). Poljak. | Төлөгчдүү боролз | H | | 2a | 1 | r | 1 |
| *Peganum nigellastrum* Bunge | Харлаг үмхий өвс | H | + | 1 | 1 | 1 | + |
| *Anabasis brevifolia* C.A. Mey | Ахар навчит баглуур | H | + | | | + | + |
| *Convolvulus ammannii* Desr. | Амманы сэдэргэнэ | H | | | + | + | + |
| *Oxybasis glauca* | Хөх ногоон лууль | T | | | | | |
| *Allium mongolicum* Regel | Монгол сонгино, хөмөл | G | 2a | | | 1 | + |
| *Echinops gmelinii* Turcz. | Гмелиний тайжийн жинс | H | | r | r | r | r |
| *Lipschitzia divaricata* (Turcz.) Zaika, Sukhor. & N.Kilian | Дэрэвгэр хависхана | H | | r | | + | |
| *Stipa glareosa* P.A.Smirn. | Сайрын хялгана | H | 2b | | | | 2a |
| *Artemisia xerophytica* Krasch. | Хуурайсаг шарилж | H | + | | | | |
| *Eragrostis minor* Host | Бага хургалж | T | | 1 | | | |
| *Salsola tragus* L. | Өргөст бударгана | T | + | + | + | | + |
| *Kochia melanoptera* Bunge | Хар дэвүүрт тогторгоно | T | + | | | | + |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Setaria viridis* | Ногоон хоног будаа | T | | r | r | | |
| *Tribulus terrestris* | Зэл зангуу | T | | + | r | + | r |
| *Neopallasia pectinata* | Шүлхий шарилж | T | | + | + | + | r |
| *Salsola passerina* | Бор бударгана | | + | | | | + |
| *Reamuria soongarica* | Улаан бударгана | | | | | | + |
| *Nitraria sibirica* | Сибирь хармаг | | + | | | | r |
| *Chloris virgata* | Саваан булган сүүл | | | | | | r |
| *Cleistogenes songorica* | Зүүнгарын хазаар өвс | | | | | | 1 |
| *Achnatherum splendens* | Гялгар дэрс | | | | + | + | |
| *Chenopodium album L.* | Цагаан лууль | | | | 2a | | |
| *Artemisia scoparia* | Ямаан шарилж | | | | | 2a | |
| *Heteropapus altaicus* | Алтайн согсоолж | | | | | + | |
| *Stellaria dichotoma* | Ацан ажигана | | | | | r | |
| *Cynanchum thesioides* | Сибирь ерөндгөнө | | | | | r | |
| *Oxytropis aciphylla* | Өргөст ортууз | | r | | | | |
| *Stipa glareosa* P.A.Smirn. | Сайрын хялгана | | 2b | | | | |

Товчилсон үгийн тайлбар: P: Фанерофит; Ch: Хамефит; G: Криптофит; H: Гемокриптофит; T: Терофит




Зураг 12.4.1.1.1. *Уурхай орчмын ургамалжилтын амьдралын хэлбэрийн ангилал*



*Зураг 12.4.1.1.2. Ургамалжилтын судалгааны талбай сонгож буй байдал*



*Зураг 12.4.1.1.2. Хөмөл - хялганат цөлөрхөг хээрийн ургамалжилт*

**12.4.2. Амьтны аймгийн судалгаа**

12.4.2.1 Шувууны судалгааны ерөнхий үр дүн

Шувууны төрөл зүйлийг тодорхойлох судалгаа 2025 оны 09 сарын 23-27-ны өдрүүдэд Ухаа худаг орчим, ойн зурвас, таван толгой нисэх буудал, Цогтцэций сумын төв, Хангинахын ам, Тугийн цохио гэх мэт хээрийн судалгаа явуулсан бүхий л талбайд бүртгэл хийж ажиллаа. Энэ удаагийн мониторингоор 12 баг, 30 овогт хамаарах 62 зүйлийг бүртгэлээ.

Харин 2012 оноос өнөөдрийг хүртэлх мониторинг судалгаагаар 14 баг, 33 овогт хамаарах 130 зүйл шувуудыг бүртгээд байна. Энэ нь монгол оронд 2022 оны байдлаар бүртгэгдээд байгаа нийт зүйлийн (Gombobaatar, 2022) 25 орчим хувийг эзэлнэ.

Өмнөх мониторингийн жилүүдэд бүртгэгдээгүй Дагуурын намнаа (*Muscicapa dauurica*), Эгэл ногоолзой (*Spinus spinus*), Цагаан шанаат хөмрөг (*Emeriza leucocephalos*) гэсэн 3 зүйлийг нэмж бүртгэлээ.

Энэ жилийн буюу 2025 оны судалгааны үр дүнг өмнөх жилүүдийн (2012, 2013, 2018, 2020, 2021, 2022, 2023, 2024) судалгааны үр дүнгүүдтэй харьцуулж чанарын болон тоон мэдээлэлд анализ хийж болох юм. Эдгээрээс 2020 он хүртэлх мэдээллийг нэгдсэн байдлаар 2020 оны Жэмр ХХК-ны боловсруулсан тайлангаас авсан бол сүүлийн жилүүдийн мэдээллийг Авралын эрэлд ХХК-ны тайлангуудаас авч ашиглалаа. Харин 2020 оноос өмнөх судалгааг аль цаг хугацаанд хийсэн нь тодорхойгүй бол 2020

онд 9 сарын 10, 2021-2022 онуудад 10 сарын эхээр хийсэн бол сүүлийн 2 удаагийн мониторингийг ижил хугацаанд (9 сарын 15-27) хийж чадсан нь онцлог байна.




12.4.2.1.1 *Тухайн жилийн мониторинг судалгаагаар бүртгэгдсэн зүйлийн тоо*


(a)


(b)


(c)




(d)

Зураг 12.4.2.1 *Мониторинг судалгааны явцад нэмж бүртгэгдсэн зургаан зүйл шувууд (a.Эгэл ногоолзой, b. Дагуурын намнаахай, c. Цагаан шанаат хөмрөг, d. Хахилаг, Хангинахын ам, автомат камерт буусан нь)*

*Хүснэгт 4. Зүйлийн жагсаалт 2021-2025*

| № | Зүйлийн нэр | Латин нэр | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **ACCIPITRIFORMES-ХАРЦАГА** | | | | | | |
| 1 | Нөмрөг тас | *Aegypius monachus* | * | | | | |
| 2 | Морин харцага | *Accipiter nisus* | | * | * | * | * |
| 3 | Саарал хулд | *Circus cyaneus* | * | | * | * | * |
| 4 | Ойн сар | *Buteo buteo* | | | * | | * |
| 5 | Талын сар | *Buteo rufinus* | | | | * | |
| 6 | Шилийн сар | *Buteo hemilasius* | | | * | * | |
| 7 | Сохор элээ | *Milvus migrans* | | | | * | * |
| | **FALCONIFORMES-ШОНХОР** | | | | | | |
| 8 | Начин шонхор | *Falco tinnunculus* | | | * | * | * |
| **GRUIFORMES – ТОГОРУУ** | | | | | | | |
| 9 | Өвөгт тогоруу | *Grus virgo* | | | * | | |
| **COLUBIFORMES-ТАГТАА** | | | | | | | |
| 10 | Хадны тагтаа | *Columba rupestris* | | | * | * | * |
| 11 | Хөхвөр тагтаа | *Columba livia* | * | * | * | * | |
| **PTEROCLIFORMES-НОГТРУУ** | | | | | | | |
| 12 | Монгол ногтруу | *Syrrhaptes paradoxus* | * | * | * | * | * |
| **BUCEROTIFORMES-ЭВЭР ХОШУУ** | | | | | | | |
| 13 | Бөөвөлжин өвөөлж | *Upupa epops* | * | | * | * | * |
| **PASSERIFORMES-БОР ШУВУУ** | | | | | | | |
| 14 | Хон хэрээ | *Corvus corax* | | * | * | * | * |
| 15 | Хар хэрээ | *Corvus corone* | | * | | * | |
| 16 | Дэрсний жиргэмэл | *Alaudala cheleensis* | * | * | * | | |
| 17 | Талын жиргэмэл | *Calandrella brachydactyla* | | | * | | |
| 18 | Монгол болжмор | *Melanocorypha mongolica* | | * | | | * |
| 19 | Эвэрт болжмор | *Eremophila alpestris* | * | * | | * | * |
| 20 | Науманны хөөндэй | *Turdus naumanni* | * | * | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Хар гүеэт хөөндэй | *Turdus atrogularis* | * | * | * | * | * |
| 22 | Улаан гүеэт хөөндэй | *Turdus ruficollis* | | | * | * | * |
| 23 | Халиун хөөндэй | *Turdus obscurus* | | | | * | |
| 24 | Алаг хөөндэй | *Zoothera aurea* | | | | * | * |
| 25 | Жирхэн дууч шувуу | *Phylloscopus proregulus* | * | * | * | * | * |
| 26 | Ногоовор дууч шувуу | *Phylloscopus trochiloides* | | | * | * | * |
| 27 | Хос судалт дууч шувуу | *Phylloscopus plumbeitarsus* | | | * | | |
| 28 | Урианхайн дууч шувуу | *Phylloscopus tristis* | * | * | * | * | |
| 29 | Дагуур гал сүүлт | *Phoenicurus auroreus* | * | * | * | * | * |

**12.4.2.4. Хөхтөн амьтны судалгаа**

Ухаа худаг цогцолбор төслийн хүрээнд Наймдайн хөндий, Таван толгой нисэх буудал орчимд жижиг хөхтөн амьтдын судалгаа, мониторинг, Тугийн цохио, Хангинах уул орчимд уулын туруутан амьтдын судалгааг хийж өмнөх онуудын үр дүнтэй харьцуулах замаар тоо толгой, байршил, нягтшил, популяцийн хөдлөл зүйг тодорхойллоо. Хээрийн судалгааг арга зүйд тусгасны дагуу 2025 оны 09 сарын 24-25-ний өдрүүдэд гүйцэтгэлээ. Энэ онд сибирь алаг даага, говийн алаг даага, савгадаахай, элсний зусаг гэсэн 4 зүйл жижиг хөхтөн амьтад баригдсан бол бор туулай, шар үнэг зэрэг зүйлүүд маршрутын дагуу таарч байлаа. Өмнөх онуудад монгол чичүүл тархсан бөгөөд 2022 онд 77 га, 2023 онд 281 га, 2024 онд 5 га болж буурсан байлаа. Харин энэ онд монгол чичүүлээс гадна элсний зусаг нэмж баригдсан.



(a) (b) (c)

Зураг 12.4.2.4.1 *Хөхтөн амьтдын судалгаа хийх үед таарсан хөхтөн амьтад (a. . Бор туулай, b. Монгол чичүүл, c. Элсний зусаг)*

**12.4.2.5. Уулын туруутан амьтдын судалгаа**

Уулын туруутан амьтдын судалгааг Хангинахын ам, Тугийн цохио чиглэлд хийж гүйцэтгэсэн бөгөөд янгир ямаа, аргаль хонь, цагаан зээр зэрэг амьтдыг бүртгэж баримтжуулахаас гадна тоо толгой, тархац, боломжит амьдрах орчны загвар зэргийг боловсрууллаа. Энэ оны мониторинг судалгаагаар Тугийн цохио орчимд 7 тооны янгир ямаа (ишиг, борлон, эм ямаа), Хангинах ууланд 2 сүргийн 17 янгир ямаа, 1 сүргийн 8 аргаль хонь бүртгэлээ.

**Уулын туруутан амьтдын тархац, байршил, тоо толгойн төлөв байдал:**

**Аргаль хонь:** Ханхонгор сумын нутагт байрлах Их уулын (20 орчим толгой), Цэций уул (30 орчим толгой), Хангинахын ам, Бичигт хад (10 гаруй, тогтвортой бус) тархац, нөөцтэй байна.
**Янгир ямаа:** Их уул, бага уул орчимд 30 гаруй толгой, Цэций уул 10 орчим, Хангинахын ам 50 гаруй, Тугийн цохио 10 орчим толгой бий.
**Хар сүүлт зээр:** Цэций уулын орчимд 10 орчим, түүнээс зүүн зүгт Шанхайн хэц, баруун хойш Наймдайн хөндий орчимд цөөн тохиолдох бол Цэций уулаас урагш Зайрмагтайн хөндий чиглэлд тус зүйлийн нягтшил нэмэгдэнэ.

**Цагаан зээр:** Таван толгойн бүлэг уурхай орчимд цагаан зээр жил бүр харилцан адилгүй тоотой таарах бөгөөд 2017 оноос Цэций уулын орчимд жилийн турш 300 хүртэлх тоотойгоор байршиж буй бөгөөд 2021 оны зун 30 гаруй янзага бүртгэгдсэн. Өвлийн улиралд идэш тэжээлийн хомсдол бий болсноор уурхайн хашаа, ажилчдын суурин, бусад суурьшлын бүсэд нэвтэрнэ. Харин 2024 оны намар зуншлага сайн болсон учир Хангинахын ам орчимд 150 гаруй, Их уулын өвөр хэсэгт 300 гаруй зээр бүртгэгдсэн.
**Хулан адуу**: Цэций уулын орчимд хавар, намартаа хаяа тохиолдоно.



(a) (b) (c)

Зураг 12.4.2.5.1 *Туруутан амьтдын судалгаа хийх үед таарсан туруутан амьтад (a. Ишигтэй Янгир ямаа, b. Автомат камер байрлуулсан байдал, c. Аргал хонь)*

### 12.4.3. Уст цэг дээр автомат камераар ажиглалт явуулах

Цагаан хадны зүүн уст цэг дээр 2025 оны 9-р сарын 16 -аас 10-р сарын 25 ны хооронд нийт 40 хоногийн турш автомат камер байршуулж, амьтдын зураг, видео баримтжуулалт хийсэн. Камерын дуранд нутгийн 5 хошуу малаас гадна цагаан зээр ганцаар болон сүргээр ажиглагдсан.



*Зураг 12.4.3.1 Камерт ажиглагдсан зэрлэг амьтдын зургуудаас.*

## 13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа | Тайлан мэдээлэл хүлээн авах тал | Гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Хугацааны тов |
|---|---|---|---|---|---|
| 13.1 | Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл танилцуулах | Цогтцэций сумын иргэд | Сумын ЗДТГ-ын төлөөлөл, Худаг ашиглагч малчин өрхүүдийн төлөөлөл, Сав газрын зөвлөлөөс төлөөлөл бүхий 14 хүнийг оролцуулан Шугаман худаг, Хоолойн гучин худаг, Цагаан эргийн худгуудад хэмжилт хийв. | 3,000.0 | 8-р сарын 20 |
| 13.2 | Компанийн үйл ажиллагаа болон БО-ны ажлын гүйцэтгэл | Багийн иргэдийн | Уламжлал болгон хийж ирсэн Нэлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийн 2025 оны 8-р сарын 8, 9-ний өдрүүдэд, Ухаа худаг наадмын | 2,000.0 | 10-р сарын 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийтийн хурал | үеэр зохион байгуулав. Тус өдөрлөгт 467 хүн идэвхитэй оролцож, мэдээлэл авч, санал хүсэлтээ илэрхийлсэн. | | |
| 13.3 | Агаарын суурин станцыг суурилуулж гадаад орчны тоосны концентрацийцн хэмжилтийн үр дүнгийн мэдээлэл хүргэх | Компанийн ажилтнууд | Oizom автомат агаарын чанарын хяналтын суурин станцыг байршуулж, тоосжилт болон бусад агаарын чанарын үзүүлэлтүүдийг 24/7 бодит хугацаанд хэмжин хянаж эхэлсэн. | 1,200.0 | Сар бүрийн 5-ны өдөр |
| 13.4 | Химийн бодисын зарцуулалтын тайлан | Цогтцэций сумын засаг даргыг тамгын газар | Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдсан химийн бодисын нийт зарцуулалтыг бүртгэн нэгтгэж, хэрэглээний динамикийг улирлаар харьцуулан дүгнэлээ. Мөн химийн бодис бүрийн орлого, зарцуулалтыг бүртгэлд үндэслэн нягтлан шалгаж, илүүдэл болон хугацаа нь дууссан бодисыг аюулгүйгээр зайлуулах арга хэмжээ авсан. | 400.0 | Жилд 1 удаа 11-р сарын 15 |
| 13.5 | Компанийн БОНЗ (ESG)-н гүйцэтгэл | Олон нийт, сонирхогч талууд | Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын бодлого, үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн үр дүнг ил тод, хариуцлагатайгаар олон нийтэд хүргэх зорилгоор БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн үр дүн, биелэлт, баримталж буй бодлого, зарчмууд болон гол шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж компанийн вэбсайт, фейсбүүк хуудсанд байршуулан мэдээлэв. | Үйл ажиллагаа ны зархдлаас | 7-р сарын 1 |
| 13.6 | Компанийн байгаль орчны ажлын гүйцэтгэл | Олон нийт, сонирхогч талууд | “Ухаа Худаг” төслийн хүрээнд байгаль орчны холбогдолтой хэрэгжиж буй ажлууд болон мэдээллийг олон нийт болон сонирхогч талуудад 2012 оноос хойш мэдээлж байна. 2025 оны 1 сарын 1-нээс 10 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 7 пост, 6 бичлэг нийтлэн танилцуулсан байна. | 800.0 | Улирал бүр |
| **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | | **7,000.0** | | |

**13.1.Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл**

Ухаа худаг уурхайн Байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгж хамтран орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны хээрийн хэмжилтийн бодит мэдээллийг

иргэдэд нээлттэй хүргэх зорилгоор хамтын оролцоот мониторингийн ажлыг жил бүр зохион байгуулдаг.

2025 оны 4 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан хамтарсан мониторингийн ажилд Сумын Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, худаг ашиглагч малчин өрхүүдийн төлөөлөл болон Сав газрын зөвлөлийн төлөөлөл зэрэг нийт 14 хүн оролцов. Мониторингийн хүрээнд Шугаман худаг, Хоолойн гучин худаг, Цагаан эргийн худгуудад хэмжилт хийсэн бөгөөд оролцогчдын ихэнх нь өмнө нь хамтарсан мониторингийн үйл ажиллагаанд оролцож байсан туршлагатай иргэд байв.

Хэмжилтийн ажил эхлэхийн өмнө хамтарсан мониторингийг зохион байгуулах үндэслэл, зорилго, ач холбогдол болон хэмжилтийн аргачлалын талаар оролцогчдод танилцуулга хийж мэдээлэл олгосон.




Зураг 13.1.1. байгаль орчны хамтарсан мониторингийн ажилд оролцогч иргэд

## 13.2.Компанийн үйл ажиллагаа болон БО-ны ажлын гүйцэтгэл

Орон нутгийн иргэдийг нээлттэй мэдээллээр хангах, компанийн үйл ажиллагааны талаарх олон талт мэдээллийг танилцуулах, тэдний санал хүсэлтийг сонсох зорилгоор уламжлал болгон хийж ирсэн Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийн 2025 оны 8-р сарын 8, 9-ний өдрүүдэд, Ухаа худаг наадмын үеэр зохион байгуулав. Тус өдөрлөгт 467 хүн идэвхитэй оролцож, мэдээлэл авч, санал хүсэлтээ илэрхийлсэн байна.

Нээлттэй өдөрлөгийн үеэр иргэдийн хамгийн их сонирхдог асуулт болох агаарын чанар болон тоосжилтын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар сонирхсон иргэдэд мэдээлэл өгөв.




*Зураг 13.2.1. Нээлттэй өдөрлөгт оролцогч иргэд*

## 13.3.Агаарын суурин станцыг суурилуулж гадаад орчны тоосны концентрацийн хэмжилтийн үр дүнгийн мэдээлэл хүргэх

Ухаа худаг уурхай орчмын гадаад орчны тоосны концентрацийцн хэмжилтийн үр дүнг нийт ажилтнуудад нээлттэй байдлаар тайлагнах журмаар БОМТ-ны самбар дээр сар бүр байрлуулах ажил хийгдсэн. Дээрх ажлын хүрээнд сар бүрийн тоосны хэмжилтийн үр дүнгээс гадна Наймдайн болон Наймантын хөндийн малчдын гар худгуудын усны түвшний хэмжилт болон байгаль орчны холбогдолтой нэмэлт мэдээлэлийг сар бүр шинэчлэн байрлуулсан.







Зураг 13.3.1. НМТ-ний мэдээллийн самбарт сар бүр байршуулсан мэдээлэл

2025 оны 1-р сарын 10-наас эхлэн уурхайн төв цэгт Oizom автомат агаарын чанарын хяналтын суурин станцыг байршуулж, тоосжилт болон бусад агаарын чанарын үзүүлэлтүүдийг 24/7 бодит хугацаанд хэмжин хянаж эхэлсэн. Уг станц нь нарийвчлалтай мэдрэгчүүдээр угсрагдсан бөгөөд PM10, PM2.5, CO, $NO_2$, $SO_2$ зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг автоматаар бүртгэж, өгөгдлийг цахим сервер рүү дамжуулдаг. Үр дүнг долоо хоног бүр нэгтгэн боловсруулж, удирдлагын түвшний ажилтнуудад и-мэйлээр тогтмол мэдээлэн хүргэж байна.







Зураг 13.3.2. Ойзом суурин станцын 7 хоног тутмын мэдээлэл

## 13.4. Химийн бодисын зарцуулалтын тайлан

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдсан химийн бодисын нийт зарцуулалтыг бүртгэн нэгтгэж, хэрэглээний динамикийг улирлаар харьцуулан дүгнэлээ. Мөн химийн бодис бүрийн орлого, зарцуулалтыг бүртгэлд үндэслэн нягтлан шалгаж, илүүдэл болон хугацаа нь дууссан бодисыг аюулгүйгээр зайлуулах арга хэмжээ авсан.



| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | Мөнгөний сульфат | Silver sulfate | $Ag_2SO_4$ | 10294-26-5 | Химийн бодисын агуулах | * | 0.30 | 0.00 | 0.00 |
| 70 | Мурексид | Murexide | $C_8H_8N_6O_6$ | 3051-09-0 | Химийн бодисын агуулах | * | 0.40 | 0.00 | 0.00 |
| 71 | Натрийн гидрофосфат | Sodium hydrophosphate | $Na_2HPO_4$ | 7558-79-4 | Химийн бодисын агуулах | * | 5.50 | 1.50 | 1.50 |
| 72 | Натрийн дигидрофосфат | Sodium dihydrophosphate | $NaH_2PO_4$ | 7558-80-7 | Химийн бодисын агуулах | * | 7.00 | 0.00 | 1.00 |
| 73 | Натрийн дихлоризоцианурат | Sodium dichloroisocyanurate | $C_3Cl_2N_3Na$ | 2893-78-9 | Химийн бодисын агуулах | * | 6.50 | 0.50 | 0.00 |
| 74 | Натрийн додецилсульфат | Sodium dodecyl sulfate | $C_{12}H_{25}SO_4Na$ | 151-21-3 | Химийн бодисын агуулах | * | 33.50 | 0.00 | 2.00 |
| 75 | Натрийн карбонат | Sodium carbonate | $Na_2CO_3$ | 497-19-8 | Химийн бодисын агуулах | * | 6.00 | 0.00 | 0.00 |
| 76 | Натрийн нитрит | Sodium nitrite | $NaNO_2$ | 7632-00 | Химийн бодисын агуулах | * | 1.00 | 0.00 | 0.00 |
| 77 | Натрийн нитропруссид | Sodium nitroprusside | $Na_2[Fe(CN)_5NO]$ | 13755-38-9 | Химийн бодисын агуулах | * | 4.50 | 0.00 | 0.00 |
| 78 | Натрийн салицилат | Sodium salicylate | $C_7H_5NaO_3$ | 54-21-7 | Химийн бодисын агуулах | * | 9.00 | 0.00 | 0.25 |
| 79 | Натрийн сульфат | Sodium sulfate | $Na_2SO_4$ | - | Химийн бодисын агуулах | * | 1.00 | 0.00 | 0.00 |
| 80 | Натрийн сульфит | Sodium sulfite | $Na_2SO_3$ | 7787-83-7 | Химийн бодисын агуулах | * | 5.50 | 0.00 | 0.00 |
| 81 | Натрийн тиосульфат | sodium thiosulfate | $Na_2S_2O_3$ | 10102-17-7 | Химийн бодисын агуулах | * | 1.50 | 6.00 | 0.00 |
| 82 | Натрийн хлорид | Sodium chloride | $NaCl$ | 7440-23-5 | Химийн бодисын агуулах | * | 7.50 | 0.00 | 0.00 |
| 83 | Натрийн цитрат | Sodium citrate | $C_6H_5Na_3O_7$ | 6132-04-3 | Химийн бодисын агуулах | * | 15.00 | 0.00 | 6.00 |
| 84 | Перхлорын хүчил | Perchloric acid | $HClO_4$ | 7601-90-3 | Химийн бодисын агуулах | * | 10.00 | 0.00 | 0.00 |
| 85 | Сафранин О | Safranin O | $C_{20}H_{19}N_4Cl$ | 477-73-6 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 0.00 | 0.00 |
| 86 | Сегнетийн давс | Potassium Sodium Tartrate | $KNaC_4H_4O_6$ | 304-59-6 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 8.00 | 0.00 |
| 87 | Силикагель | Silica gel | $SiO_2 \cdot nH_2O$ | 63231-67-4 | Химийн бодисын агуулах | * | 8.00 | 0.00 | 0.00 |
| 88 | Толуол 4 сульфонамид | Toluene sulfonamide | $C_7H_7NSO_2NH_2$ | 139-86-6 | Химийн бодисын агуулах | * | 2.00 | 0.00 | 0.00 |
| 89 | Төмрийн хлорид | Iron chloride | $FeCl_3$ | 10025-77-1 | Химийн бодисын агуулах | * | 6.00 | 0.00 | 0.00 |
| 90 | 1, 10 -Фенантролин | 1 10 phenanthroline | $C_{12}H_8N_2$ | 66-7 | Химийн бодисын агуулах | * | 0.03 | 0.00 | 0.00 |
| 91 | Фенолфталейн | Phenolphthalein | $C_{20}H_{14}O_4$ | 77-09-8 | Химийн бодисын агуулах | * | 0.03 | 0.00 | 0.00 |
| 92 | Фторт устөрөгч | Hydrogen fluoride | $HF$ | 7664-39-3 | Химийн бодисын агуулах | * | 0.50 | 0.00 | 0.50 |
| 93 | Хурган чихний хүчил | Oxalic acid | $C_2H_2O_4$ | 144-62-7 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 0.00 | 0.00 |
| 94 | Цайрын сульфат | Zinc sulfate | $ZnSO_4$ | 7733-02-0 | Химийн бодисын агуулах | * | 9.00 | 0.00 | 0.00 |
| 95 | Цайрын хлорид | Zinc chloride | $ZnCl_2$ | 7646-85-7 | Химийн бодисын агуулах | * | 10.00 | 0.00 | 9.00 |
| 96 | ЭДТА динатрийн давс - Трилон Б | Ethylenediaminetetraacetic acid disodium salt | $C_{10}H_{14}N_2Na_2O_8$ | 6381-92-6 | Химийн бодисын агуулах | * | 10.00 | 0.00 | 0.00 |
| 97 | Этилийн спирт | Ethanol | $C_2H_5OH$ | 64-17-5 | Химийн бодисын агуулах | * | 7.50 | 0.00 | 0.00 |
| 98 | Альфа-Нафталамин | Alpha-Naphthalene | $C_{10}H_9N$ | 91-20-3 | Химийн бодисын агуулах | * | 0.30 | 0.00 | 0.22 |
| 99 | Нимбэгний хүчил | Citric acid anhydrous | $C_6H_8O_7$ | 77-92-9 | Химийн бодисын агуулах | * | 57.00 | 0.00 | 0.00 |
| 100 | Калийн нитрат | Potassium nitrate | $KNO_3$ | 7757-79-1 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 0.00 | 0.00 |
| 101 | Натрийн фторид | Sodium fluoride | $NaF$ | 7681-49-4 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 0.00 | 0.00 |
| 102 | Цардуул | Starch | $(C_6H_{10}O_5)n$ | 9005-25-8 | Химийн бодисын агуулах | * | 0.00 | 0.00 | 0.00 |

Илгээсэн:
Ахлах инженер /А. Төгсжаргал/

Хянасан:
Химийн бодисын агуулах хариуцсан инженер

*Зураг 13.4.1. 2025 оны химийн бодисын зарцуулалтын тайлан*

## 13.5. Компанийн БОНЗ (ESG)-н гүйцэтгэл

“Энержи Ресурс” ХХК нь 2024 онд хэрэгжүүлсэн Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын бодлого, үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн үр дүнг ил тод, хариуцлагатайгаар олон нийтэд хүргэх зорилгоор БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн үр дүн, биелэлт, баримталж буй бодлого, зарчмууд болон гол шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж компанийн вэбсайт, фейсбүүк хуудсанд байршуулан мэдээлэв.

Тайлангийн мэдээллийг Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын стандарт, уул уурхайн салбарт мөрдөгдөж буй БОНЗ-ын чиглэлийн шилдэг туршлага, мөн Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан БОНЗ болон тогтвортой байдлын тайлагналын удирдамжид нийцүүлэн бэлтгэн хүргэж ажиллав.




Зураг 13.5.1. Тогтвортой Хөгжлийн тайлан 2024

2024 оны Тогтвортой Хөгжлийн Тайланд Байгаль орчны чиглэлээр дараах агуулга бүхий мэдээллийг багтаан, мэдээлэв.

- Нөхөн сэргээлт ба биологийн олон янз байдал
- Ногоон байгууламж ба ойжуулалт
- Агаарын чанар
- Хог хаягдлын менежмент
- Усны менежмент

- Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт
- Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал







Зураг 13.5.2. Тогтвортой хөгжлийн тайлан, Байгаль орчны мэдээлэл

## 13.6. Компанийн байгаль орчны ажлын гүйцэтгэл

“Энержи Ресурс” ХХК нь олон нийтийн сүлжээнд “Энержи Ресурс – Хөгжлийн Төлөө” Фэйсбүүк хуудсаараа дамжуулан “Ухаа Худаг” төслийн хүрээнд байгаль орчны холбогдолтой хэрэгжиж буй ажлууд болон мэдээллийг олон нийт болон сонирхогч талуудад 2012 оноос хойш мэдээлж байна. 2025 оны 1 сарын 1-нээс 10 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 7 пост, 6 бичлэг нийтлэн танилцуулсан байна.










Зураг 13.6.1. Энержи Ресурс – Хөгжлий төлөө фейж хуудсанд байгаль орчны талаар тавигдсан мэдээлэл

Мөн энэ жил бусад мэдээллийн сувгууд болох [www.mining.mn](http://www.mining.mn), [www.zarig.mn](http://www.zarig.mn), [www.mass.mn](http://www.mass.mn), [www.zuv.mn](http://www.zuv.mn) болон [www.eguur.mn](http://www.eguur.mn) - ийн вэбсайтууд болон бусад фейсбүүк хуудсуудаар дамжуулан зүлэгжүүлсэн талбайн мэдээллийг хүргүүлж байна.

## 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн зардал **324,000,000** төгрөг бөгөөд түүний барьцаа болох **162,00,000** төгрөгийг Төрийн сангийн тусгай дансанд Энержи Ресурс компаниас байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний барьцаа болгон байршуулсан. 2025 оны зарцуулалтын задаргааг доорх хүснэгтээр харуулав.

| № | Хийгдэх ажлын чиглэл | Хийгдсэн ажлын тодорхойлолт | Зарцуулалт, мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв | Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 67,000.00 |
| | | Нүүрс баяжуулах үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 16,000.00 |
| | | Цахилгаан станцын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 12,360.00 |
| | | Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 23,100.00 |
| | | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үеийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | - |
| 2 | Нөхөн сэргээлт | Биологийн нөхөн сэргээлт | 90,000.00 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа | Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд тооройн төгөл хашиж хамгаалах, ургамлын судалгаа хийх | 29,000.00 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор | Нөлөөллийн бүсийн малчид болон сумдын иргэдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх | ОНХ-н зардлаас |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах | Цогтцэций сумын соёлын биет бус өв болох Говь шанхын уртын дууг таниулах, сэргээн алдаршуулах | Нийгмийн хариуцлагын зардлаас |
| 6 | Осол эрсдэлийн менежмент | Химийн бодисын хадгалалт ашиглалтаас үүсэх эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт | 13,000.00 |
| 7 | Хог хаягдлын менежмент | Хог хаягдлын ангилан ялгалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах, | 17,800.00 |
| 8 | Удирдлага зохион байгуулалт | Байгаль орчны менежмент тогтолцооны аудит, Байгаль орчны ажлын байрны үзлэг, сургалт | 22,000.00 |
| 9 | Орчны хяналт шинжилгээ | Усны хяналт шинжилгээ | 9,680.00 |
| | | Агаарын чанарын хяналт шинжилгээ | 21,700.00 |
| | | Хөрсний хяналт шинжилгээ | 1,920.0 |
| | | Ургамлан бүрхэвч ба амьтны аймгийн судалгаа | 17,000.00 |
| 10 | Олон нийтэд тайлагнах | Мониторингийн ажилд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх | 7,400.00 |
| | **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | **330,960.00** |